



**Хууль зүй, дотоод
хэргийн яам**



**“Шүүх, эрх зүйн
шинэчлэлт” төсөл**

ТӨРИЙН ОНОЛ

Гарын авлага

Зөвлөх: Н.Лүндэндорж
Боловсруулсан: Ч.Өнөрбаяр
М.Ариунаа
Д.Отгонтуяа

*Энэхүү гарын авлагыг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас
хэрэгжүүлж буй Дэлхийн банкны “Шүүх, эрх зүйн шинэчлэлт”
төслийн хүрээнд боловсруулав.*

Улаанбаатар
2007

DDC
342'023
Т-594

Төрийн онол
Гарын авлага

Хөтөлбөр боловсруулсан:

Зөвлөх: **Н.Лүндэндорж** *Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор*

Боловсруулсан: **Х.Тэмүүжин** *Магистр (LLM)*

Гарын авлага боловсруулсан:

Зөвлөх: **Н.Лүндэндорж** *Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор*

Редактор: **Ч. Өнөрбаяр** *(LLM)*

Багийн гишүүд:

Ч.Өнөрбаяр *Магистр (LLM)*

М.Ариунаа *Магистр (LLM)*

Д.Отгонтуяа *Магистр (LLM)*

Хэвлэлийн хэмжээ: 17.5 х.х
Номын хэмжээ: 70х100/16
Хэвлэсэн газар: “Содпресс” ХХК

ISBN: 97-99929-54-29-9



“ШҮҮХ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛТ” ТӨСЛИЙН ТУХАЙ

Хууль зүйн сургуулийн багш, оюутнуудад



*“Шүүх, эрх зүйн шинэчлэлт”
төслийн зохицуулагч
Д.ОЮУНЧИМЭГ*

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төсөл 2002 оноос хэрэгжээд дуусах шатандаа орж байна.

Энэ төслийн хүрээнд эрх зүйн дээд боловсролыг чанаржуулах чиглэлээр эхний шатны зарим ажлыг хийж дуусгалаа. Эдгээр ажлын үр дүн нь таны гар дээр очиж буй энэ гарын авлага юм. Бид энэ ажлыг зохион байгуулахдаа гадаадын зөвлөх гэхээсээ монголчууд бидний оюун ухаанд тулгуурлаж, дотоодын эрдэмтэн, багш нараар хийлгэсэн юм. Энэ номыг бүтээхэд хууль зүйн сургуулиудаас нэр хүндтэй, туршлагатай ахмад багш, нөгөө талаар идэвхтэй, санаачлагатай, хийж бүтээе, өөрийгөө боловсруулъя гэсэн эрмэлзэлтэй залуу багш нарыг баг болгон оролцуулсан юм. Энэ гарын авлагыг бүтээх явцад багш нар хамтран ажиллаж, бие биенээсээ харилцан суралцаж, цаашид судалгаа шинжилгээний ажил, эрх зүйн сургалтын шинэчлэлтийг хамтран хийхэд үр дүнд хүрнэ гэдгийг харуулсан болно.

Оюутанд зориулсан цогц гарын авлага (хичээлийн хөтөлбөр, тойм лекц) нь Монголд анх удаагаа гарч байгаа билээ. Оюутны гарын авлага нь тэдний судалж буй хичээлд хандах хандлагыг өөрчилж, “бэлэнчлэх” сэтгэлгээнээс ангижруулахад хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна.

Төсөл бол тодорхой хугацаанд хэрэгжээд дуусдаг жамтай. Харин төсөл хэрэгжүүлэх явцад танилцсан, хамтарч ажилласан багш нар цаашдаа өөрсдийгөө боловсруулах, сургалтынхаа арга барил, чанарыг сайжруулах чиглэлээр хийж эхэлсэн ажлаа үргэлжлүүлнэ гэдэгт найдаж байна. Хичээлийн хөтөлбөр, оюутны гарын авлага бүтээхэд оролцсон 100 орчим эрдэмтэн, багш нар болон энэ ажлыг гардан зохион байгуулж, уялдаа холбоог нь хангах талаар идэвх зүтгэлтэй ажилласан төслийн ажилтан Б.Сарантуяад талархал илэрхийлье.

Үр дүнд чиглэсэн сургалтын хөтөлбөр



*“Шүүх, эрх зүйн шинэчлэлт”
төслийн зөвлөх
У.ТУЯА*

Оюутан залуус та бүхэнд их мэдлэгийг хуримтлуулах нь чухал уу, харин уг мэдлэгээ ашиглах чадвар, мэргэжлийн үнэт зүйлсийг эзэмших нь чухал уу. Аль замыг чухал гэж сонгосноос таны суралцах арга барил, цаашлаад сургалтад хандах хандлага тань тодорхойлогддог байна. Сургалтын хөтөлбөр, гарын авлага боловсруулахад ч энэ хоёр талаас авч үзэх хэрэгтэй болдог.

Бид 2003 оноос Дэлхийн банкны “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслийн “Хууль зүйн бакалаврын боловсролыг сайжруулах” дэд төслийн хүрээнд энэхүү сургалтын хөтөлбөр, гарын авлагыг боловсруулахдаа дараах шаардлагыг харгалзсан бөгөөд оюутан таныг ч энэ тухай мэдэж сургалтын хөтөлбөр, гарын авлагаа ашиглахыг зөвлөж байна. Үүнд:

- ❖ Оюутан ямар зорилгоор уг хичээлийг судалж, ямар үр дүнд хүрэхээ мэдэж байх ёстой.
- ❖ Мэргэжлийн мэдлэг нь мэргэжлийн ур чадвар болон хөгжиж, үнэт зүйл болон төлөвшсөн байх нь чухал. Иймээс мэдээлэл болгоныг боловсруулах бие даалтын ажил оюутанд хэрэгтэй.

БАГИЙН ТАНИЛЦУУЛГА



Нанзаадоржийн Лүндэндорж

Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D), профессор

Төрийн онол, төрийн эрх зүй, монголын төр ёс, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн асуудлаар судалгаа хийдэг. 50 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл гадаад, дотоодын мэргэжлийн сэтгүүлд нийтлүүлсэн. Нэг сэдэвт зохиол, их, дээд сургуулийн сурах бичиг, гарын авлага хэд хэдийг бичиж хэвлүүлсэн байна.



Чадраабалын Өнөрбаяр Хууль зүйн магистр

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Эрх зүй, төрийн онол, түүхийн тэнхимийн багш, докторант.

Нэг сэдэвт зохиол нэг, эрдэм шинжилгээний өгүүлэл 20 орчмыг нийтлүүлсэн. К.Осаквегийн “Харьцуулсан эрх зүй судлал” номын орчуулгын редактороор ажилласан. Найжел Ашфордын “Чөлөөт нийгмийн үндсэн зарчмууд” номыг хамтран орчуулсан.

Төр, эрх зүй, улс төрийн онол, эрх зүйн философи, Монгол улс дахь үндсэн хуульт ёсны хөгжлийн асуудлаар судалгааны ажил эрхэлдэг.



Мөнхдалайн Ариунаа Хууль зүйн магистр

Отгон тэнгэр ИС-ийн ХЗС-ийн ОУЭЗ-н тэнхимийн багш, Отгон тэнгэр ИС-ийн ХЗС-ийн хууль зүйн клиник сургалтын төвийн захирал. Ном, гарын авлага бш, өгүүлэл, нийлэл 15 орчим

Төр, эрх зүйн онол, Харьцуулсан эрх зүйн чиглэлээр мэргэшсэн



Дагдангийн Отгонтуяа. Хууль зүйн магистр

Шихихутаг ХЗДС-ийн багш. Эрх зүйн онол, төрийн онолын чиглэлээр эрдэм шинжилгээний 5 өгүүлэл нийтлүүлж. “Эрх зүйн философи” сурах бичгийн хамтран зохиогчоор ажилласан.

Төрийн онол, эрх зүйн философийн чиглэлээр судалгааны ажил хийж байна.



ӨМНӨХ ҮГ

Эрх зүйн шинжлэх ухааны тулгуур үндэс нь хүний суурь эрх, түүнийг хамгаалж, хэрэгжүүлэхэд чиглэсэн эрх зүйн хэм хэмжээнээс бүрэлддэг. Хүний суурь эрхийн хувь заяа, эрх зүйн хэм хэмжээний агуулга, мөн чанар бидний төр гэж нэрлээд байгаа тэр зүйлээс шууд хамаардгийг бид бас мэднэ. Тэрхүү хамаарал, түүний давтамжийг танин мэдэх нь эрх зүйч мэргэжлийн “цагаан толгой” мөн. Энэ л шаардлагаар эрх зүйн сургалтад төрийг өрнө, дорногүй янз бүрийн нэр, хаягийн дор судалсаар иржээ.

Манай улсад 90-д оныг хүртэл “Төр, эрх зүйн онол” гэсэн нэгдсэн судлагдахууны хүрээнд төрийг ангийн онолын үүднээс судалж байв. Октябрийн хувьсгалаас өмнөх Орос оронд болон гадаадын эрх зүй судлалд “Төр, эрх зүйн онол” гэсэн нэгдмэл ойлголт, судлагдахуун байгаагүй. Одоо ч ОХУ-ыг эс тооцвол байхгүй. ЗХУ дахь сталинизмын үеийн ангийн болон хүчирхийллийн онолын нөлөөгөөр төр бол эрх зүйг бүтээдэг гэсэн үзлийн үүднээс “Төр, эрх зүйн онол” нэгдмэл, нэг судлагдахуун байх ёстой гэсэн номлол бий болсон түүхтэй. Энэ онолд төрийг нэг ангиас нөгөө ангиа дарангуйлах машин гэж үзнэ. Эрх зүйг төрөөс тогтоодог, төрийн тушаал, зааврын нийлбэр гэнэ. Үүний улмаас төр, эрх зүйн онол нэгдмэл гэж үзэж байлаа. Өдгөө төрийг ч, эрх зүйг ч тэгж үзэх бололцоогүй болжээ.

Төр тогтоодоггүй, төрөөс хэрэгжилтийг нь гуйдаггүй, аяндаа хэрэгжих статустай эрх орших төдийгүй, тэр нь эрх зүйн аливаа хэм хэмжээний үндэс, төрийг захирах хүч гэсэн үзэл санаа аль хэдийн бий болжээ. Төрийг ангийн хүчирхийллийн хэрэгсэл бус, харин иргэдийн эрх, эрх чөлөөг хамгаалдаг, эрх зүй болон эрх зүйн хэмжээгээр хязгаарлагдаж байдаг, улсын доторх улс төрийн эрх мэдлийн тогтолцоо гэж үзсээр иржээ.

XX сүүлчээр ОХУ-ын болон манай зарим судлаачид “Төр, эрх зүйн онол”-ыг “Эрх зүй, төрийн онол” гэж эрх зүйг төрийн өмнө оруулан хэрэглэж байв. Энэ нь сталинизмын үеийн хүчээр нэгтгэсэн зохиомол нэгдлийн гажиг согоогоос гарах гэсэн оролдлогын илрэл, нөгөө талаас Rule of Law-ийн зарчмыг хүлээн авах санаатай холбоотой байсан бизээ. Гэвч нэмэгдэхүүний байрыг солиход нийлбэрийн чанар өөрчлөгддөггүй гэсэнтэй утга нэг юм. Харин 90-ээд оны эхээр МУИС-д төр, эрх зүйн онолын салгасан нь санамсаргүй бөгөөд зүгээр нэг механик хуваалт биш, харин олон улсын жигшийг дагасан, эрх зүйн болон төрийн мөн чанарыг ангийн болон марксист бус агуулгаар авч үзэх гэсэн зарчмын өөр утга агуулгатай юм. Ингэж “Төрийн онол” гэсэн судлагдахуун монголд үүссэн байна. Төрийн онол гэсэн судлагдахуун өдгөө эрх зүй тогтоодог субъект гэсэн хуучин номлолоосоо салж, Үндсэн хуулийн эрх зүйн “толгой” судлагдахуун болж хөгжих тал руугаа цаашид явах учиртай. Энэ гарын авлагыг энэ үйлст нэмэр болно гэж найдаж байна.

Дэлхийн банкны санхүүжилтээр Монгол улсад хэрэгжиж байгаа “Шүүх, эрх зүйн шинэчлэлт” төслөөс санаачлан, судлаачдын хүч, бололцоонд тулгуурлан хийсэн хичээлийн шинэ хөтөлбөрийг нэг мөр хэрэгжүүлэхэд залуу судлаачдын боловсруулсан энэ гарын авлага бас тус нэмэр болох нь эргэлзээгүй.

*МУИС-ийн тэргүүлэх профессор,
Эрх зүйн шинжлэх ухааны доктор (JSD),
Философийн доктор (PhD),*

Н.Лүндэндорж

ГАРЧИГ

ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	3
БАГИЙН ТАНИЛЦУУЛГА	4
ӨМНӨХ ҮГ	5
ТӨРИЙН ОНОЛ ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР	
1. Төрийн онол хичээлийн тодорхойлолт	7
2. Төрийн онол хичээлийн агуулга	10
3. Төрийн онол хичээлийн заах арга зүй	26
4. Төрийн онол хичээлийн үнэлгээ	35
ТӨРИЙН ОНОЛ ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА	
I бүлэг. ЕРӨНХИЙ ОНОЛ	
1. Төрийг судлах арга зүй	38
2. Төрийн тухай төсөөллийн хувьсгал, хөгжил	40
3. Төрийн тодорхойлох орчин үеийн хандлагууд	42
Семинар 1. Төр байгаа зүйл үү? Эсхүл байх ёстой зүйл үү?	44
4. Төрийн шинж эрх мэдэл, зорилго	44
Семинар 2. Нутаг дэвсгэр, хүн ам, нийтлэг засаг яагаад чухал вэ?	46
5. Төр үүсэх, үгүй болох үндэслэл	47
6. Иргэний нийгэм төрийн суурь болох нь	49
Семинар 3. Иргэний нийгэм төрийн харилцаа	51
7. Төрийн удирдлагын хэлбэр	52
Семинар 4. Бүгд найрамдах улс түүний төрөл	54
8. Төрийн байгууламжийн хэлбэр	55
9. Төрийн дэглэм	56
10. Төрийн байгууллага, түүний чиг үүрэг	58
Семинар 5. Төрийн орон нутгийн байгууллага	60
II. бүлэг. ТУСГАЙ ОНОЛ	
11. Төрийн эрх мэдэл хуваарилах онол	62
12. Эрх зүйт төр, түүний үндсэн элементүүд	64
Семинар 6. Rule of law & rule law	65
13. Социал төр, түүний үндсэн зарчмууд	66
Семинар 7. Эрх зүйт ба социал төр	68
14. Монгол төрийн хөгжил	69
Семинар 8. Монголын төрийн хөгжил	71
15. Төрийн хөгжил түгээмэл хандлага	72
Ашигласан материал	74



ТӨРИЙН ОНОЛ ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨР

1. Төрийн онол хичээлийн тодорхойлолт

Төрийн онол хичээлийн танилцуулга

Хичээлийн нэр: Төрийн онол

Индекс:

Кредит цаг: 2

Нийг цаг: 40 /лекц-24, семинар-16/

Семестр: I

Хичээлийн зорилго:

Төрийн онол хичээлд суралцсанаар оюутан: төр, түүний үүсэл, хөгжлийн нийтлэг зүй тогтол, онол хандлагыг судлан мэдэж, Хууль зүйн шинжлэх ухаанд тулгуурлан орчин үеийн үндсэн хуульт төрийн талаархи суурь мэдлэгийг эзэмших; ардчилал, эрх зүйт ёс, нээлттэй нийгэм, иргэний эрхийн үүднээс төрд хандах арга зүй, чадвартай болох; төртэй холбоотой нийгмийн үзэгдлүүдэд онолын үндэслэлтэй үнэлгээ дүгнэлт өгөх хандлагыг өөртөө төлөвшүүлнэ.

Агуулгын тодорхойлолт:

Төрийн онол хичээлээр төрийн мөн чанар, түүхэн хэв маяг, чиг үүрэг, хөгжлийн ерөнхий зүй тогтол, Үндсэн хуульт ардчиллын үе дэх уламжлалт төрийн хувьсал өөрчлөлт, онол арга зүйн зөрөө, даяаршлын нөлөөлөл зэргийг судлана. Үүнд: төрийн үүсэл хөгжлийн тухай онол сургаалууд, тэр дундаа нийгмийн гэрээний онол, төрийн болон ард түмний бүрэн эрхт байдал, уламжлалт болон орчин үеийн төрийн шинж, ангилал, хэлбэр ардчилсан болон ардчилсан бус төрийн хэтийн төлөв, уламжлалт нийгэм дэх төрийн чиг үүрэг болон либераль нийгэм дэх Үндсэн хуульт төрийн чиг үүргийн ялгаа, эрх зүйт ёс /Rule of law/, үндсэн хуульт ёсны үүднээс төрд хандах арга зүй, даяаршлын нөлөө улс үндэстний өөрчлөлт зэргийг авч үзнэ.

Залгамж холбоо:

Төрийн онол хичээл нь Үндсэн хуулийн эрх зүйн суурь курс хичээл бөгөөд Эрх зүйн онол, Монголын төрт ёсны түүхэн уламжлалт хичээлүүдтэй зэрэгцэн судлагдана. Агуулга нь Эрх зүйн философи, Харьцуулсан эрх зүй хичээлээр гүнзгийрч Нийтийн эрх зүйн хичээлүүдээр задарна.

Үнэлгээ:

Хичээлийн явцад оюутан үнэлгээний онооны 60 хувийг идэвхи оролцоо /илтгэл хэлэлцүүлэх, семинар удирдах, мэтгэлцээн зохиох/, бие даалтын ажил /тус бүр нь 500 үгтэй 3 доошгүй эссе/, явцын шалгалт /20 хувь/-аар цуглуулна. Эцсийн шалгалтаар үнэлгээний онооны 40 хувийг авна.

Зорилтууд:

- ❖ Төрийн ерөнхий болон тусгай онолын суурь мэдлэгийг эзэмших
- ❖ Хууль зүйн шинжлэх ухаан дахь төрийн онолын үндсэн нэр томъёонуудтай танилцах
- ❖ Төр, эрх зүйн ойлголтууд, улс төр, нийгмийн асуудалд Үндсэн хуульт төрийн суурь зарчмууд, ардчилал, эрх зүйт төрийн үүднээс дүн шинжилгээ

хийх чадвартай болох

- ▲ Төрийн талаархи өөрийн мэдлэг, итгэл үнэмшлийг бүтээж, түүнд бодитой хандах хандлага төлөвшүүлэх
- ▲ Ардчилсан, нээлттэй, зах зээлийн нийгмийн амьдралд төрийн гүйцэтгэх үүгийг танин мэдэх, Төрийн чиг үүргийг иргэний эрхийн үүднээс тайлбарлах арга зүйд суралцах
- ▲ Тодорхой байр суурь илэрхийлэх, хамгаалах, /амаар, бичгээр, билэг тэмдгээр.../ онолын үндэслэлтэй мэтгэлцэх, ойлголцолд хүрэх гэх мэт мэдлэг, чадварыг эзэмших.

Төрийн онол хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө, цаг хуваарилалт

1.	I. Ерөнхий онол	Лекцийн сэдэв	Цаг	Семинарын сэдэв	Цаг
		1. Төрийг судлах арга зүй	2	1. Байгаа болон байх ёстой төрийн тухай 2. Төрийн тухай түгээмэл тодорхойлолт бий болоогүйн учир шалтгаан 3. Гадаад хэлбэрээр тодорхойлохоос институтчилэх аргад шилжсэн нь	2
		2. Төрийн тухай төсөөллийн хувьсал, хөгжил			
		3. Төрийг тодорхойлох орчин үеийн хандагууд	2	1. Төр гэсэн ойлголтын агуулга 2. Төрийг тодорхойлох түүхэн оролдлогууд 3. Төр социологийн утгаар 4. Төр хууль зүйн утгаар	2
		4. Төрийн шинж, эрх мэдэл, зорилго	2	5. Хүн ам, нутаг дэвсгэр, нийтлэг эрх мэдэл 6. Төрийн эрх мэдлийн онцлог	
		5. Төр үүсэх ба үгүй болох үндэслэл 6. Иргэний нийгэм төрийн суурь болох нь	2	1. Төр анх үүсэх 2. Төр үүсэх хууль зүйн утга /de facto, de jure/ 3. Төр өөрчлөгдөх, үгүй болох нөхцөл, шалтгаан 4. Иргэний нийгэм төрийн хянах нь 5. Иргэний нийгэм төрийн харилцаа 6. Иргэний нийгэм бүтцээрээ дарангуйллын тогтолцоог хаах нь	2
		7. Төрийн удирдлагын хэлбэр	2	1. Хаант төр ба БНУ-ын ялгаа 2. БНУ, түүний төрөл	2
		8. Холбооны болон нэгдмэл улс	2	3. Холбооны болон нэгдмэл улсын нийтлэг болон ялгаатай тал	
		9. Ардчилсан ба ардчилсан бус дэглэм	2	1. Ардчилсан болон ардчилсан бус дэглэмийн үндсэн шинжүүд 2. Төрийн байгууллага ба механизм, онцлог 3. Төрийн төв байгууллага: Парламент ЗГ, Шүүх	2
		10. Төрийн байгууллага ба түүний чиг үүрэг		4. Төрийн орон нутгийн байгууллага	2



2.	II. Тусгай онол	11. Төрийнэрх мэдэл хуваарилах онол	2	1. Төрийн эрх мэдэл хуваарилах онолын үндсэн зорилго 2. Эрх мэдэл хуваарилах онол дахь өнөөгийн асуудал 3. Rule of law ба Rule by law 4. Эрх зүйт төрийн үндсэн шинжүүд	
		12. Эрх зүйт төр, түүний үндсэн элементүүд	2		
		13. Социал төр, түүний үндсэн зарчмууд	2	1. Эрх зүйт ба социал төр 2. Социал төрийн үндсэн зарчим	
		14. Монголын төрийн хөгжил	2	1. Монголын төрийн үүслийн талаархи түүхэн маргаан 2. Хөгжлийн түүхэн үеүд	
		III. Дүгнэлт хэсэг: Төрийн хөгжил дэх түгээмэл хандлага	2	3. Ардчилсан төрийн хөгжлийн үйл явц 4. Даяршил ба дангааршил 5. Уламжлалт төрөөс Үндсэн хуульт төрд шилжих хандлага	
НИЙТ			24		16

2. Төрийн онол хичээлийн агуулга

1 бүлэг. ЕРӨНХИЙ ОНОЛ

Бүлгийн зорилго: Төрийн ерөнхий ойлголт, үүсэл хөгжлийн нийтлэг зүй тогтолыг танин мэдэж, төрийн тухай өөрийн мэдлэгийг бүтээнэ

1. Төрийг судлах арга зүй

Зорилго: Төрийг судлах онол, арга зүйд суралцаж, эрх зүйн чиг баримжаа, хандлага төлөвшөнө.



Нэр томъёо

- ❖ Аргазүй
- ❖ Субъектив, объектив эрх
- ❖ Jus
- ❖ Lex Онол
- ❖ Ерөнхий онол
- ❖ Тусгай онол
- ❖ Байгалийн засаг
- ❖ Байх ёстой төр
- ❖ Байгаа төр



Сэдвийн агуулга

Төрийн онолыг судлах шаардлага, ач холбогдол. Төрийг судлах нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухааны арга зүй, тэдгээрийн ялгаа. Төрийг судлах хууль зүйн шинжлэх ухааны арга зүй, түүний онцлог.

Төрийг бодит факт гэж судлахын зэрэгцээ байх ёстой зүйлийн үүднээс судлах нь. Байгаа болон байх ёстой зүйлийн хооронд суурь хэм хэмжээ /Basic norm/ үүсэх үндэслэл. Байх ёстой зүйл ба үндсэн хууль.

Төрийн онолын тогтолцоо, судлагдахуун, ерөнхий болон тусгай онолын нэгдэл.



Хяналтын асуулт

- Субъектив эрх зүйн агуулгад жам ёсны эрхээс гадна өөр хэм хэмжээ багтах уу? Түүнийг та юу гэж нэрлэх вэ?
- Төр, түүний байгууллагаас гадуур эрх зүйн хэм хэмжээ үүсэх үү? Үүний учир шалтгааныг тайлбарлана уу?
- Төрийг байгаа зүйлийн болон байх ёстой зүйлийн үүднээс судлахын ялгааг тунгаан бодно уу? Бид аль талаас голчлон судалдаг бол?
- Монгол улсын төрийн үйл ажиллагаа Үндсэн хуулийн үзэл баримтлал, хэм хэмжээнд нийцэж буй эсэхийг судлах нь төрийг судлах ямар арга зүй вэ?
- Төрийн тусгай болон ерөнхий онолууд хоорондоо ямар уялдаа холбоотой вэ? Төрийн онолыг ийнхүү ангилгахын ач холбогдол юу вэ?



Эх сурвалж

1. Төрийн онол. Н.Лүндэндорж. УБ., 2006.1-5 дахь тал.
2. Төрийн ерөнхий онол. Ц.Сарантуяа. УБ., 1998.
3. Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага.
4. Н.Лүндэндорж. УБ., 002.
5. Улс төрийн философийн удиртгал. Ж.Вольф. УБ., 2002
6. Либертарианизм. Д.Боаз. УБ., 2005.

2. Төрийн тухай төсөөллийн хувьсал хөгжил

Зорилго: Төрийг тодорхойлох түүхэн оролдлогууд, тэдгээрийн мөн чанар, “төр” гэсэн нэршлийн гарал үүсэл, хувьсал, өөрчлөлтийг танин мэдэж, төрийн уламжлалт ойлголтуудтай танилцана.



Нэр томъёо

- ❖ Polis
- ❖ Civitas
- ❖ Imperium
- ❖ Regnum
- ❖ State
- ❖ Demokrats
- ❖ Respublec
- ❖ Нийгэм
- ❖ Нутаг дэвсгэр
- ❖ Хүн ам
- ❖ Нийтлэг засаг
- ❖ Улс
- ❖ Үндэстэн
- ❖ Хяналтын асуултууд



Сэдвийн агуулга

Төрийг тодорхойлох түүхэн оролдлогууд, тэдгээрийн мөн чанар: Гадаад дүр төрхөөс институтчилэн тодорхойлох /Аристотелээс Боден хүртэл/ хандлагад шилжсэн нь. Төрийн тухай түгээмэл тодорхойлолт бий болоогүйн шалтгаан.

Төр” гэсэн нэршлийн гарал, үүсэл, хөгжил, хувьсал /Оршин суугч, ард түмэн, газар нутаг, эзэн-төрийн тэргүүн, улс-улс гүрэн, төр-ёс, хууль цааз г.м./

Төрийг тодорхойлох хандлага

Объектив арга: төр бол факт, төр бол төлөв байдал, төр бол ард түмэн, төр бол эрх мэдэл-засаглагч, засгийн газар г.м.

Субъектив арга: төр бол нийгмийн үзэгдэл, төр бол оюун ухаан, ёс суртахууны организм, төр бол хамт олон-холбооны нэгдэл, төр бол эрх зүйн үзэгдэл г.м.



Хяналтын асуулт

- Төрийн тухай тогтсон томъёолол бий болгож болох уу? Тогтсон томъёолол гэж юу вэ? Өөрийн хариултын үндэслэлийг эргэцүүлэн бодно уу?
- Төрийг гадаад дүр төрхөөр болон институтчилэн тодорхойлохын ялгаа юунд орших вэ? Танд аль нь илүү онвчтой санагдаж байна вэ? Яагаад.
- Таны бодлоор төр гэж юу вэ? Таныхаар төрийг тодорхойлох 2 хандлагын аль нь илүү үндэслэлтэй вэ? Яагаад.



Эх сурвалж

1. Улс төр. Аристотель. УБ., 2004.
2. Төрийн онол. Н.Лүндэндорж. УБ., 2006. 6-23 дахь тал.
3. Общее учение о государстве. Еллинек Г. Снб., 1903.
4. The Western Idea of law. S.C.Smith, Darid N. Weisstub. Buttermorths. 1983.

3. Төрийг тодорхойлох орчин үеийн хандлагууд /хууль зүйн болоод социологийн/

Зорилго: Төрийг тодорхойлох орчин үеийн үндсэн хандлагуудтай таншшаж, төр, нийгмийн үзэгдэлд онолын дүн шинжилгээ хийх арга зүйд суралцана.



Нэр томъёо

- ❖ Марксист хандлага
- ❖ Марксист бус хандлага
- ❖ Легист хандлага
- ❖ Rule by law
- ❖ Rule of law



Сэдвийн агуулга

Төрийн тухай ойлголтын түгээмэл агуулга: Улс төрийн нийтлэг эрх мэдлийг хэрэгжүүлэх зохион байгуулалт.

Төр олон талт үзэгдэл болох нь. Төрийг тодорхойлох хандлагууд /улс төрийн, бүтцийн, чиг үүргийн, кибернетик г.м/.

Социологийн хандлага: Улс төрийн нийтлэг эрх мэдлийг дангаар эзэрхэх нь төрийн гол эх сурвалж гэж үзэх үндэслэл.

Хууль зүйн буюу легист хандлага: Төр-эрх зүйн үзэгдэл гэх үндэслэл. Төр улс төрийн нийтлэг эрх мэдлийг тодорхой нутаг дэвсгэр, хүн амын хүрээнд хэрэгжүүлдэг эрх зүйн дэг журмын хууль зүйн хэлбэр болох нь.

Гол зарчим нь төрийн эрх мэдэл хуулийг тогтоодоггүй, хуулиуд төрийн эрх мэдлийг тогтоодог, хуулиуд нь хүний эрхэд үндэслэдэг гэж үзэхэд тулгуурлана.



Хяналтын асуулт

- М.Вебер төрийг “Хууль ёсны хүчийг бүрэн эзэрхсэн нийгмийн дотор оршиж буй улс төрийн эрх мэдлийн зохион байгуулалт” гэж тодорхойлсон. Энэ тодорхойлолттой санал нэг байна уу? Үндэслэлээ тайлбарлана уу?
- Төрийг тодорхойлох социологийн болон хууль зүйн хандлагын гол ялгааг дахин нэг эрэгцүүлэн бодно уу?



Эх сурвалж

1. Төрийн онол. Н.Лүндэндорж. УБ., 2006.18-23 дахь тал.
2. Төр ба эрх зүй. С.САпексеев. УБ., 2004.
3. Общее учение о государстве. Еллинек Г. Спб., 1903.
4. Либертарианизм. Д.Боаз. УБ., 2005.
5. Улс төр бол мэргэжил мөн. Шинжлэх ухаан бол мэргэшил мөн. М.Вебер УБ., 2000.

4. Төрийн шинж, эрх мэдэл, зорилго

Зорилго: Төрийн шинж, эрх мэдэл, тэдгээрийн онцлог, төрийн зорилгыг танин мэднэ.



Нэр томъёо

- ❖ Хүн ам
- ❖ Газар нутаг
- ❖ Нийтлэг засаг
- ❖ Бүрэн эрх
- ❖ Засаг
- ❖ Чиг үүрэг
- ❖ Зорилго
- ❖ Зорилт



Сэдвийн агуулга

Төрийг шинжээр нь тодорхойлох онол, үзэл баримтлал, нутаг дэвсгэр, хүн ам, нийтлэг эрх мэдлийн тухай ойлголт. Эрх мэдлийн тухай ерөнхий ойлголт, төр ба нийтлэг эрх мэдэл, хүсэл зориг, хүсэл зоргийг хэрэгжүүлэх арга, эрх мэдлийн ангилал, төрийн эрх мэдлийн эх сурвалж, төрийн эрх мэдлийн онцлогууд.

Төрийн эрх мэдлийн субъект. Төрийн зорилго, зорилт, чиг үүрэг. Төрийн зорилгын тухай онолууд /Аз жаргал элбэг баян амьдралыг цогцлуулах, Ёс суртахууны хэм хэмжээг хэрэгжүүлэх, Засаглагчийн зан суртахууны итгэл үнэмшил, төрөөс хувь хүнтэй харилцах хил хязгаарыг тогтоох, аюулгүй байдал, эрх чөлөөг эрх зүйгээр хамгаалах болон төрийн харьцангуй зорилгын онолууд/. Төрийн түгээмэл болон үндэсний зорилго.



Хяналтын асуулт

- Төрийн шинжийн нутаг дэвсгэр, хүн ам, нийтлэг эрх мэдэл нь гагцхүү төрд байх уу? Даяаршил төрийн эдгээр шинжид нөлөө үзүүлж байна уу? Жишээн дээр тайлбарлана уу?
- Агаарын дээд хилийг олон улсын эрх зүйд одоогоор нэг мөр тогтоосон уу?
- Хүн ам нь ард түмнээс өргөн агуулгатай гэж үзсэний шалтгаан нь юу вэ? Үндэслэлээ тайлбарлана уу
- Ф. Шершеневич эрх мэдэлд захирагдах үндэс нь захирагдагчийн айдас, итгэл гэсэн. Та үүнтэй санал нэг байна уу? Энэ тайлбараар орчин үеийн төрийн эрх мэдлийн сэтгэл зүйн шалтгааныг ойлгож болох уу?
- Таны бодлоор төрийн эрх мэдлийн эх сурвалжийн бүрэлдэхүүнд юу юуг оруулж болох вэ? Түүнийгээ Монгол улсын жишээн дээр авч үзнэ үү.
- Төрийн зорилго, зорилт, чиг үүргийг Монгол улсын жишээн дээр тодорхойлох оролдлого хийнэ үү.



Эх сурвалж

1. Төрийн онол. Н.Лүндэндорж. УБ., 2006. 37-48 дахь тал.
2. Общее учение о государстве. Еллинек Г. Спб., 1903.
3. Төрийн ерөнхий онол. Ц.Сарантуяа. УБ., 1998.
4. Государствоведение. Чиркин.В.Е. М., 1999.

5. Төр үүсэх ба үгүй болох үндэслэл

Зорилго: Төр үүсэх, үгүй болох ойлголт, байгалийн захиргаа, төрийн үүслийн талаарх онол, үзэл баримтлал, төрийн үүсэлд нөлөөлсөн түгээмэл хүчин зүйлтэй танилцаж, нийгмийн гэрээний онолоор 1992 оны Үндсэн хуульт төрийн үүслийг тайлбарлах арга зүйд суралцана.



Нэр томъёо

- ❖ Анархизм
- ❖ Эдийн засаг
- ❖ Хөдөлмөр
- ❖ Нийгмийн анги, давхарга
- ❖ Газрын эзэн
- ❖ Софистууд
- ❖ Байгалын захиргаа
- ❖ Иргэшил
- ❖ Патернализм
- ❖ Арьсны өнгөөр ялгаварлах үзэл
- ❖ Нийгмийн гэрээ
- ❖ Үндсэн хууль
- ❖ Үндсэн хуульт төр



Сэдвийн агуулга

Төрийн үүслийн тухай ойлголт: төр үүссэн түүхэн эхлэл, төр үүссэн гэж үзэх үүсмэл буюу хууль зүйн үндэслэл, de facto, de jure-гийн тухай ойлголт. Төр өөрчлөгдөх, үгүй болох, мөхөх, устах тухай ойлголт, тэдгээрийн ялгаа.

Төр үүсэх урьдчилсан нөхцөл: байгалийн захиргаанаас удирдагчийн, улмаар нийтийн захиргаанд шилжих нөхцөл.

Төрийн үүслийн талаархи монист болон плюралист хандлага, онол үзэл баримтлалууд.

Төрийн үүсэлд нөлөөлсөн түгээмэл хүчин зүйл: Экологи, антрапологи, нийгэм эдийн засаг, хүн ам зүй.



Хяналтын асуулт

- Төрийн үүслийг хууль зүйн хувьд авч үзнэ гэдэг нь түүхэн эхлэл буюу хэзээ яаж үүссэнийг авч үзэхгүй гэсэн хэрэг мөн үү? Та конститутив болон декларитив онолын алийг нь дэмжиж байна вэ? Яагаад.
- Байгалийн захиргааны үе гэж юу вэ? Төргүй бол хүмүүс хэрхэн амьдрах вэ? Төр үнэхээр зайлшгүй юу?
- “Хүн бол улс төрийн амьтан” гэж Аристотель хэлжээ. Энэ нь хүн - захирах захирагдах харилцаанд зайлшгүй орох тавилантай амьтан гэсэн үг үү?
- Орчин үед төрийн үүслийг нийгмийн гэрээний онолоор тайлбарлахын учир шалтгаан юу вэ?



Эх сурвалж

1. Төрийн онол. Н.Лүндэндорж. УБ., 2006.77-104 дэх тал.
2. Төрийн ерөнхий онол. Ц.Сарантуяа. УБ., 1998.
3. Service E. Origins of the State and Civilization. N.Y.: Norton, 1925
4. Общее учение о государстве. Еллинек Г. Спб., 1903.

6. Иргэний нийгэм төрийн суурь болох нь

Зорилго: Иргэний нийгмийн тухай ойлголт, иргэний нийгэм, төрийн харилцаа, Монгол улсын Үндсэн хууль дахь иргэний нийгмийн үзэл санаа, зарчимтай танилцаж, иргэний нийгэмд онолын үзэл баримтлалтай хандах хандлага төлөвшинө.



Нэр томъёо

- ❖ Хувийн өмч
- ❖ Хувийн ашиг сонирхол
- ❖ Нийтлэг ашиг сонирхол
- ❖ Иргэний нийгэм
- ❖ Улс төрийн нийгэм
- ❖ Үндсэн эрх

- ❖ Өөрөө удирдах ёс
- ❖ Хэвлэлийн эрх чөлөө
- ❖ Нээлттэй байх
- ❖ Олон ургалч үзэл
- ❖ Анархизм
- ❖ Тоталитаризм
- ❖ Улс төрийн плюрализм



Сэдвийн агуулга

Иргэний нийгэм, ойлголт, нэр томъёо, үзэл санаа, үндсэн зарчмууд. Иргэний нийгмийн институт, шинж, үйл ажиллагаа. Төрийн эрх мэдлийг хязгаарлах цорын ганц хүчирхэг механизм бол иргэний нийгэм гэх үндэслэл. Үндсэн хууль, хуулийг төрөөс өөрчилдөг нь.

Орчин үеийн иргэний нийгэм /эрх чөлөөний орчин, эрх зүйт, ардчилсан ёсны орчин, нээлттэй орчин, олон ургалч үзлийн орчин, өөрөө хөгжих механизм бүхий орчин/.

Иргэний нийгмийн үүслийн тухай үзэл баримтлал /жам ёсны төлөв, төртэй хамт үүссэн, хөрөнгөтний нийгэм хэзээ үүссэн тэнд иргэний нийгэм үүссэн/.

Иргэний нийгэм төрийн харилцаа, түүнд баримтлах зарчмууд /нэгдмэл, зөрчил бүхий сөрөг хүч, төрийн халдагаас хүний эрх, эрх чөлөөг хамгаалах институт, иргэдийн хүлээн зөвшөөрсөн хэмжээгээр төр орших, төрөөс дээгүүр хувь хүн, төрийн дур зоргыг хязгаарлагч/.

Монгол улсын Үндсэн хууль дахь иргэний нийгмийн үзэл санаа, зарчим /хувь хүний хараат бус байдал, үзэл бо дчоо чөл өөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, ажил мэрэгжлээ чөлөөтэй сонгох, үл ялгаварлагдах, хувийн өмч хөрөнгөтэй байх, дарангуйллыг хаах, мэдээллийн эрх чөлөө, өөрөө удирдах ёс г.м/.



Хяналтын асуулт

- Ж.Локк “Иргэний нийгэм төрийг нөхцөлдүүлнэ, иргэний нийгмийн үндэс өмч, хүмүүс өмчөө хамгаалах эрхийн дагуу төр улсыг байгуулдаг” гэж үзсэн. Энэ ямар утгатай вэ?
- Иргэний нийгмийг яагаад эрх чөлөөний орчин гэдэг вэ?
- Иргэний нийгэм бүтцээрээ дарангуйллыг хаадаг гэдэг нь юу гэсэн үг вэ? Үндэслэлийг нь дэлгэрүүлж хэлнэ үү?
- Монгол улсын Үндсэн хууль дахь иргэний нийгмийн үзэл санааг тайлбарлаж, зарим онцлох заалтыг тоочно уу?



Эх сурвалж

1. Төрийн онол. Н.Лүндэндорж. УБ., 2006. 105-124 дэх тал.
2. Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага. Н.Лүндэндорж. УБ., 2003.
3. Нийгмийн гэрээ ба улс төрийн зарчмууд. Ж.Руссо. УБ., 2002. IV бүлэг.



4. Философия права. В.Гегель. М., 1990.
5. Civic Society and Political Theory, The mit Press. Cambridge. Massachusetts and London. England. 1992.

7. Төрийн удирдлагын хэлбэр

Зорилго: Төрийн удирдлагын хэлбэр, ойлголт, хаант болон бүгд найрамдах улсын шинж, онцлогтой танилцана.



Нэр томъёо

- ❖ Хаант төр
- ❖ Бүгд найрамдах төр
- ❖ Ерөнхийлөгчийн бүгд найрамдах улс
- ❖ Парламентын бүгд найрамдах улс



Сэдвийн агуулга

Төрийн хэлбэрийн ойлголт, ангилал, удирдлагын хэлбэр.

Хаант төр: хэмжээгүй эрхт хаант засаг, хэмжээт эрхт хаант засаг, дуалист хаант засаг, парламентын хаант улс, Үндсэн хуульт хаант улс, сонгуулийн хаант улс.

Бүгд найрамдах төр: Бүгд найрамд улсын ойлголт, ерөнхийлөгчийн, парламентын, холимог бүгд найрамдах улс, нийтлэг болон ялгаатай тал. Төрийн удирдлагын хэлбэрийг сонгох үндэслэл, түүний объектив, субъектив тал.



Хяналтын асуулт

- “Бүгд найрамдах улс хаант улсаас илүүтэй ардчиллын суурь үнэт зүйлсийг хамгаалдаг” гэж үзэж болох уу? Үүнийг одоогийн улсуудын жишээн дээр эрэгцүүлэн бодоорой.
- Монгол улс парламентын засаглалыг чухам юуг үндэслэн сонгосон гэж та үзэж байна вэ?
- Ерөнхийлөгчийн бүгд найрамдах улсын хэлбэр ямар улсад илүүтэй тохирдог вэ? Яагаад.



Эх сурвалж

1. Төрийн онол. Н.Лүндэндорж. УБ., 2006. 149-160 дахь тал.
2. Төрийн ерөнхий онол. Ц.Сарантуяа. УБ., 1998.
3. Государственное управление зарубежных стран. С.В.Пронкин О.Е.Петрунина// Классический университетский учебник. М., 2004.

8. Холбооны болон нэгдмэл улс

Зорилго: Төрийн байгууламж, ойлголт, холбооны болон нэгдмэл улсын онцлог шинж, зарчимтай танилцана.



Нэр томъёо

- ❖ Төрүүдийн бусад холбоо.
- ❖ Төрийн байгууламж
- ❖ Холбооны улсын зарчим
- ❖ Нэгдмэл улсын зарчим
- ❖ Протекторат
- ❖ Уни
- ❖ Хувийн уни
- ❖ Бодит уни
- ❖ Импери



Сэдвийн агуулга

Төрийн байгууламжийн ойлголт, ангилал.

Холбооны улс: онцлог шинж, үндсэн зарчим, хандлага, ангилал /нутаг дэвсгэрийн холбооны улс, үндэсний холбооны улс, тусгаар улсуудын холбоо/.

Нэгдмэл улс: онцлог шинж, үндсэн зарчим, ангилал /энгийн нэгдмэл улс, нийлмэл нэгдмэл улс/.



Хяналтын асуулт

- Улс орнуудыг төрийн байгууламжийн хувьд “энгийн нэгдмэл”, “нийлмэл нэгдмэл” гэж ангилах болсон шалтгааныг тодорхой жишээн дээр онолын үндэслэлтэй тайлбарлана уу?
- “Холбооны улсын зарчим нь гагцхүү төв засгийн үйл ажиллагааг хязгаарлахад чиглэгддэг” гэдэгтэй санал нийлэх үү. Үндэслэлээ тайлбарлана уу?



Эх сурвалж

1. Төрийн онол. Н.Лүндэндорж. УБ., 2006. 161-166 дахь тал.
2. Общее учение о государстве. Еллинек Г. Спб., 1903.

9. Ардчилсан ба ардчилсан бус дэглэм

Зорилго: Ардчилсан ба ардчилсан бус дэглэмүүдийн ялгаа, онцлогтой танилцаж, ардчилалын үнэт зүйлс, зарчимд суралцан, төрийн үйл ажиллагаанд ардчиллын үзүүлэлт, аргачлалаар үнэлэлт, дүгнэлт хийх чадварт суралцана.



Нэр томъёо

- ❖ Ардчилал
- ❖ Фашизм
- ❖ Социализм
- ❖ Коммунизм
- ❖ Авторитари дэглэм
- ❖ Зах зээлийн эдийн засаг
- ❖ Нээлттэй нийгэм
- ❖ Сонгуулийн ардчилал
- ❖ Либерал ардчилал
- ❖ Хяналтын асуултууд



Сэдвийн агуулга

Төрийн дэглэмийн ойлголт, ардчилсан болон ардчилсан бус дэглэмийн ялгаа, үндсэн шинжүүд. Либерал ардчиллын үндсэн зарчмууд, үнэт зүйлс.



Хяналтын асуулт

- Сонгуульт ардчилал гэх ойлголтын агуулгыг тайлбарлаж, либерал ардчилалтай ямар хамааралтай болох тухай эрэгцүүлнэ үү?



Эх сурвалж

1. Төрийн ерөнхий онол. Ц.Сарантуяа. УБ., 1998.
2. Төрийн онол. Н.Лүндэндорж. УБ., 2006.161-166 дахь тал.
3. Политические режим. Грохмыно.А.Л. М., 1994.
4. Ардчиллын тухай. Р.Даль. УБ., 2004.

10. Төрийн байгууллага ба түүний чиг үүрэг

Зорилго: Төрийн байгууллага, ойлголт, ангилал, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага, тэдгээрийн чиг үүрэгтэй танилцаж, төрийн байгууллага, түүний чиг үүрэгт Үндсэн хуулийн үзэл баримтлалаар дүн шинжилгээ хийх хандлагад суралцана.



Нэр томъёо

- ❖ Төрийн механизм
- ❖ Иргэний үндсэн эрх
- ❖ Хууль тогтоох байгууллага
- ❖ Засгийн газар, түүний байгууллага
- ❖ Шүүх
- ❖ Нутгийн удирдлага



Сэдвийн агуулга

Төрийн байгууллага, ойлголт, тогтолцоо /иргэний тогтолцоо, улс төр-хүнд суртлын тогтолцоо, шашин-хүнд суртлын тогтолцоо/. Бусад байгууллагаас ялгагдах үндсэн онцлог.

Төрийн байгууллагын ангилал: ангилах шалгуур /үйл ажиллагааны хүрээгээр нь, чиг үүргээр нь, байгуулах аргаар нь, бүрэлдэхүүн, шийдвэр гаргах аргаар нь/.

Хууль тогтоох эрх мэдлийн байгууллага: парламент /өргөн эрх мэдэлтэй, хязгаарлагдмал эрх мэдэлтэй, зөвлөх эрх мэдэлтэй/. Парламентын хууль тогтоох, төлөөлөх, хянах бүрэн эрх. Парламентыг тараах.

Нэг танхимтай болон хоёр танхимтай парламент.

Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага: Засгийн газар, Ерөнхий сайд, кабенитын зарчим.

Нэг намын засгийн газар, хоёр намын засгийн газар, эвслийн засгийн газар, намын бус засгийн газар. Засгийн газрыг огцруулах

Шүүх эрх мэдлийн байгууллага: шүүхийн тогтолцоо, зарчим, хэлбэр, шүүн таслах үйл ажиллагааны зорилго.

Нутгийн удирдлагын байгууллага.

Төрийн чиг үүрэг, ойлголт, ангилал /үндсэн ба гадаад чиг үүрэг/. Хууль тогтоох, биелүүлэх, хамгаалах чиг үүрэг. Бусад улстай хамтран ажиллах чиг үүрэг.



Хяналтын асуулт

- Төрийн механизм гэсэн ойлголтын агуулгад байгууллага, албан тушаалтнаас өөр бүрдэл хэсэг хамаарах уу? Хэрэв байгаа бол түүнийг тодруулна уу.
- Парламентын үндсэн чиг үүрэг юу вэ?
- Монгол улсад хоёр танхимтай парламент байж болох уу? Онолын үндэслэлийг тайлбарлана уу?
- Эвслийн засгийн газрыг хоёр намын засгийн газраас ялгагдах ялгааг тодруулна уу?
- Монгол улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ, шүүгч гагцхүү хуульд захирагдана гэсэн Үндсэн хуулийн заалтад онолын тайлбар хий.
- Төрийн чиг үүргийг үндсэн хуулийн байгуулалтай холбон тайлбарлана уу?



Эх сурвалж

1. Төрийн онол. Н.Лүндэндорж. УБ., 2006.171-201 дахь тал.
2. Общее учение о государстве. Еллинек Г. Спб., 1903.
3. Конституционное право. Л.Дюги. М., 1908.
4. Государствоведение. Чиркин.В.Е. М., 1999.
5. Государственное и административное устройство Германий. Ф. Хёфер. Мюнхен., 1994.
6. Местные самоуправления. Г.Штамнфл, Х.Шоллер. Мюнхен., 1995.



II бүлэг. ТӨРИЙН ТУСГАЙ ОНОЛ

Бүлгийн зорилго: Төрийг тусгай онолын тусламжтайгаар танин мэдэх арга зүй эзэмшинэ.

11. Төрийн эрх мэдэл хуваарилах онол

Зорилго: Төрийн эрх мэдэл хуваарилах үзэл санаа, онол бүрэлдэх явц, төрийн эрх хуваарилах онол, түүний орчин үеийн асуудал, Монгол улс дахь төрийн эрх мэдэл хуваарилалттай танилцаж, эрх мэдэл хуваарилах онолын түүхэн ач холбогдол, үнэт чанарыг ойлгуулахад чиглэнэ.



Нэр томъёо

- ❖ Эрх мэдэл хуваарилах
- ❖ Хязгаарлагдмал засаг
- ❖ Хүний эрхийг хамгаалах механизм
- ❖ Хяналт тэнцэийн зарчим /check and balance/
- ❖ Төвийг сахисан эрх мэдэл



Сэдвийн агуулга

Эрх мэдэл хуваарилах ойлголт, үзэл санаа, онол бүрэлдсэн түүхэн үйл явц, Хүний эрх, эрх чөлөө ба төрийн эрх мэдлийн хуваарилалт. Төрийн эрх мэдлийг хуваарилаагүй улс оронд Үндсэн хууль хэрэг дээр үл орших үндэслэл. Төрийн эрх мэдэл хуваарилахын үндсэн зорилго, Төрийн эрх мэдэл хуваарилалтын үндсэн зарчим: тэнцвэр, хяналт, бие даасан байдал, хууль тогтоох эрх мэдлээс гүйцэтгэх эрх мэдэлд эрх шилжүүлэх нөхцөл, журам, асуудал. Монгол улсын Үндсэн хууль дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт.



Хяналтын асуулт

- “Иргэд нь эрхээр хангагдаагүй, төрийн эрх мэдлийг хуваарилаагүй нийгэмд Үндсэн хууль байдаггүй” гэснийг тайлбарлана уу?
- Төрийн эрх мэдлийг хуваарилахын хамгийн гол зорилго юу вэ?
- “Төрийн эрх мэдэл хуваарилах” зарчмыг Үндсэн хуулийн өөрчилж үл болох цөм гэж үзэж болох уу? Үндэслэлийг тайлбарлана уу?
- Үндсэн хуулийн шүүхийн хяналт төрийн эрх мэдэл хуваарилахад ямар үүрэг гүйцэтгэж байна вэ?
- Гүйцэтгэх эрх мэдлийг хянах парламентын болон шүүхийн хяналтын онцлог, давуу талыг эрх мэдэл хуваарилах онолын үүднээс тайлбарлана уу?



Эх сурвалж

1. О духе законов // Избр. Произведения. Ш.Монтескье. М., 1955.
2. Төрийн ерөнхий онол. Ц.Сарантуяа. УБ., 1998.
3. Улс төрийн философийн удиртгал. Жоннатон Вольф. УБ., 2002

4. Ардчиллын чанар /судалгааны өгүүллийн эмхтгэл/. УБ., 2005.
5. Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага. Н.Лүндэндорж. УБ., 2002. 123-133 дахь тал.
6. Төрийн онол. Н.Лүндэндорж. УБ., 2006. 203-217 дахь тал.

12. Эрх зүйт төр, түүний үндсэн элементүүд

Зорилго: Эрх зүйт төрийн ойлголт, үзэл санаа, эрх зүйт төрийг тогтоох суурь нөхцөл, эрх зүйт төрийн хөгжлийн хандлага, чиглэл зэрэгтэй танилцаж, хууль эрх зүйн амьдралд эрх зүйт төрийн зарчмуудаар үнэлэлт дүгнэлт өгөх арга зүйд суралцана.



Нэр томъёо

- ❖ Эрх зүйт төр
- ❖ Хууль
- ❖ Эрхзүй
- ❖ Хүний жам ёсны эрх
- ❖ Үндсэн эрх



Сэдвийн агуулга

Эрх зүйт төрийн үзэл санааны эх сурвалж, эрх зүйт төрийн ойлголт, "Rule of law" ба "Rechtsstaat" ойлголтын үүсэл, нэгдэл, ялгаа, "Rule of law" ба "Rule by law" ойлголт, ялгаа.

Эрх зүйт төрийн үндсэн элементүүд: /1/ төрийн эрх мэдлийн хуваарилалт, /2/ гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас улс төрийн удирдлага хэрэгжүүлэхдээ хууль ёсыг чандлан сахих нь, /3/ үндсэн хуульт ёсыг хэрэгжүүлэх, /4/ шүүх эрх мэдлийн хараат бус байдал, /5/ эрүүгийн хууль тогтоомжийг буцаан хэрэглэхийг хориглох, /6/ эрх зүйн хамгаалал, хяналтыг тогтоох.



Хяналтын асуулт

- Эрх зүйт төр нь “байх ёстой” зүйлийг хуульчилсан хуулийг дээдэлдэг үү, эсвэл хуулийг л дээдэлдэг үү. Эдгээр ялгааг Rule of law, Rule by law гэсэн ойлголтуудын үүднээс тайлбарлана уу?
- Эрх зүйт төрийн агуулгын шаардлагад юуг багтаадаг вэ? Эрх зүйт төрийн хэлбэрийн шаардлагаас юугаараа ялгаатай вэ?
- “Шүүгч бол ярьдаг хууль, хууль бол ярьдаггүй шүүгч” гэсэн эртний Ромын мэргэн үгэнд эрх зүйт төрийн үүднээс шинжилгээ хийнэ үү?
- Nulla poena sine lege буюу хуульгүйгээр ямар ч шийтгэл байх ёсгүй гэсэн эрх зүйт төрийн үндсэн зарчимд онолын шинжилгээ хийнэ үү?
- Эрх зүйт төрийг тогтоох суурь нөхцлийг улс төр, эдийн засаг, хууль зүйн шинжлэх ухааны үүднээс тайлбарлана уу?



Эх сурвалж

1. Төрийн онол. Н.Лүндэндорж. УБ., 2006. 218-237 дахь тал.
2. Государственное и административное устройство Германий. О.Брунер, Ф.Хёфер. Мюнхен. 1994.
3. The Rule of law. Edited by Josef Thesing. 1997.
4. Харьцуулсан эрх зүй: ерөнхий тусгай онол. Кристофер Осакве. УБ., 2005.
5. The Morality of Law, New Heaven. Revised edition. Yale University Press. 1964.

13. Социал төр, түүний үндсэн зарчмууд

Зорилго: Эрх зүйт болон социал төрийн зарчим, ялгаа, нэгдэл, социал төр үүссэн шалтгаан, социал төрийн ойлголт, элемент, социал төрийг тогтоох суурь нөхцөл, хөгжлийн хандлагатай танилцана.



Нэр томъёо

- ❖ Социал төр
- ❖ Нийгмийн халамж
- ❖ Нийгмийн баялаг
- ❖ Тэгш эрх
- ❖ Нийгмийн тэгш байдал
- ❖ Хүнлэг ёс



Сэдвийн агуулга

Социал төрийн ойлголт, онцлог, зорилго. Халамжит төр ба социал төр, тэдгээрийн ялгаа. Социал төр, эрх зүйт төрийн салшгүй холбоо, түүхэн сургамж. Социал төрийн давуу болон сул тал, түүнийг даван туулах боломж.

Социал төрийн үндсэн зарчим: амьдралын наад захын баталгаа, нийгмийн тэгш ёсыг эмзэг бүлгийн хүрээнд хамгаалах, нийгмийн эмзэг хэсэгт тусламж үзүүлэх.



Хяналтын асуулт

- Социал төр үүсэх болсон үндсэн шалтгааныг тайлбарлана уу?
- Монгол улсын Үндсэн хуулийн оршил хэсэгдэх "...хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм цогцлон хөгжүүлэх" гэснийг социал төрийн үзэл баримтлалын үүднээс тайлбарлаж болох уу?
- Монгол улсын Үндсэн хуульд социал төрийн ямар зарчмууд орсон бэ? Тэдгээрийг ХБНГУ-ын Үндсэн хуулийн холбогдох заалттай харьцуулсан шинжилгээ хийнэ үү?
- Социал төрийн хөгжлийн чиг хандлага ба сул талыг орчин үеийн төр судлалын үүднээс тайлбарлана уу?



Эх сурвалж

1. Төрийн онол. Н.Лүндэндорж. УБ., 2006. 239-247 дахь тал.
2. Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага. Н.Лүндэндорж. УБ., 2003. II бүлэг.
3. Спортын эрх зүйн зарим асуудал. Б.Бат-Эрдэнэ. УБ., 2003
4. The Rule of law. Edited by Josef Thesing. 1997.

Сэдэв 14. Монголын төрийн хөгжил

Зорилго: Монгол төр ёсны сэтгэлгээний эх сурвалж, уламжлал, Монгол төрийн үүсэл, хөгжлийн түүхэн үеүд, Монгол улсад ардчилсан төр бүрэлдэх үйл явцтай танилцана.



Нэр томьёо

- ❖ Төр ёс
- ❖ Нүүдэллэн аж төрөх ёс
- ❖ Төр дээдлэх үзэл
- ❖ Хос ёсон
- ❖ Азийн үйлдвэрлэлийн арга



Сэдвийн агуулга

Дорно дахин төр ёсны соёл ба азийн үйлдвэрлэлийн арга. Монгол төр ёсны сэтгэлгээ, түүнийг нөхцөлдүүлсэн хүчин зүйл. Монголын төрийн үүсэл, хөгжлийн түүхэн үеүд, тэдгээрийн онцлог.

Хаант засагаас Бүгд найрамдах улсын хэлбэрт шилжсэн нь.

Монгол дахь социалист төрийн үе.

Монгол улсад ардчилсан төрийг төлөвшүүлэх үйл явц.



Хяналтын асуулт

- “Төр ёс”, “төр” ойлголтын нэгдэл хийгээд ялгаа юунд орших вэ? Эдгээрийн аль нь өргөн хүрээтэй вэ?
- Монголын төр ёсны эх сурвалжийг дорно дахины төр ёсны уламжлал гэж үзэж буйн шалтгааны талаар тунгаан бодно уу?
- Дорнын төр ёсны сургаалыг Өрнийхтэй харьцуулахад ямар онцлогтой вэ?
- Монголчууд төрийг шүтэж, дээдэлж хүндэтгэж ирсэн нь ямар учир шалтгаантай вэ?
- Монголын төр ёсон дахь “хос ёс”-ны сургаалыг ямар зорилгоор хэн бий болгосон бэ?
- Монгол улсад ардчилсан төр тогтоох үйл явцад өдгөө хүрсэн хамгийн томоохон ололтууд ба бэрхшээл.



Эх сурвалж

1. Төрийн онол. Н.Лүндэндорж. УБ., 2006. 263-274 дэх тал.
2. Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага. Н.Лүндэндорж. УБ., 2003. V бүлэг.

15. Дүгнэлт хичээл: Төрийн хөгжил дэх түгээмэл хандлага

Зорилго: Төрийн хөгжлийн түгээмэл хандлага, төрийн чиг үүргийн хөгжил хувьсал, төрийн хөгжил дэх даяаршлын үзүүлэх нөлөө, төрийн хөгжлийн хэтийн төлөвтэй танилцана.



Нэр томъёо

- ❖ Нэр томъёо
- ❖ Даяаршил
- ❖ Дангааршил
- ❖ Үндсэн хуульт ёс
- ❖ Шууд ардчилал
- ❖ Олон улсын санхүүгийн байгууллагууд
- ❖ Олон улсын хамтын байгууллагууд



Сэдвийн агуулга

Төрийн хөгжлийн түгээмэл хандлагын тухай ойлголт, дотоод, гадаад тал, Үндсэн хуульт ёсонд шилжих, төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд ард түмний оролцоо өсөн нэмэгдэх хандлага, төрийн чиг үүргийн хөгжил хувьсал, төрийн хөгжил дэх даяаршил ба дангааршил, төрийн хөгжлийн хэтийн төлөв.

Даяаршил, ойлголт, түүний талаархи эерэг, сөрөг байр суурь, үзэл баримтлалууд, Монголд үзүүлэх даяаршлын нөлөө.



Хяналтын асуулт

- Төрийн онолыг судлахын нэг гол үр дүн нь түүний хөгжлийн түгээмэл хандлагыг олж харах явдал мөн үү?
- Хүн төрөлхтөн үндсэн хуульт ёсонд шилжих үйл явцыг төрийн хөгжлийн нэг түгээмэл хандлага гэж үзэхийн үндэслэл юу вэ?
- Төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд ард түмний оролцоо өсөн нэмэгдэж байгаагийн илрэл юу вэ? Дэлгэрүүлэн тайлбарлана уу?
- Даяаршлийн эерэг болон сөрөг нөлөөг дахин нэг харьцуулж, бүдүүвчээр илэрхийлнэ үү?



Эх сурвалж

1. Төрийн онол. Н.Лүндэндорж. УБ., 2006. 249-262 дэх тал.
2. Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага. Н.Лүндэндорж. УБ., 2003. III бүлэг.

3. Хичээлийн заах арга зүй

Төрийн онол хичээлийн заах арга зүйд тавих шаардлага

Төрийн онол хичээлийг судлах үндэслэл, хичээлийн зорилго, зорилттой уялдан уг хичээлийг заах арга зүйд дараахь шаардлага тавигдана.

- ❖ Тухайн хичээлийн зорилгыг хангахуйц, түүний агуулгад тохирсон арга, хэлбэрийг сонгож хичээлээ заах
- ❖ Тухайн хичээлээр оюутан эрх зүйн талаар өөртөө мэддэг бүтээгээд зогсохгүй бүтээсэн мэдлэгээ амьдралд хэрэглэх чадвар эзэмших, мэргэжилдээ хариуцлагатай хандах хандлага төлөвших нөхцөл боломжийг хангах
- ❖ Оюутан бүр хичээлд жигд, идэвхтэй оролцох боломж, нөхцөлийг бүрдүүлэх
- ❖ Эрх зүйн онол нь онолын болон арга зүйн шинжтэй хичээл тул дадлагын хичээлийг түлхүү ашиглах

Мэдээлэл түгээх арга, аргачлал

Лекцийн арга /Lecture/

Лекцийн товчлол болон танилцуулгыг хэвлэж урьдчилан тараана. Хичээлийн явцад оюутан тодруулж тэмдэглэх зүйлээ бичиж болохуйц зайг тусгайлан гаргаж лекцийг хэвлэнэ.

Лекцийн хичээлийг багш Төрийн онолын ерөнхий ойлголт, өргөн хүрээний мэдлэгийг оюутанд өгөх, ойлгоход нарийн төвөгтэй зүйлийг тайлбарлан таниулах болон гагцхүү олон цаг зарцуулан янз бүрийн эх сурвалж уншиж байж бий болох мэдлэгийг хүргэх, зорилгоор ашиглах нь илүү тохиромжтой. Лекцийн хичээлд, зураг, бүдүүвч, дэлгэц, компьютер, проектор болон бусад үзүүлэн таниулах материал өргөнөөр ашиглах нь цаг хэмнэх, оюутны мэдээлэл хүлээн авах чадварыг нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Лекцийн аргыг хэрэглэхэд анхаарах зүйлс:

- ❖ Лекцийг үргэлжилсэн урт хугацаагаар унших нь оюутан анхаарлаа төвлөрхөд бэрхшээл үүсгэдгийг харгалзан боломжтой нөхцөлд хэлэлцүүлэг, дүрд хувирах, биечлэн үзүүлэх зэрэг бусад аргыг лекциндээ багтаах нь зүйтэй.
- ❖ Багш ярихын зэрэгцээ үзүүлэн таниулах материал ашигласан тохиолдолд оюутнуудын тогтоох мэдээллийн хэмжээ 25 хүртэл хувиар нэмэгддэг бол заалгасан зүйлээ туршиж хэрэглэсэн нөхцөлд энэ үзүүлэлт 70 хувь хүртэл өсдөгийг анхаарах шаардлагатай.

Эвлүүлгийн арга /Jacksaw/

Энэ арга нь оюутанд богино хугацаанд их хэмжээний мэдээлэл олж авах боломж олгодог ба лекцийг орлуулахад түүнийг ашигладаг. Тухайлбал, эрх зүйт ёсны зарчмуудыг нэгтгэн ойлгоход энэ арга үр нөлөөтэй байж болох юм.



Эвлүүлгийн аргын зорилго нь оюутнууд бие биедээ заах, сургах боломж олгодог ба тухайн хичээлээр мэдээлэл олж авахад хүндрэлтэй тохиолдолд тайлбарлах, асуулт тавих, бусадтай харилцах, бусдыг сонсох чадварыг амьдралд хэрэглэхэд илүү үр дүнтэй байдаг.

Хичээлийн зарим сэдвийг судлахад оюутнууд дэлгэрэнгүй мэдээчэл шаардагддаг ба энэ тохиолдолд тухайн мэдээлэл, лекцийн агуулга болон бусад нэмэлт хэрэглэгдэхүүнийг жижиг багийн тоогоор хувааж бэлтгэнэ. Бэлтгэсэн материалаа дугтуйд хийж багуудад тарааж өгнө. Тэдэнд "мэргэжилтэн" болоход хангалттай хугацаа өгөх хэрэгтэй учир баг бүр дээр багш очиж материалаа ойлгож байгаа эсэх, бусдад хэрхэн тайлбарлах талаар ярилцаж туслах шаардлагатай.

Сократын яриа /Socrat's Talk/

Бүлэг сэдэв танилцуулах, богино хугацаанд их хэмжээний мэдээлэл олж авах болон нэлээд сэтгэлгээ хөгжүүлэх сэдвийн дор энэ аргыг ашиглана. Тухайлбал, хуульд дээд хүчин чадал олгох үзэл баримтлал ба төрийн эрх мэдэл хоёрын сөргөлдөөний талаарх сэдвийг харилцан ярилцах нь тохиромжтой байдаг.

Энэ арга нь сургалтын үйл явцад оюутнуудыг идэвхтэй оролцуулах, оюутнуудад үзэл бодлоо илэрхийлж, хамгаалах боломж олгох, нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэх ач холбогдолтой. Энэ аргыг ашигласнаар оюутнуудын хичээлд хандах сонирхлыг өдөөж, бусадтай санал бодлоо хуваалцаж, мэтгэлцэх, маргах соёлд суралцуулна.

Хичээлийн үзэх сэдэв, товч агуулга, ашиглах эх сурвалж зэргийн талаархи мэдээллийг багш урьдчилан оюутнуудад танилцуулан, тараасан байна. Мөн оюутнуудын хичээлд суух байршил, нэрс зэрэг нь багшид урьдчилан өгөгдсөн байна. Багш оюутанд нэрээр нь хандан тухайн асуудлаар үзэл бодлыг нь сонсож, үндэслэгээг нь сонсон харилцан ярилцаж, бусдад дүгнэх боломж олгож, хэлэлцүүлэг өрнүүлэн явуулна.

Хүн бүр багш /Each one teach one/

Бүлэг сэдвийг танилцуулах эсхүл үзсэн сэдвийн агуулга, ухагдахуунуудыг дүгнэх, лекцийн агуулгыг оюутнуудад хүргэхэд энэ аргыг гол төлөв ашиглана.

Энэ аргын зорилго нь сургалтын үйл явцад оюутан бүр идэвхтэй оролцох, бие биетэйгээ санаа бодлоо солилцоход ач холбогдолтой. Энэ аргыг ашигласнаар хичээлээр заавал эзэмших ёстой сэдвийн агуулга болон ухагдахууны талаар ерөнхий ойлголт өгөх ба оюутнуудын сонирхлыг өдөөж, асуулт тавихад хүргэнэ.

Хэрэгжүүлэх дараалал:

- ❖ Лекцийн агуулга, мэдээллийг утгат хэсгээр нь хувааж, тарааж өгөх зорилгоор жижиг цаасан дээр бичиж бэлдэнэ. Энэ нь таны сургалтад оролцогчдын тоогоор байх ёстойг анхаарч оролцогч бүрт тараана.
- ❖ Оюутнууд мэдээллийг уншсаны дараа уншсан зүйлийнхээ агуулгыг ярих, зураглал, бүдүүвчээр илэрхийлэх зэргээр бусдад түгээх бэлтгэл хийнэ. Энэ үед багш тусламж шаардлагатай хүн дээр очиж зөвлөгөө өгч, тайлбарлаж болно.
- ❖ Бэлтгэх хугацаа дууссаны дараа тэд мэдээллээ бие биедээ танилцуулж ангиа тойрон явна. Хүн бүр өөрт байгаа мэдээллээ танилцуулж, бусдаас мэдээлэл

авч дуустал энэ ажил үргэлжилнэ. Зорилго нь бусадтай мэдээлэл солилцох буюу өөрт байгаа мэдээллээ бусдад тарааж, шинэ мэдээлэл бусдаас олж авахад оршино.

Энэ ажлыг дууссаны дараа багш оюутнуудад хандан, бие биенээсээ юу олж мэдсэн, ямар шинэ мэдээлэл авсан тухай, уг мэдээлэл өөрт нь ямар хэрэг болох тухай асууж ярилцана.

Ярилцлагын явцад оюутнуудад юу хэрэгтэй байгаа, тэд бие биеэсээ авсан мэдээллийг хэрхэн цэгцлэх шаардлагатайг багш ажиглаж, тэр дагуу нэмэлт мэдээллийг өгнө.

Оролцооны арга, аргачлал

Хийсвэр жишээ /Abstract example/

Хийсвэр жишээ нь мөн Сократын яриа-наас үүдэлтэй бөгөөд оюутнуудын сэтгэлгээг хөгжүүлэх, эрх зүйн үзэгдэлд онолын задаргаа, эрх зүйн зарчим, үзэл баримтлалын дүн шинжилгээ хийх чадвар эзэмшүүлэхэд энэ арга өргөн хэрэглэгддэг.

Зорилго нь сургалтад оролцогсодын өмнө онолын үндэслэл, тайлбаруудыг нарийвчлан хийж болохуйц хийсвэр жишээ бүхий нөхцөл байдлыг тавьж, суралцагсдын өмнө авсан мэдээлэл, туршлага болон амьдралдаа баримтладаг үнэ цэнэд нь тулгуурлан уг нөхцөл байдлыг улам бүр хүндрүүлэн сорьж, идэвхтэй оролцуулахад оршино.

Хэрэгжүүлэх дараалал:

- ❖ **Үндэс суурийг тавих.** Дүн шинжилгээ хийхэд хэрэглэх зарчим, агуулгыг танилцуулсан байх ёстой.
- ❖ **Хийсвэр жишээг ашиглах.** Эрх зүйн зарчим, үзэл баримтлал, дүрмүүдийг ашиглан олон сонголт гаргаж ирж болох хариулттай, эсхүл тэдгээрээр дэс дараатай алхамууд хийж болох хийсвэр жишээ гаргах.
- ❖ **Танилцуулах.** Олсон хийсвэр жишээг сонирхлыг татах хэлбэрээр буюу болж өнгөрсөн бодит зүйл, моодонд орж байгаа зан заншил, алдартай хүмүүс, уран бүтээлтэй холбох, иш татах, үйл явдлыг ноцтойгоор эсхүл хошигносон хэлбэрээр танилцуулж болно.
- ❖ **Зөрүүг олж тогтоох.** Эрх зүйн онолыг ашиглаад шууд шийдчихэж болохооргүй хийсвэр жишээ бол харилцан идэвхтэйгээр дүн шинжилгээ хийх боломжтой байвал зүгээр.
- ❖ **Санал асуулга асуух.** Тодорхой сценари бүхий жишээг хэлэлцсэний дараа оролцогч бүрт тухайн жишээнд дурдсан асуудлаар нэг буюу түүнээс дээш асуулт тавьж, асуулт бүр дээр олон сонголт бүхий хариулт өгч саналыг нь асуух хэрэгтэй.
- ❖ **Харилцан идэвхитэй дүн шинжилгээ хийх.** Хийсвэр жишээг уншиж сонсгоод, оюутнууд саналаа өгч, хариуг цаасан дээр булгасны дараа багш тухайн санал буюу хариуны хувилбарын талаар тайлбар шаардаж хэлэлцүүлгийг эхлүүлнэ.



Тохиолдол шинжлэх /Case method/

Тохиолдол шинжлэх арга нь оюутнуудад эрх зүйн хэм хэмжээг амьдралын тодорхой жишээн дээр үндэслэн хэрэглэж сурахад нь туслах зорилготой асуултын аргад тулгуурласан хэлбэр юм. Тодорхой жишээ гэдэг нь тухайн явдал, бодит хэрэг, шүүхийн шийдвэр зэрэг оюутнуудад нийгэм, эрх зүй, хүний эрхийн асуудлаар шинэ сэргэг ойлголт, мэддэг өгөх, асуудалд олон талаас нь шүүмжлэлтэй, нухацтай хандах сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэгдэж ашиглагдах хэрэглэгдэхүүн юм.

Сургалтын тохиолдлууд ихэвчлэн эх бичвэрийн хэлбэртэй байдаг боловч кино болон дүрс бичлэг, дуу хураагчид бичигдсэн, дүр бүтээж тоглох болон бусад хэлбэрээр байж болно.

Тохиолдол шинжлэх аргыг хэрэглэхийн тулд амьдрал, практикт гарч байсан эрх зүйн онолын маргаантай холбоотой хэрэг маргааны талаарх янз бүрийн мэдээлэл, хууль тогтоомж, эрх зүйн актууд болон холбогдох гарын авлагуудыг бэлтгэсэн байх шаардлагатай.

Зорилго: сургалтын энэ арга нь суралцагчийн ямар нэгэн бодит баримтын талаар асуулга тавих, тухай бүрийн тодорхой нөхцөлүүдэд чухал болохыг тодорхойлж, тэдгээрийг задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, тохиолдол бүрт эргэцүүлэн бодож байх боломж олгодог. Тохиолдлыг шинжлэх явцаа суралцагчид нь цээжлэн тогтоох эхний хэлбэрээс эхлээд бодит баримтыг үнэлэх хүртэл сэтгэхүйн үйлдлүүдийг хийж дадлагажиж болно.

Түүнчлэн оюутнууд шүүхийн шийдвэр болон хэрэг маргаанд дүн шинжилгээ хийх, хууль хэрэглэх дадал, арга зүй олгох, тэдний идэвхийг өрнүүлэхэд энэ аргын зорилго оршино.

Тохиолдол шинжлэх аргыг яагаад хэрэглэдэг вэ?

- ❖ Тоймлосон дүгнэлт, тодорхой үзэл санааг гаргадаг.
- ❖ Харьцангуй өндөр түвшинд хийсвэрлэн сэтгэх боломжийг хангадаг.
- ❖ Суралцагчдын дотоод сэтгэлгээний дадлага, чадварыг хөгжүүлэх, бие даасан задлан шинжилгээ хийх болон шийдвэр гаргах хүнд бэрх сэтгэн бодох үйлдэлд дасгана.
- ❖ Танхимд суралцаж буй суралцагчдыг бодит амьдралын туршлага, жишээтэй сэтгэлгээний хувьд холбоотой байх нөхцдийг бүрдүүлнэ.
- ❖ Суралцагч онолын болон ерөнхий мэдлэг, арга зүйн чадвар, өөрт буй болсон хандлагаа амьдралд хэрэглэх боломж олгохын зэрэгцээ, эрх зүйн практикт шинэ үзэл санаа, ойлголт, зарчмыг хөгжүүлэхэд нөлөөлнө.

Тохиолдол шинжлэх аргыг хэрэглэхэд тавих хязгаарлалт болон санамж:

- ❖ Хэдийгээр авч байгаа тохиолдол нь бодит байдлын тусгал болдог ч жинхэнэ бодит байдал хараахан биш юм. Нэг ч жишээ жинхэнэ бодит байдлыг бүрэн орлож чадахгүй гэдгийг санах хэрэгтэй. Зарим тохиолдолд жинхэнэ байдал дээр шийдвэр гаргахдаа танхимын сургалтын жишээнд үзүүлж хэрэглэх аргагүй тийм үл ойлгогдох баримтад үндэслэхэд хүрэх нь ч бий.
- ❖ Сургалтад хэрэглэгдэж буй жишээ бүр нь өөрийн тодорхой үзэл бодол, мэргэжлийн түвшин бүхий хүн /багш/-ээр суралцагчдад хүрдгийг мартаж болохгүй. Уг аргыг хэрэглэх нь үлэмж их цаг хугацаа шаардана. Энэ чанараар бусад хичээл, сэдвийн цагт сөргөөр нөлөөлдөг. Иймээс тохиолдол нь маш

сайн шилж авсан, баялаг агуулгатай, өгөөжтэй, суралцагчдын дадлага, чадварыг үнэхээр хөгжүүлж чадахуйц байх ёстой.

- ❖ Зөвхөн ганц тохиолдлыг шинжилснээр сурагчид маш сайн дүгнэлтэд хүрч болох юм. Мөн нэг сэдэв дээр хэд хэдэн жишээ, эсхүл өгөгдсөн жишээн дээр, болон статистик тоо баримт дээр ажиллах боломжтой.
- ❖ Ердийн танхимын нөхцөлд багш нь энэ аргаар хичээл явуулахад лектор биш ярилцлагыг хөтлөгчийн дүрд тоглох болно. Гэтэл багш бүр энэ үүргийг биелүүлэхэд бэлэн биш байж болохыг бас анхаарах шаардлагатай. Зарим тохиолдолд хууль, эрх зүй тэр бүр ойлгомжтой биш, тэгээд ч зөрчилдөөнтэй байх нь бий. Батлагдсан хуулиудын эдгээр дутагдал нь сургалтын жишээг танхимын нөхцөлд заахад хүндрэлтэй болгож болно. Ийм тохиолдолд багш, суралцагчид ямар хууль батлагдсан байх ёстой байсан, хуулийг хэрхэн өөрчлөн сайжруулж болох, ийнхүү өөрчлөн сайжруулахад оролцох арга замуудын талаар ярилцахад хүрдэг.
- ❖ Энэ аргыг хэрэглэхдээ нэг багшид 20-оос илүүгүй оюутан оногдохоор бодож тооцоолох хэрэгтэй бөгөөд оюутны тоо үүнээс илүү байх тохиолдолд хичээлийн зорилго, үр дүнд муугаар нөлөөлдөг.
- ❖ Холбогдох гарын авлага /гарын авлага, дасгал, бодлогын хураамж зэрэг/, материал, хууль тогтоомжоор зайлшгүй хангагдсан байх ёстой бөгөөд энэ шаардлага хангагдаагүй тохиолдолд хичээлийг үр дүнтэй явуулах боломжгүй.
- ❖ Багшийн хувьд хуулийн практикт ажилласан туршлагатай байх нь энэ хичээл амжилттай явагдах гол нөхцөл юм.

Тохиолдлыг бэлтгэх:

Тохиолдлыг сонгон авах болон боловсруулахдаа дараах шалгууруудыг анхаарах хэрэгтэй.

- ❖ Хүмүүсийн амьдрал, төрийн онол, практикт олонтаа тохиолддог маргаантай асуудлуудыг тусгасан, өөрөөр хэлбэл, бодит байдалд бүрэн нийцсэн эсэх
- ❖ Суралцагчдад сонирхолтой бөгөөд зохимжтой эсэх
- ❖ Тохиолдолд авсан нөхцөл нь суралцагчдын зүгээс заддан шинжилгээ хийж, өөрсдийн эргэцүүлээ бодож боловсруулах боломж олгохуйц байгаа эсэх
- ❖ Эерэг, сөрөг баримт нотолгоог гаргаж болохуйц, мэдээллийн тэнцлийг хангаж чадсан эсэх

Үе шат:

Нэг. Шийдвэр гаргахад бэлтгэх үе.

Аливаа шийдвэрийг гаргахад хангалттай сайн мэдээлэл, баримт нотолгоо цуглуулж боловсруулах хэрэгтэй байдаг. Үүний нэг адил тохиолдлыг шинжилж, шийдвэр гаргахын тулд бэлтгэл ажил хэрэгтэй. Үүнд:

1. Тухайн тохиолдлыг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг өгөх. Мэдээллийг өгөх олон янзын арга байдаг. Тухайлбал, уншуулах, бага хэмжээний лекц сонсгох, видео бичлэг үзүүлэх гэх мэт.
2. Тохиолдлыг уншуулах. Энэ үед оюутанд тохиолдол /шүүхээр хянан хэлэлцэх



ажиллагаа/-ын эцсийн үр дүн, шийдвэрийг мэдээлэхгүй байх хэрэгтэй. Уг асуудлын бодит төгсгөлийг нилээд хожим нь авч үзэх болно.

3. Цаашдаа суралцагчдын анхаарлыг бодит баримтын учрыг олоход чиглүүлэх нь чухал. Юуны түрүүнд тохиолдлын үйл явдлыг сайтар ойлгуулах нь чухал. Дараах асуудалд хариулт авах замаар тэдний ойлголтыг гүнзгийрүүлж болно.

- Уг тохиолдолд /шүүхээр хянан хэлэлцэх ажиллагаа/ чухам юу болсон бэ?
- Уг маргаанд ямар хүмүүс, аль аль талууд оролцсон болох?
- Оролцсон талууд болон хүмүүсийн үйлдсэн, хийсэн зүйл нь чухам ямар учир шалтгааны улмаас үйлдэгдсэн болох?
- Онолын ямар үндэслэл, арга зүйн ямар нөхцөлүүд чухал болох, шүүхийн шийдвэрт ямар үндэслэгээ чухал болох.

Хичээлийн энэ үед бүх суралцагчид нэг ижил баримтад тулгуурлах ёстой бөгөөд энэ үндсэн дээрээ идэвхтэй ажиллах ёстой тул багш сургалтын тухайн шатанд анхааралтай байх нь чухал. Түүнчлэн уншлагын дадал суугаагүй суралцагчдад ч энэ үе нь чухал ач холбогдол, нөлөөлөлтэй байдаг.

Багшийн зүгээс өөрөө асуулт боловсруулж суралцагчдад ч тавих эсхүл тэднээр өөрсдөөр нь ажиллуулж, асуулт боловсруулж ч болох юм. Ингэхдээ хоёр хоёроор нь ажиллуулах бөгөөд нэг нь чухал баримтууд дээр товч дүгнэлт хийж байхад хоёр дахь асуултуудыг боловсруулан бэлтгэж байх юм.

Хоёр. Шийдвэр гаргах үе

Суралцагчид хэрэгтэй мэдээллээ авч, тохиолдлыг хангалттай сайн судалж, ойлгосны үндсэн дээр шийдвэр гаргах үйл ажиллагаандаа орно. Тэдний шийдвэр гаргах үйл явцыг багш янз бүрийн аргаар зохион байгуулж болно.

Төрийн онолын хичээл нь бусад салбар эрх зүйн хичээлийн нэгэн адил амьдралд ойрхон, практикаар байнга шалгагдаж байдаг учир энэ хичээлийг заах гол арга нь тохиолдол шинжлэх арга юм.

Маргаантай асуудлаар хэлэлцүүлэг явуулах арга

Энэ арга нь онолын эсрэг, тэсрэг үзэл бодлыг оюутнууд хамтран хэлэлцэж, өөрийн санал бодол, байр суурийг илэрхийлэх, хамгаалах, мэдээлэл солилцох, өрсөлдөгчийн үзэл бодлыг хүлээн зөвшөөрөх чадвартай болгох зорилготой.

Маргаантай асуудаар хэлэлцүүлэг явуулах аргаар хичээлийг явуулахад оюутнууд эсрэг, тэсрэг үзэл бодлыг хүлээн зөвшөөрч, ойлгож, няцаах, нотолгоог дэвшүүлэх чадвар, хандлага төлөвших боломжтой.

Суралцагчдаас, уг асуудалд тэдний үзэж байгаагаар хамгийн чухал маргаантай асуудлууд нь чухам аль нь болохыг асууснаар багш уг сэдэвт холбогдолтой хэлэлцүүлэг, ярилцлага эхэлж болох юм. Хичээлийн явц дүнгээс шалтгаалаад олон төрлийн /хууль эрх зүй, ёс суртахууны эсхүл практикийн холбогдолтой гэх мэт/ асуудлууд гарч болох юм.

Маргаантай асуудлаар хэлэлцүүлэг явуулахад оюутан эхлээд тухайн тохиолдлын хамгийн маргаантай болох цөм хэсгийг ойлгох нь чухал бөгөөд үүнгүйгээр тэдэнд уг тохиолдлын бусад зүйлийг ойлгоход бэрх болно.

Багшийн зүгээс сургагчдын түвшин болон уг аргаар ажиллах дадлага туршлага зэргийг харгалзан өөрөө уг жишээний гол маргаантай хэсгийг нь тайлбарлан ярьж ч болох талтай. Ингэж багшийн эсхүл оюутны өөрсдийн хүчээр тодорхой ойлгож авсан асуудлын гол хэсгийг дараа дараагийн үзэх зүйлүүдээс ялгаж салгах нь чухал юм.

Үүний дараа оюутан онолын үндэслэл, баримт, нотолгоо олох, боловсруулах болон тэдний гаргасан баримт нотолгоо нь нэг үзэл санааг дэмжиж, нөгөөг эсэргүүцэх нь ойлгомжтой. Энэ явцад тэдэнтэй олон талыг хамарсан дараах асуудлуудыг хөндөн ярилцаж болно.

- ❖ Маргалдагч үзэл санаа бүрийг дэмжих буюу эсэргүүцэх ямар баримт, учиршалтгаан байж болох? Аль нь үнэмшил муутай болох? Яагаад?
- ❖ Энэ асуудлыг өөр арга замаар шийдвэрлэж болох эсэх?
- ❖ Хөндлөнгийн байр суурь болоод маргагч талуудын хувьд энэхүү асуудлыг яаж, хэрхэн шийдвэрлэснээр ямар үр дагавар учирч болох?
- ❖ Баримт нотолгоо, учир шалтгаан болон шийдвэр бүрийн давуу тал нь юу болох?

Оюутныг хууль зүйн баримт, шалтгааныг ашиглах, эрх зүйн онолын ойлголт, нийгмийн үнэт зүйл болон улс төр, эдийн засгийн холбоо хамаарлыг судалж чадаж байгаа бол урам өгөх нь чухал. Янз бүрийн нотолгоо, баримт, учир шалтгааныг тодруулах хэлэлцэх явцад бусдын буюу өөр нотолгоо, үндэслэлд хүлээцтэй, тэвчээртэй хавдах, мөн хэлэлцүүлгийн ил тод байдлыг хангасан тийм уур амьсгал бүрдүүлэх нь зохистой байдаг.

Оюутнуудаас шүүн хэлэлцэж буй ямар ч асуудал, санаа бодол, хүсэлт нь эв зетэй байдал, маргаан зөрүүтэй аль ч үед адил тэгш хэлэлцэгдэж, яригдах ёстойг ойлгосон байх ёстой. Өөрөөр хэлбэл, суралцагчид бусдыгаа сонсдог, үзэл санааг нь хүндэтгэдэг, бодитой хандаж, үнэлэлт өгөх чадвартай байна гэсэн үг.

Энэ үед тэдний бүх учир шалтгаан, нотолгоог сонссоны дараа шийдвэр гаргахад анхаарлыг нь төвлөрүүлэх нь чухал. Тэдний гаргасан шийдвэрийн үндэслэлийг заавал асуух хэрэгтэй. Хэрэв шийдвэрийг багш гаргасан буюу уншиж сонгосон бол дараа нь заавал сурагчдаар үнэлэлт өгүүлэх хэрэгтэй. Тэд багшийн уншсан сэдэвтэй санал нийлж байгаа эсэх? Ямар учраас? Энэ шийдвэр нь уг ажиллагаанд оролцогч талуудад хэрхэн тусч байна вэ? Нийгэмд ямар үр дагавар авчрах вэ? гэх мэтээр асуух нь тэдэнд үнэлэлт, дүгнэлтээ хэлэх боломжийг олгоно.

Хэрэв шийдвэрийг оюутнууд өөрсдөө гаргасан бол уг шийдвэрийг гаргах болсон шалтгаан, үндэслэлийг хэрхэн тайлбарлаж байгааг анхаарах нь зүйтэй. Энэ бүхний эцэст, хэрэв авсан тохиолдол нь шүүхээр шийдвэрлэгдсэн бодит хэрэг байсан бол багш шүүхийн шийдвэрийг хэлж өгөх нь зүйтэй. Үүнийг хийхдээ, оюутнууд зөвхөн байгаа баримтад тулгуурлан өөр шийдвэр гаргаснаараа буруутай мэтээр өөрсдийгөө ойлгох байдал төрүүлэхгүйгээр хийх нь чухал. Үүний тулд багш дараах загвар асуултуудаас ашиглаж болох юм.

- ❖ Оюутны болон хуулийн байгууллагын гаргасан шийдвэрүүдийг харьцуулж, аль нь юуны учир илүү давуутай болохыг хэлэлцэнэ.
- ❖ Шүүх яагаад өөр шийдвэр биш, чухам тэрхүү шийдвэрийг гаргах болов? Энэхүү шийдвэрийг гаргахад ямар шалтгаан нөлөөлөв?
- ❖ Та нар энэ шийдвэртэй санал хэрхэн нийлж байна вэ? Танд энэ шийдвэр эрхэн нөлөөлж байна? Бусад хүмүүст бол яаж нөлөөлөх вэ? Энэ шийдвэрийн нөлөө, ач холбогдол ямар байх вэ? гэх мэт.



Хичээлээр хэлэлцэх маргаантай асуудлыг сонгох шалгуур:

- ❖ Асуудлыг олон талаас нь авч хэлэлцэх боломжтой, үнэхээр маргаантай асуудал мөн эсэхийг тогтооно.
- ❖ Хуулийг дээдлэхэд болон ардчиллыг хөгжүүлэхэд энэхүү асуудал нь чухал ач холбогдолтой эсэх
- ❖ Энэ асуудал нь тухайн оюутнуудад хэлэлцэхэд тохиромжтой болон эрх зүйн онол, арга зүйн хувьд ач холбогдолтой эсэх

Маргаантай асуудлыг хэлэлцэхэд баримтлах дүрэм:

Маргаантай асуудлыг хэлэлцэхэд хувь хүний үзэл бодлыг хөндөх ба сэтгэлийн хөдөлгөөн үүсгэдэг учраас заримдаа түүнийг зохион байгуулалттай дарааллаар хэрэглэхэд хүндрэлтэй байдаг. Иймээс хичээлийг зохион байгуулалт сайтай явуулах, үүссэн маргаантай байдлыг хяналтдаа байлгахад дараах дүрэм нь багшид тус болно.

Тухайлбал:

- ❖ Дүрмийг зөвшилцөж гаргаад бүгд биелүүлнэ.
- ❖ Нотолгоо болон баттай мэдээлэл дээр анхаарлаа төвлөрүүлнэ.
- ❖ Цаг барьж, ганцаараа ярихаас зайлсхийнэ.
- ❖ Уриа хэрэглэхээс зайлсхийнэ.
- ❖ Маргааныг хийсвэр түвшинд хүргэхээсээ өмнө тодорхой асуудлуудаар ярилцана.
- ❖ Таны байр сууринд эргэлзэх бололцоог бусдадаа олгоно.
- ❖ Өөрийн байр суурийн эргэлзээтэй, хүнд хэцүү болон сул талуудыг хүлээн зөвшөөрнө.
- ❖ Бусдын санааг өөрчлөн хэлэх замаар ойлгож сурна. Ийм дадалтай болгохын тулд бусдаас сонссоноо өөрчлөн хэлж сурна. Үзэл бодол болгонд хүндэтгэлтэй хандана.

Хэрэгжүүлэх дараалал:

1. Ангийн булангуудад хэлэлцэх асуудлын сэдвээс хамааран "Санал бүрэн нийлж байна", "Санал нийлж байна", "Шийдээгүй буюу эргэлзэж байна", "Санал нийлэхгүй байна", "Санал бүрэн нийлэхгүй байна" эсвэл "Маш зөв", "Зөв", "Буруу", "Маш буруу" гэсэн бичиг бүхий цаасыг энэ дарааллаар байрлуулсан байна.
2. Энэ дасгал ажлыг хэрхэн хийх талаар дүрэм зохиогоод түүнийгээ хэлэлцэж батална.

Дүрмийн жишээ

1. Хэлэлцэж буй асуудлын хүрээнд суралцагчид өөрсдийн байр суурийг илтгэсэн бичиг бүхий буланд очиж зогсоно.
2. Суралцагчдыг өөрсдийн байр суурийг тодруулж тайлбарлахыг хүснэ. Бүх суралцагчдыг хамруулах үүднээс ижил сонголттой сурагчид нэг багийг үүсгэж ярилцаад байр сууриа танилцуулахад бэлдэнэ.
3. Өөрсдийн байр суурийг тайлбарласны дараа хэн нэг нь байр сууриа өөрчилж өөр буланд очихыг хүсэж байгаа эсэхийг асууна. Хэрэв өөрчлөх хүсэлтэй хүн гарвал яагаад ингэх болсон шалтгааныг асууна.

4. Эсрэг баримтлалуудын дэвшүүлсэн үндэслэлээс аль нь хамгийн үнэмшилтэй байсныг асууна.

Сургалтыг идэвхжүүлэхэд чиглэсэн арга, дасгалууд:

Сургалтын арга зүйд мэдээлэл түгээх, оролцооны зэрэг дээр дурдсан аргуудаас гадна тэдгээртэй хослуулан сургалтын явцад оюутнуудыг идэвхжүүлэх, өдөөх, анхаарал төвлөрүүлэх зорилгоор тусгай арга, дасгалуудыг хэрэглэх нь зүйтэй. Гэхдээ аль аргыг ямар сэдэв бүхий хичээл дээр, ямар аргуудтай хослуулан хэрэглэх талаар багш урьдчилан бэлтгэж, төлөвлөх хэрэгтэй. Энэ утгаар багш хичээлийн агуулга, сургалтын арга, аргачлал, дасгалуудыг уялдуулан төлөвлөх хүснэгтийг ашиглах боломжтой.

Сургалтыг идэвхжүүлэх арга, дасгалуудыг эрх зүйн онолын хичээлийн агуулгатай уялдуулан багш өөрийн арга барилаар баяжуулан хэрэглэж болно. Сургалтад өргөнөөр хэрэглэдэг зарим арга, дасгалуудыг дурдвал.

1. Мөс хайлуулах буюу танилцах дасгал:
а/ цасан өнхрүүш

Зорилго:	Оюутны идэвхийг өрнүүлэх, алжаалыг тайлах, бие биеийнхээ нэрийг мэддэг болгох
Анхаарах зүйл:	Жижиг багаар ажиллах үед тохиромжтой
Материал:	Шаардлагагүй

Оролцогч бүр нэрээ хэлэхээс гадна нэрнийхээ үсгээр эхэлсэн ямар нэгэн тэмдэг нэр бодож олно. Тухайн хүний хувийн шинж чанарыг тодорхойлсон тэмдэг нэр байх нь чухал. Оролцогчид нэгэндээ тэмдэг нэр хэлж өгөх, давхцаж байгаа эсэхэд анхаарал хандуулах нь чухал. Дасгал дараах байдлаар явагдана. Үүнд: Оролцогч эхлээд өмнөх хүнийхээ нэр, нэрийн үсгээр эхэлсэн тэмдэг нэр хэлээд дараа нь өөрийн нэр, нэрийн үсгээр эхэлсэн тэмдэг нэрийг хэлнэ. Дараагийн оролцогч түрүүчийн оролцогчийн хэлснийг бүгдийг давтаж хэлээд дараа нь өөрийн нэр, тэмдэг нэрийг мөн хэлнэ. Дасгал ийм маягаар цааш үргэлжилсээр сүүлчийн хүн бүх оролцогчийн нэр, тэмдэг нэрийг давтан хэлээд өөрийн нэр, тэмдэг нэрийг хэлнэ.

б/ бөмбөг

Зорилго:	Оюутны идэвхийг өрнүүлэх, алжаалыг тайлах, бие биенийхээ нэрийг мэддэг болгох.
Материал:	Жижиг бөмбөг

Дасгал дараах байдлаар явагдана. Бүх оролцогчид тойрог болон зогсоно. Дасгалыг эхлэхдээ өөрийн нэр болон нэг нэгний нэрийг хэлэнгээ тэр хүн рүүгээ бөмбөгөө шиднэ. Бөмбөг авсан хүн өөрийн нэрээ мөн бөмбөгөө дамжуулах хүний нэрийг хэлэнгүүтээ бөмбөгөө шидэх байдлаар тоглоом өрнөх ба оролцогчид нэгнийхээ нэрийг лавлаж асуухгүйгээр, мөн бөмбөгөө хурдан дамжуулдаг болтол үргэлжлүүлэн тоглож болно.



2. Солилцооны арга

- Зорилго: Тодорхой асуудлыг шинжлэхэд оролцогчдыг бүгдийг хамруулах, идэвхжүүлэх, бие даан асуудал дэвшүүлэн дүгнэх, шүүмжлэн хэлэлцэх чадварыг хөгжүүлэх
- Анхаарах зүйл: Оролцогчид баг дотроо шийдвэрлэх асуудааа зураг, график, хүснэгт гэх мэт аргуудаар илэрхийлэн хамтран ажиллана.

Хэрэгжүүлэх дараалал:

- ❖ Багийн гишүүдийг дугаарлана.
- ❖ Багшийн хэлсэн тоо, эсвэл оюутан өөрсдөө хэн нэгнийгээ сонгон багтаа үлдээж, үлдсэн хэсэг нь бусад багийн ажилтай танилцахаар явна. Энэ үедээ бүх багийн ажилтай тойрон явж танилцахаас гадна асуулт асууж, өөрсдийн саналыг хэлнэ.
- ❖ Багтаа үлдсэн хүн өөр багаас ирж байгаа хүмүүст өөрсдийн хийсэн ажлаа танилцуулна. Бүх оролцогчид өөрсдийн багтаа эргэн ирж, багтаа үлдсэн хүндээ бусдын санал бодлыг танилцуулж ярилцана. Багууд хийсэн ажлаа дахин хянаж, нэмэх, хасах зүйлийг тодорхойлон ажлаа нэгтгэнэ.

3. Марафон бичлэгийн арга

Энэ арга нь бага хугацаанд олон хүний саналыг гаргах, чөлөөт сэтгэлгээг хөгжүүлэх зорилготой оролцооны арга юм.

Анхаарах зүйл: тодорхой сэдэв үзсэний дараагаар хэрэглэж оюутнуудаар дүн шинжилгээ хийлгэнэ.

Хэрэгжүүлэх дараалал:

- ❖ Сургалтын агуулгыг харгалзан оновчтой асуултыг урьдчилан бэлтгэнэ.
- ❖ Дээрх асуултад багийн гишүүн бүр нэг хуудас цаасан дээр өөрийн хариултаа бичээд баруун гар талын хүн рүүгээ дамжуулна. Ингээд анхны бичсэн хуудас эхний хүн дээр иртэл дамжуулна.
- ❖ Хариултауд нэлээд зөрүүтэй байвал баг дотроо ярилцах замаар цааш үргэлжлүүлж болно. Хэрвээ багийн гишүүд бүгд ижил хариулт бичсэн байвал эхний хүнийг урамшуулж болно.
- ❖ Марафон бичлэгийн аргыг аль болох хурдан хугацаанд тодорхой асуудлыг дүгнэн хэлэлцэх, оюутнуудыг идэвхжүүлэх, анхаарлыг төвлөрүүлэх болон хичээлийн төгсгөлд дүгнэх байдлаар хэрэглэхэд тохиромжтой.

4. Хичээлийн үнэлгээ

Үнэлгээний зорилго

Төрийн онол хичээлийн явцад олж авсан мэдлэг, түүнийг практикт ашиглах чадвар хийгээд оюуны үнэт зүйлийн баримжаалалтад гарсан өөрчлөлтийг бодитойгоор үнэлэхэд уг хичээлийн үнэлгээний гол зорилго оршино. Үнэлгээ нь бүхэлдээ зорилгодоо хүрч чадсан эсэхийг илрүүлэхэд чиглэгдэнэ.

Багш үнэлгээний дүнг дараах зорилгоор ашиглана:

- давтан судлах шаардлагатай эсэхийг тогтоох сурч боловсрох эрмэлзлэлийг идэвхжүүлэх
- сургалтын үр дүнд хүрэн явцад оюутны мэдлэг, чадвар ямар түвшинд байгааг тодорхойлох
- багш өөрийгөө болон хичээл зорилгодоо хүрсэн эсэхийг үнэлэх.

Үнэлгээний шалгуур

Үнэлэх зүйл	Үнэлэх жишиг шалгуур
Мэдлэг	❖ тодорхой асуултад ардчилал, эрх зүйт ёс, иргэний эрх, үндсэн хуульт ёсны онолын үндэслэлүүдийг ашиглан хариулж чадаж байгаа эсэх ❖ эрх зүйн онолын мэдлэгээ бусдад танилцуулж, тайлбарлаж чадаж байгаа эсэх ❖ тухайн судлагдахууны тодорхойлолт гаргах, үндсэн ба үндсэн бусыг ялгах, харьцуулалт хийх, хамаарлыг тогтоох арга зүйг эзэмшсэн эсэх. ❖ хариулт болон үзэл бодлынхоо онолын болон практик үндэслэл нотолгоог гаргаж байгаа байдал
Чадвар	❖ тодорхой онолын мэдлэгийг ашиглан /үндэслэл, нотолгоо болгох, жишээ баримт татах, тайлбарлах/ тухайн асуудлыг тайлбарлаж, шийдвэр гаргаж чадаж байгаа эсэх ❖ бодлого бодох, тохиолдол шийдвэрлэхдээ эрх зүйн онолын мэдлэгээ ашиглаж чадаж байгаа эсэх ❖ баримт бичиг боловсруулах чадварт суралцсан байдал амаар болон бичгээр өөрийгөө илэрхийлэх чадварын хөгжлийн түвшин
Хандлага	❖ өөрийн үзэл бодол байр суурь, үнэлгээ дүгнэлтийг илэрхийлж чадаж байгаа эсэх, ийнхүү илэрхийлэхдээ бусдын үзэл бодол, байр сууринд хүндэтгэлтэй хандаж, түүнээс үнэ цэнэтэй зүйлийг олж харж, авч чадаж байгаа эсэх ❖ багийн гишүүн байх, бусдыг төлөөлөх чадварын хөгжилт ❖ ялгаатай үзэл бодол байр сууринд хандах хандлага, түүнийг хүлээн зөвшөөрч байгаа байдал

Дээрхээс гадна оюутны мэдлэг, чадварын түвшнийг дараах байдлаар ангилан, үнэлгээг ялгавартай тогтоож байх нь зүйтэй. Үүнийг хамгийн энгийн буюу доод түвшнээс хамгийн төвөгтэй буюу дээд түвшинд хүрэх дарааллаар тодорхойлж болно.

Мэдлэг. Хамгийн доод түвшин. Голчлон тодорхой баримт, мэдээллийг тогтоож авах, сэргээн санах чадварыг авч үзнэ.

Ойлгоц. Өөрөө анхлан сэдэж олсон бус, өөрөөр хэлбэл, бусдын олж тогтоосон зүйлсийг оюутан наад захын түвшинд ойлгосон болохыг харуулж буй тайлбарлах, өөрийн үгээр илэрхийлэх, ургуулан бодож дүгнэлт хийх зэрэг чадвар юм.



Хэрэглээ. Оюутан мэдэж авсан ойлголт, зүй тогтол зэргийг урьд тохиолдож байгаагүй шинэ нөхцөл байдал, мөн практикийн тодорхой тохиолдолд хэрэглэх чадвар.

Анализ. Мэдээллийг бүрэлдэхүүн хэсгүүдэд нь задлан хувааж, ялгаж зааглахыг хэлнэ.

Синтез. Бүрэлдэхүүн хэсгүүдийг нэгтгэн бүхэл зүйл бий болгохыг хэлнэ. Оюутан урьд нь байгаагүй бүтцийн шинэ хувилбарыг бүтээх чадвартай байх ёстой.

Үнэлэлт. Хамгийн дээд түвшин. Бусдын бүтээсэн зүйл, түүний логик бүтэц, үүдэслэл нотолгоо нь бүрэн гүйцэд хийгдсэн эсэхэд үнэлгээ өгөх зэргийг ойлгоно.

Дээрх чадварын түвшинг дотор нь дараах байдлаар ангилж болно. Үүнд:

Сургалтын зорилго	Оюутны чадвар
Заавал эзэмшсэн байвал зохих /essential/	Мэдлэг, ойлгоц, хэрэглээ
Эзэмшсэн байвал сайшаалтай /desirable/	Анализ, синтез, үнэлгээ

ТӨРИЙН ОНОЛ ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА

I бүлэг. ЕРӨНХИЙ ОНОЛ

1. Төрийг судлах арга зүй

Төр бол нэг талаас нийгтийн бодит үзэгдэл, бэлэн оришиж буй факт, нөгөө талаас байх ёстой хэм хэмжээ бүхий эрх зүйн үзэгдэл мөн.

Профессор Н.Лүндэндорж

Төрийг судлах шаардлага, ач холбогдол



Эрх зүйг төрөөс хамгаалж, бас хэм хэмжээний хэлбэрт оруулан хууль баталж байдаг хэдий ч ямар эх сурвалжид тулгуурлаж буйгаас хамаарч зохицуулалтын арга, механизм нь харилцан адилгүй. Зарим төр иргэдээ хувийн өмчтэй байхыг зөвшөөрч, тэр эрхийг хуулиар хамгаалж байхад, зарим нь хориглож байх жишээтэй. Тэгвэл ямар нь хамгаалж, ямар нь хориглож байдгийг ойлгох, түүний учир шалтгааныг тогтоох шаардлагатай. Энэ зүй тогтлыг ойлгох нь **хууль зүйн шинжлэх ухаанд** хөл тавих эхлэл мөн.

Тэгэхлээр, төрийн онолыг судалснаар хууль зүйн шинжлэх ухааны тулгын гурван чулуу болсон **"Эрх зүй", "Эрх зүйн хэм хэмжээ", "Төр"** гэсэн нэр томъёогоор тэмдэглэсэн үзэгдлийн шалтгаант холбооны зүй тогтлыг ойлгох, улмаар хууль зүйн практикт түүний илрэх арга, хэлбэрийг танин мэдэх, тайлбарлах, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тандах онол, арга зүйг эзэмшинэ.

Төрийг байгаа зүйлийн хувьд судлах нь

Эдүгээ төрийг **байгаа** болон **байх ёстой** зүйлийн үүднээс судлах хандлага давамгайлж байна. Төрийг байгаа зүйлийн хувьд судална гэдэг нь бодитой байгаа факт, түүний үүсэл, хөгжлийн зүй ёсны шалтгаант холбоог эрж хайна гэсэн үг. Үүний тулд нийгэм, хүмүүнлэгийн ухаан, байгалийн шинжлэлийн ололт, хууль, зүй тогтолд тулгуурлан, хүн, байгалийн салшгүй холбооноос эх үндсээ авсан соёл иргэншлийн онол, арга зүйг ашиглана.

Төрийг **нийгмийн бодит үзэгдэл** хэмээн судлахдаа иргэний нийгэм, төрийн дотоод шалтгаант холбооны эх сурвалжид гол анхаарал хандуулна. Нийгэмд төр, түүний эрх мэдэл, албадлага орших зайлшгүй шаардлага, хүчин зүйл, эх сурвалжийг нийтлэг болон хувийн ашиг сонирхлын ялгаа, тэдгээрийг төлөөлсөн иргэний болон улс төрийн нийгэмлэг, хүний мөн чанар, хүсэл зориг, сэтгэлгээний хэв шинж, иргэншил, соёлын онцлогтой холбон судална.

Төрийг байх ёстой зүйлийн хувьд судлах нь

Байгаа төрийн бодит фактад тулгуурлан байх ёстой төрийг улс төр, хууль зүйн үнэт зүйлийн хэм хэмжээнд (Basic Norm) тулгуурлан бас судалдаг. БАЙХ ЁСТОЙ ЗҮЙЛ гэдэг бол ямар нэг субъектын хүсэл зориг, дур зоргын хэм хэмжээ биш. Энэ бол тухайн үеийн хүний танин мэдэхүйн хүрсэн төвшингээр хязгаарлагдан тогтсон суурь хэм хэмжээ (Basic Law)-г хүлээн зөвшөөрч, баримтлал болгох явдал мөн.



Төрийн бодит ахуй буюу хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлээр илрэн хэрэгжиж байгаа эрх зүйн тогтолцооны бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн агуулгын болон хэлбэрийн эх сурвалжийг байх ёстой зүйлийн үүднээс хэм хэмжээчлэн судална. Энэ нь байгаа хууль зүйн хэм хэмжээнд байх ёстой хэм хэмжээ хэрхэн тусгалаа олсныг нээн тогтоох замаар байх ёстой зүйлийг олоход чиглэнэ гэсэнүг.

Үндсэн хуульт төр ёсны орчин үеийн онолоор хууль зүйн хэм хэмжээний байх ёстой суурь зарчим, хэм хэмжээ Үндсэн хуульд тусгалаа олсон байх тул төрийн бүтэц, чиг үүргийг **үндсэн хуулийн үзэл санаа, тулгаар зарчмыг** судлах хандлага өдгөө давамгайлж байна.



Хяналтын асуулт

- ❖ Төрийг байгаа зүйлийн хувьд судлахын ач холбогдлыг тодорхой жишээн дээр тайлбарлана уу.
- ❖ Орчин үеийн төр судлалд төрийг байх ёстой зүйлийн үүднээс тайлбарлах хандлага хүчтэй байгаагийн шалтгааныг эргэцүүлнэ үү?
- ❖ Аливаа Үндсэн хуулийг байгаа зүйл гэж ойлгох уу? Байх ёстой зүйл гэж ойлгох уу?



Сорил

1. Соёл иргэншлийн онол, арга зүй нь төрийг:
 - a. Байх ёстой зүйлийн хувьд судална
 - b. Байгаа зүйлийн хувьд судална
 - c. Аль алинаар нь судална
 - d. Зөв хариулт алга байна
2. Нормативизм нь төрийг:
 - a. Байгаа зүйлийн хувьд судална
 - b. Байх ёстой зүйлийн хувьд судална
 - c. Аль алинаар нь судална
 - d. Зөв хариулт алга байна

2. Төрийн тухай төсөөллийн хувьсгал, хөгжил

Орчин үеийн либерал ардчилал, дарангуйлал, цэргийн дэглэм, хаант засаг гээд янз бүрийн дэглэмд амьдарч буй хүмүүсийн зарим нь чөлөөт зах зээлийг дэтгэдэг байхад зарим нь үйлдвэрлэл, хуваарилалтын хамтын хэлбэрийг дэмжинэ. Энэ бүхэн дээр коммунизм хийгээд утопи үзлийг багтаасан янз бүрийн үзэл, онолыг нэмэх юм бол төр гэдэг зүйлийн талаар нийтлэг зүйл огтоос үгүй, тодорхойлох аргагүй эрээвэр хураавар зүйл болно.

Жоннатон Вольф

Төрийн тухай ойлголт нарийн төвөгтэй болох нь

Төрийг хүн бүр төсөөлдөг. Гэвч нийтээр хүлээн зөвшөөрсөн түгээмэл тодорхойлолт өдгөө хүртэл үгүй байна. Тийм учраас хүмүүс физик, хими, биологи гэж юу вэ гэж асуудаггүй атлаа төр гэж юу вэ хэмээн бие биеэс асуусаар иржээ. Энэ нь уг үзэгдлийн нарийн төвөгтэй, олон шинжлэх ухааны мэдээлэл, судалгаа шаарддагийн нэгэн илрэл. Энэ нь дараахь хүчин зүйлтэй холбоотой:

1. Үе үеийнхэн түүхэн ахуй, цаг, иргэншил, соёлоо тусгасан ертөнцийг үзэх үзэлтэй,
2. Төр байнга хувьсан өөрчлөгддөг, олон талт үзэгдэл,
3. Төрийг ойлгох, түүнд хандах улс үндэстний сэтгэлгээний арга, соёл янз бүр.

Төрийг гадаад дүр төрхөөр нь тодорхойлох нь

Төрийг үе үеийн сэтгэгчид танин мэдэхүйн хүрсэн төвшиндөө ахуй, цагийн агшинг тусган тодорхойлохыг оролдсоор иржээ. Тухайлбал, Аристотель Улс төр зохиолдоо төрийг улс төрийн харьцахуй (общение) гэж тодорхойлсон. Тэрээр иргэд сайн сайхан амьдралын төлөө улс төрийн харилцаанд нэгдэж, зохион байгуулалт бүхий амьдралын хэв шинжид орсныг улс гэж үзэж байсан.

Төрийг иргэдийн холбоо, нэгдэл, зохион байгуулалт гэж үзэж байсан энэ төсөөлөл Европын улс төрийн сэтгэлгээний хэв шинжид хүчтэй нөлөөлж, улмаар төрийг улс төрийн байгууллага, хүмүүсийн онцгой төрлийн холбоо (илрэх гадаад дүр төрхөөр нь) гэж үзэх үзлийн хөрс суурь болсон байна. Английн сэтгэгч Ж.Локк Удирдлагын тухай хоёр номлол бүтээлдээ "Би төр гэдэг ойлголтын дор ардчилал болон удирдлагын ямар нэгэн хэлбэрийг бус, харин латин хэлний "civitas" гэсэн үгээр тэмдэглэсэн аливаа хараат бус нийгэмлэг (any independent community)-ийн тухай ямагт эргэцүүлэн бодож байлаа. Энэ үг манай хэлний "common wealth" гэсэн үгтэй илүү тохирч байгаа бөгөөд энэ ойлголт хүмүүсийн нийгэмлэгийг бүр ч тод ил эрхийлж байгаа юм" гэжээ. Дээр дурьдсан сэтгэгчид төрийг улс төрийн нийгэмлэг, холбоо, нэгдэл гэснээс цааш нарийсч түүний дотоод бүтэц, институт, элементийг төдийлөн шинжлээгүй юм.

Төрийг институтчилэх хандлага

Ж.Бодены үеэс Францын төр судлаачид төрийг нэгдэл, холбоо гэх нь тийм ч оновчтой биш, харин түүнийг бүрдүүлэгч тогтолцооны элементээр дамжуулж судлах хэрэгтэй гэсэн үзэл санааг дэвшүүлсэн юм. Төрийг зөвхөн улс төрийн нэгдэл холбоо гэх үзлээс улс төрийн сэтгэлгээ нэг алхмаар урагшилж, **инстучилэх**



хандлага (төрийн тэргүүн, дээд байгууллага, удирдах хэсэг гэх мэт) бий болсон нь төр судлалд ихээхэн дэвшил болсон. Т.Гоббс Левиафан зохиолдоо "хүмүүсийг айлган барьж нийтийн үйл хэрэгт үйл ажиллагааг чиглүүлж, нийгмийн орчинд тэднийг дасган журамлахын тулд нэг хүн эсвэл байгууллагад онцгой эрх мэдэл, хүчийг төвлөрүүлэх замаар нийтийн эрх мэдлийг бий болгож болно. Тиймээс нэг этгээдийн гарт олон хүнийг ийнхүү нэгтгэснийг төр (civitas) гэж нэрлэж болно" гэж институтчилэх хандлагыг цааш хөгжүүлсэн байна.

Төр бол эрх зүйт хуулинд захирагдсан хүмүүсийн нэгдэл

И.Кант "Төр бол эрх зүйт хуулинд захирагдсан хүмүүсийн нэгдэл" гэсэн тодорхойлолтыг анх өгсөн. Тэр ч байтугай хамгийн реалист үзэлтэн болох Гумплович ч төрийг "Тодорхой эрх зүйт дэг журмыг сахиулж байхын тулд жам ёсоор үүсэн гарч ирсэн эрх мэдлийн байгууллага" мэтээр тодорхойлж байв. Ер нь төрийн тухай ойлголтын суурь болгож эрх зүйт төрийг авч үзэж байсан нь XIX зууны сүүлч, XX зууны эхэн үеийн гол хандлага байлаа. Энэхүү хандлага өдгөө ч ач холбогдолтой хэвээр байна.



Хяналтын асуулт

- ❖ Төрийн тухай тогтсон томъёолол бий болгож болох уу? Үндэслэлийг тайлбарлана уу.
- ❖ Төрийг гадаад дүр төрхөөр болон институтчилэн тодорхойлохын ялгаа юунд орших вэ?
- ❖ Төрийг байнга хувьсан өөрчлөгдөж байдаг зүйл гэж ойлгож болох уу? Төрд өөрчлөгдөшгүй тогтвортой шинж бий юу?



Сорил

1. "Төр бол эрх зүйт хуулинд захирагдсан хүмүүсийн нэгдэл" гэдэг нь:
 - a. Аль нэг түүхэн хэв таягаар нь тодорхойлох хэтэрхийлэл
 - b. Аль нэг элементээр нь тодорхойлох хэтэрхийлэл
 - c. Төрийг байх ёстой талаас нь тодорхойлох хэтэрхийлэл
 - d. Зөв хариулт алга байна
2. Төрийг Н₂О шиг хатуу томъёолох бололцоо бий юу?
 - a. Тийт
 - b. Үгүй
 - c. Ардчилсан төрд л болно
 - d. Хаант төрд л болно

3. Төрийг тодорхойлох орчин үеийн хандлагууд

*Төр бол хууль ёсны хүчийг бүрэн эзэрхсэн нийгмийн дотор оршиж буй улс
төрийн эрх тэдлийн зохион байгуулалт мөн.*

Макс Вебер

Төр бол эрх зүйн дэг журам.

Ханс Кельзен

Төрийн тухай ойлголтын агуулга

Орчин үед төр гэсэн нэр томъёог дараах агуулгаар хэрэглэж байна:

1. Нийтлэг эрх мэдэлд нэгдсэн, тодорхой нутаг дэвсгэрт амьдарч байгаа хүмүүсийн нийлбэр;
2. Нийтлэг эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа байгууллага, албан тушаалтны тогтолцоо;
3. Улс төрийн нийтлэг эрх мэдлийн захирах захирагдах харилцаа;
4. Хүн ам, нутаг дэвсгэр, үр нөлөө бүхий засгийн газартай бүрэн эрхт, тусгаар тогтносон эрх зүйн этгээд.

Социологийн хандлага

Улс төрийн нийтлэг эрх мэдлийг төрийн гол эх сурвалж гэж үзэж, түүгээр дамжуулан төрийн мөн чанарыг судалж, тодорхойлдог. Тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд хүн амыг бүрэн эрхтэй, хууль ёсоор захирахулс төрийн нийтлэг эрх мэдлийн хүч, түүний зохион байгуулалтыг төр гэж үздэг. Социологийн хандлага улс төрийн нийтлэг эрх мэдлийн гол мөн чанарыг хүч, албадлага гэж үздэг. Зохион байгуулсан хүч буюу төр бүх нутаг дэвсгэр, хүн амыг бүрэн хамарч, нийтийн үйл хэрэг, бусдын эрх чөлөө, дэг журмыг шаардлагатай үед хүч, албадлагаар хамгаалдаг хамгийн хүчтэй эрх мэдэл мөн.

Хууль зүйн хандлага

Тодорхой нутаг дэвсгэрийн хүрээнд дээд эрх мэдлийг тогтоосон корпорацийг төр гэж үздэг үзлийн онол, арга зүйд тулгуурлан хөгжсөн. "Төр - нийгмийн үзэгдэл" гэсэн ойлголтод тулгуурласан социологийн хандлага төрийн тухай ойлголтын төвд **хүмүүсийн холбооны нэгдлийг** тавьдаг бол "төр - эрх зүйн үзэгдэл" гэсэн ойлголтод үндэслэсэн хууль зүйн хандлага төрийн тухай ойлголтын төвд **хүмүүсийн нэгдлийн эрх зүйн дэг журмын харилцааг илэрхийлсэн хууль зүйн хэлбэрийг** гол эх сурвалж болгодог. Хууль зүйн хандлага дотроо сонгодог, легист гэх мэт чиглэлтэй.

Сонгодог хандлага

Хүн ам, нутаг дэвсгэр, нийтлэг эрх мэдэл гэсэн гурван үндсэн шинжийг төрийн үндсэн эх сурвалж гэж үздэг. Энэхүү гурван үндсэн шинжээр төрийг тодорхойлох хандлага өдгөө төр, эрх зүйн шинжлэх ухааны гол номлол болж байна.



Легист хандлага

ХІХ зууны сүүлчээр Германд үүсэж, ХХ зуунд Г.Кельзен хөгжүүлж, өдгөө өрнөдийн оронд нэлээд дэлгэрсэн чиглэл юм. Тэрбээр **төрийг харьцангуй төвлөрсөн эрх зүйн дэг журам** гэж тодорхойлсон.



Хяналтын асуулт

- ❖ Легист хандлагаар “хууль=төр” гэж ойлгож болох уу?
- ❖ М.Веберийн “төр бол хууль ёсны хүч” гэснийг гартаа буу барьсан дээрэмчний тушаалаас хэрхэн ялгах вэ?
- ❖ Төрийн хүлээн зөвшөөрөгдөх байдлыг хууль зүйн болон социологийн хандлагын үүднээс тайлбарлана уу?



Сорил

1. Социологийн хандлагын төлөөлөгч Макс Вебер төрийг дараахь байдлаар тодорхойлсон.
 - a. Эрх зүйн дэг журам
 - b. Байгууллага, албан тушаалтны тогтолцоо
 - c. Хууль ёсны хүч
 - d. Объектив суртахууны дээд хэлбэр
2. Хэн нь төрийг харьцангуй төвлөрсөн эрх зүйн дэг журам гэж үзсэн бэ?
 - a. М.Вебер
 - b. Г.Гегель
 - c. Р.Моль
 - d. Х.Кельзен
3. Төр судлалд “Гурван элементийн сургааль” гэж алдаршсан нь
 - a. Легист хандлага
 - b. Сонгодог хандлага
 - c. Социологийн хандлага
 - d. Аль нь ч биш

Семинар 1. Төр байгаа зүйл үү? Эсхүл байх ёстой зүйл үү?

Маргаантай асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэх

1. Хүмүүсийг БАЙГААГААР нь, хууль дүрмийг БАЙЖ БОЛОХУЙЦААР нь авч үзэхдээ иргэний дэг журат дотор баталгаатай, хууль ёсны захиргааны ямар нэгэн дүрэм журам байж болох эсэхийг эрж хайхыг хүснэм.

Шударга ёс болон ашиг тустай байх явдлыг бие биенээс нь огтхон ч ялган салгахгүйгээр эрхийн дагуу эдлэх ёстой зүйл болон агийг сонирхлын дагуу хүсэж байгаа зүйл хоёр өөр хоорондоо уялдаатай эсэхийг энэхүү эрэл хайгуулаараа тодруулахыг хүснэм.

Ж.Ж.Руссо Нийгмийн гэрээ ба улс төрийн эрхийн зарчмууд зохиолоос...

- ❖ Норматив болон дискриптив арга зүйн үүднээс Ж.Ж.Руссогийн "Нийгмийн гэрээ ба улс төрийн эрхийн зарчмууд" зохиолд анализ хийнэ үү?
- 2. Англид бичмэл Үндсэн хууль байхгүй. Харин түүнийг 1215 оны Магна Харт, 1628 оны Эрхийн Петици, 1679 оны Хабееус Корпус акт, 1689 оны Эрхийн Билль цогцоороо илэрхийлдэг байна.
- ❖ Байх ёстой төрийг гагцхүү бичмэл Үндсэн хуультай холбон тайлбарлаж болох уу?
- ❖ Таны бодлоор Английн үндсэн хуульт ёсыг ямар арга зүйгээр судлах вэ?
- 3. Монгол улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 1-д: "Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ" гэж заасныг судлах нь аль арга зүйд хамаарах вэ? Үндэслэлийг тайлбарлана уу?



Анхаарах зүйл

- 1) Холбогдох эх сурвалж материалыг олж цуглуулах
- 2) Өгөгдсөн мэдээлэлтэй сайтар танилцах
- 3) Эх зохиол болон бусад эх сурвалжийг заавал ашиглах
- 4) Монгол улсын Үндсэн хуулийн онолын тайлбаруудыг олж унших


4. Төрийн шинж, эрх мэдэл, зорилго

Төрийн шинжийг бүрдүүлж байгаа хүн ам нутаг дэвсгэр, нийтлэг эрх тэдэл бол төр улс орших үндэс мөн.

Георги Еллинек

Нутаг дэвсгэр

Төрийн нэг гол шинж бол төрийн бүрэн эрх мэдэлд хамаарах орон зай буюу нутаг дэвсгэр юм. Төрийн нутаг дэвсгэрийн ХУУРАЙ ГАДАРГУУН хэсэгт эх газар, арал ба анклав (бусад улсаар тойрон хүрээлэгдсэн далайд гарцгүй тухайн улсын нутаг дэвсгэр) багтдаг.





Хуурай болон усан хэсгийн дээрх агаарын орон зай нь улсын нутаг дэвсгэрийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд түүний дээд хилийг олон улсын эрх зүйд одоогоор нэг мөр тогтоогоогүй байна.

Нутаг дэвсгэртэй адилтгах объект

Тухайн улсын далбаа буюу онцлох тэмдэг бүхий усан болон агаар, сансрын хөлөг онгоц ба станц, усан доорхи холбооны шугам, хоолой, тухайн улсын нутаг дэвсгэрт оршдоггүй (далай, сансар гэх мэт) бусад объект багтдаг

Хүн ам

Нийтлэг ашиг сонирхлоороо нэгдсэн захирах, захирагдах харилцаанд орших хүмүүсийн нийлбэр цогц мөн. Хүн амын бүрэлдэхүүнд тухайн улсын харъяат болон харъяат бус (гадаадын байнга, түр оршин суугч, цагаач гэх мэт) хүмүүс багтана. Хүн ам ийм өргөн бүрэлдэхүүнтэй учраас "ард түмэн" гэсэн ойлголтоос өргөн агуулгатай.



Нийтлэг эрх мэдэл

Нийтлэг эрх мэдэл нь улс төрийн эрх мэдлийн дээд хэлбэр мөн. Энэ эрх мэдлийг зөвхөн төр хэрэгжүүлдэг учраас төрийн сачшгүй шинжид хамаарна. Төрийн эрх мэдлийг нийтлэг гэж тодотгохын хууль зүйн үндэс нь:



1. Нийт нутаг дэвсгэр, хүн амыг бүрэн хамардаг,
2. Нийтийн өмчид тулгуурлан эрх мэдлээ хэрэгжүүлдэг,
3. Нийтлэг эрх ашгийг илэрхийлэн хамгаалдаг,
4. Нийтээр дагаж мөрдөх эрх зүйн хэм хэмжээг тогтоож, биелүүлж, хамгаалдаг,
5. Нийт хүн амаар хүлээн зөвшөөрөгдсөн (арга нь янз бүр байж болно) байдаг,
6. Нийт улс үндэстнийг дотоод, гадаад бүрэн эрхтэй төлөөлдөгт оршино.

Төрийн эрх мэдлийг дараагийн бүлэгт дэлгэрүүлэн авч үзэх болно. Төрийн шинж (хүн ам, нутаг дэвсгэр, нийтлэг эрх мэдэл) бол эрх зүйн байдлыг нь үндэсний болон олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн эрх зүйн зарчим, хэм хэмжээгээр тодорхойлж, хамгаалж, зохицуулж байдаг үндэсний болон олон улсын эрх зүйн нэн чухал объект мөн.

Төрийн эрх мэдэл, түүний эх сурвалж

Төрийн эрх мэдлийн эх сурвалж нь ард түмний хүсэл зориг байх ёстой. Ард түмэн сонгож байгуулсан төрийн байгууллагын бүтцээр дамжуулж хүсэл зоригоо хэрэгжүүлнэ. Тийм учраас төрийн эрх мэдэл бол төлөөлөх ардчиллын зарчмаар ард түмнээс Үндсэн хуулийн дагуу шилжүүлсэн эрх мэдэл мөн. Эл үзэл санаа анх Францын хувьсгалаас төрөн гарч "Засгийн бүх эрх ард түмний мэдэлд" гэсэн зарчмаар ардчилсан дэглэмтэй бүхий л улсын Үндсэн хуульд хэлбэршсэн байна.

Төрийн зорилго

Төрийн зорилго гэсэн ойлголтыг дараах гурван өөр төвшинд авч үздэг. Нэгдүгээрт, хүн төрөлхтний хувьсан өөрчлөгдөж байгаа харилцааны өмнө тавьж буй зорилго. Хоёрдугаарт, түүхэн үйл явцаас хамааран тухайн төр улсын өмнө бий болж буй зорилго. Гуравдугаарт, тухайн эрин үед иргэд, нийгмийн өмнө тавьж буй зорилго зэрэг болно.



Хяналтын асуулт

- ❖ Нутаг дэвсгэрт юу хамаарах ба түүний хилийг хэрхэн тогтоох вэ?
- ❖ “Газрын хэвлий”, “Нутгийн ус” гэсэн ойлголтуудыг олон улсын нийтийн эрх зүйн үүднээс тайлбарлана уу?



Сорил

1. Нутаг дэвсгэрийн хил хязгаарыг тогтооно.
 - a. Нэг талын хүсэл зоригоор
 - b. Нийтээр хүлээн зөвшөөрсөн зангилын дагуу
 - c. Олон улсын гэрээгээр
 - d. Үндэсний эрх зүйгээр
2. Эх газрын хормой нь
 - a. Нээлттэй тэнгисийн бүрдэл хэсэг
 - b. НҮБ-ын дүрмээр зохицуулагдана
 - c. Далайн эргийн улсын нутаг дэвсгэрт багтана
 - d. Далайд гарцтай улсуудын эзэмшил

Семинар 2. Нутаг дэвсгэр, хүн, ам нийтлэг засаг яагаад чухал вэ?

Харьцуулан шинжлэх арга

Төрийн үндсэн шинж, түүний бүрдэл	
Проф Н.Лүндэндорж	Проф Ц.Сарантуяа
1. Нутаг дэвсгэр ❖ Агаарын орон зай ❖ Газрын хэвлий ❖ Усан гадаргуу ❖ Хуурай гадаргуу ❖ Нутаг дэвсгэртэй адилтгах объект	1. Нутаг дэвсгэр ❖ Агаарын орон зай ❖ Нутгийн ус ❖ Хуурай газар ба усан зам ❖ Газрын хэвлий
2. Ард түмэн ❖ Төрснөөр ❖ Үүсмэлээр	2. Ард түмэн ❖ Нутаг дэвсгэрийн зарчим ❖ Ураг төрлийн зарчим



3. Нийтлэг эрх мэдэл

- ❖ нийт нутаг дэвсгэр, хүн амыг бүрэн хамардаг,
- ❖ нийтийн өмчид тулгуурлан эрх мэдлээ хэрэгжүүлдэг,
- ❖ нийтлэг эрх ашгийг илэрхийлэн хамгаалдаг,
- ❖ нийтээр дагаж мөрдөх эрх зүйн хэм хэмжээг тогтоож, биелүүлж, хамгаалдаг,
- ❖ нийт хүн амаар хүлээн зөвшөөрөгдсөн байдаг,
- ❖ нийт улс үндэстнийг дотоод, гадаад бүрэн эрхтэй төлөөлдөгт оршино.

3. Төрийн засаг

- ❖ Төвлөрүүлэн хуваарилах
- ❖ Ардчилсан байдлаар хуваарилах



Анхаарах зүйл

- 1) Нийтлэг болон ялгаатай байр суурийг тодруулах
- 2) Агуулгын хувьд адил боловч нэр томъёоны хувьд өөр зүйл байгаа эсэхийг нягтлах
- 3) Нутаг дэвсгэр, хүн ам, нийтлэг засаг яагаад чухал болохыг тайлбарлах

5. Төр үүсэх, үгүй болох үндэслэл

Бусдын зүгээс ирэх халдлагаас өөрийгөө хамгаалах нь хүмүүний үндсэн хэрэгцээ юм. Энэхүү хэрэгцээ л төрийг бий болгосон.

Томас Хоббс

Нийгмийн гэрээ гэдэг бол харилцан ашигтай хамтын ажиллагаа бөгөөд түүн дээр улс төрийн тогтолцоо суурилах ёстой.

Жон Локк

Бидэнд эрх чөлөө, ёс зүй, сайн дурын хамтын ажиллагаа байхад төр засаг, хууль, шүүх хэрэггүй.

Петер Кропоткин

Төрийн үүслийн агуулга

Төрийн үүсэл" гэсэн ойлголт хоёр үндсэн агуулгатай. НЭГДҮГЭЭРТ, төр анх хэрхэн, яаж үүссэн тухай түүхэн эхлэлийг, ХОЁРДУГААРТ, иргэншсэн үед шинэ төр улс үүссэн гэж үзэх үндэслэлийг илэрхийлдэг. Нийгэм, хүмүүнлэгийн бүх шинжлэх ухаан төрийн үүслийг энэ ӨРГӨН УТГААР хэм хэмжээний бус



хандлагаар, төр хэзээ, ямар учир шалтгаан, хүчин зүйлийн нөлөөгөөр анх үүссэн байж болохыг судалдаг. Хоёр дахь агуулгаар буюу ЯВЦУУ УТГААР хууль зүйн шинжлэх ухаан, түүний дотроос төрийн болон олон улсын нийтийн эрх зүйн ухаан хэм хэмжээний хандлагаар төр үүссэн гэж үзэх үндэсний хийгээд олон улсын эрх зүйн номлол, хэм хэмжээг үндэс болгон судална.

Анархизм

Төр оршин байсан эсэх талаар өдгөө хоёр үзэл хандлага дэлхий дахинд түгээмэл байна. Нэгдүгээрт, хүмүүс үргэлж төртэй байгаагүй гэдэг үзэл (Анархизм), Хоёрдугаарт, төр угаас байсан, хүний оршихуйн баталгаа, төрөлх зүйл гэсэн үзэл баримтлал (Нийгмийн гэрээний онол). Анархистуудын үзлээр хүн төрөлхтөнд эрх чөлөө, тэгш эрх, тэдний амьдрал дахь эелдэг зан харьцаа байхад хууль, төр засаг хэрэггүй. Учир нь амьд амьтад, түүний дотор хүн ч гэсэн угаасаа бие биедээ "харилцан туслах" шинжтэй байдаг.

Байгалийн захиргаа

Байгалийн захиргааны үе бол улс төрийн нийтлэг бий болохоос өмнөх амьтны төрөлх араншин, зөн билэгт тулгуурласан цусан төрлийн холбоо бүхий овгийн зохион байгуулалт юм. Ийм нийгмийн тухай Т.Гоббс "Левиафан" зохиолдоо "Тэр үед үр ашиг нь тодорхой биш учир үйлдвэрлэл үгүй, газрыг боловсруулдаггүй, далай тэнгисээр аялах арга, ухааныг олоогүй, барилга байгууламж, хот суурин, хөгжил цэцэглэлт, дэлхийн тухай мэдлэг үгүй, цаг барьдаггүй, хамгийн аймшигтай нь мөнхийн дайсагнал, айдас хүйдэс, хүний амьдрал ядуу, ой гутам" байсан гэжээ.



Нийгмийн гэрээ

Төр бол ганц нэгээрээ бас дээр нь өөрийн эрхээр амьдарч байвч үргэлжийн дайн самуун, нэгэнт баталгаажуулаагүй болохоороо ямар ч үр ашиггүй эрх чөлөөнөөс залхсан хүмүүсийн нийгэмд нэгдэх гэрээ мөн.

Төрийн үүслийн асуудалд

Олон улсын эрх зүйн үүднээс хандах нь



Шинээр үүссэн төрийг бүрэн хэмжээгээр, албан ёсоор хүлээн зөвшөөрөхийг DE JURE гэнэ. Энэ нь хүлээн зөвшөөрөх олон улсын практикийн сонгодог хэлбэр. DE JURE хүлээн зөвшөөрөлтөөр холбогдох улстай дипломат, консулын болон бусад албан ёсны харилцаа бүрэн хэмжээгээр тогтоох боломж нээгддэг. Хэсэгчлэн хүлээн зөвшөөрөхийг DE FACTO гэнэ. Аливаа улсууд харилцан бие биенээ хүлээн зөвшөөрөх сонирхолгүй боловч, ямар нэг асуудлыг шийдвэрлэхийн тулд түр зуур албан ёсоор хүлээн зөвшөөрөхийг AD HOC гэнэ.



Төрийн үүслийн тухай орчин үеийн хандлага

Орчин үеийн төр судлал төрийн үүслийг бүхэлд нь тайлбарлах нэгдмэл онол боловсруулах бололцоогүй гэсэн дүгнэлтэд хүрээд төрийн үүсэл, хөгжилд харьцангуй түгээмэл нөлөөлсөн хүчин зүйлийг тодруулахыг зорьж байна. Үүнд:

- Экологийн хүчин зүйл
- Хүн ам зүйн хүчин зүйл
- Нийгэм, эдийн засгийн хүчин зүйл
- Антропологийн хүчин зүйл

Төрийн үгүй болох үндэслэл

Төр үүссэн шиг бас үгүй болж болно. Байгалийн гамшгаар, гаднын түрэмгийллээр эсвэл өөр улсад сайн дураар нэгдсэн, нэгдэл холбоо задарснаар төрийн шинж (нутаг дэвсгэр, хүн ам, нийтлэг эрх мэдэл) алдагдсаныг төр үгүй болох гэнэ.



Хяналтын асуулт

- ❖ “Анархизм” = “Хаос байдал” гэж ойлгож болох уу? Үндэслэлийг тайлбарлана уу?
- ❖ 1924 онд Ардын хувьсгал ялж, анхдугаар Үндсэн хуулиа баталжээ. Энэ нь аль ойлголтыг илэрхийлэх вэ?

6. Иргэний нийгэм төрийн суурь болох нь

Засгийн газар иргэний нийгмийг бус, харин иргэний нийгэм түүнийг нөхцөлдүүлнэ. Иргэний нийгмийн үндэс нь өмч мөн.


Жон Локк

Иргэний нийгэм нь хүний эрх чөлөөг хязгаарласан бүхний эсрэг зогсдог ертөнц мөн. Хүн бүрийн хувийн хүсэл зориг, эрх чөлөөг бусдынхтай хослуулах явдал нь түүний үндэс билээ.

Г.В.Гегель

Гэр бүл, бизнесийн бүлэглэл, төр засгаас ангид байдлаар үйл ажиллагаа явуулж буй институциудын нийлбэр цогц.

Civicus (Олон улсын иргэний нийгмийн байгууллага)



Иргэний нийгэм гэж юу вэ?

Иргэд хувийн ашиг сонирхлоо эрх зүйт, нийтлэг хуулийн хүрээнд чөлөөтэй хэрэгжүүлэх нээлттэй, олон ургальч, өөрөө хөгжих механизм бүхий орчин мөн. Үүний хамгийн жижиг, анхдагч орчин нь гэр бүл юм. Гэр бүлийн гишүүд өөр хоорондоо чөлөөтэй харилцаж амьдардаг шиг, иргэний нийгэмд иргэдийн үзэл бодол, өмч хөрөнгө, авьяас чадвар, эрх ашиг чөлөөтэй хэрэгжинэ. Ийм учраас иргэний нийгэм - эрх чөлөө, ашиг сонирхол, ардчилал хөгжих хөрс суурь мөн.

Иргэний нийгэм-эрх чөлөөний орчин

Эдийн засгийн хүрээнд хүн бүр өмчлөгч байх эрх нээгдсэн, өмчийн хэлбэрүүд чөлөөтэй, эрх тэгш байхыг хуулиар хамгаалсан, зах зээлийн харилцаа тогтсон, төрийн хууль бус оролцоог хориглосон байна. Социал хүрээнд иргэд нийгэмд эзэлсэн байр суурь, бүлэг давхраа, нас хүйс, яс үндэс, шашин суртлаас үл хамааран ашиг сонирхол, хэрэгцээгээ хангахын төлөө чөлөөтэй эрэл хайгуул хийх бүрэн эрх чөлөөтэй, нэр төртэй амьдрах бололцоог бүрдүүлсэн нийгмийн үр нөлөө бүхий бодлоготой байна. Улс төрийн хүрээнд үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй төдийгүй тийм бололцоог хангасан, эвлэлдэн нэгдэх, улс төрийн сонголт хийх, сонгох, сонгогдох эрхийг хэрэгжүүлэх хариуцлагатай улс төрийн харилцаа, соёл, эрх зүйн дэг журам бүрэлдсэн байхыг хэлнэ.

Иргэний нийгэм-эр зүйт, ардчилсан ёсны орчин

Хүний эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрөх төдийгүй, түүнийг хамгаалах, хэрэгжүүлэх механизмыг эрх зүйт хууль, ардчилсан аргаар бүрдүүлсэн байна.

Иргэний нийгэм-нээлттэй орчин

Олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн суурь зарчим, хэм хэмжээг хүндэтгэн биелүүлэх, тэр үндсэн дээр нээлттэй бодлого баримталж, дэлхийн улс түмэнтэй эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагаа явуулах, дотооддоо мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг бүрдүүлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө, оршин суух газраа сонгох, гадаадад явах, эх орондоо буцаж ирэх бололцоо бүхий байхыг ойлгоно.

Иргэний нийгэм-олон ургальч үзлийн орчин

Нэг үзэл суртал, номлол, нэг улс төрийн хүчний дангаар ноёрхох бололцоог хаасан, сэтгэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх хууль зүйн бололцоотой, сөрөг хүчний дуу хоолойг сонсдог, эрх ашгийг нь хуулиар хамгаалсан байхыг хэлнэ.

Иргэний нийгэм-өөрөө хөгжих механизм бүхий орчин

Хамгийн бага зохицуулалт бүхий төртэй, хууль ёсны аливаа санал, санаачилга, бие даасан байдал хэрэгжих эрх зүйн орчинтой, хувь хүнээс эхлэн төрийн болон төрийн бус аливаа байгууллага эрх зүйт хуулийн хүрээнд бие даан, хараат бус үйл ажиллагаа явуулах бололцоотой байхыг хэлнэ.

Иргэний нийгэм -Төрийн сөрөг хүч

Иргэний нийгэм, төр нэгдэлтэй оршихын хамт харилцан бие биеэ хянаж, тэнцвэржиж байдаг нийгмийн жам ёсны хоёр хүч мөн. Төрийг Левиафан (далайн домгийн амьтны нэр) болгочихгүй сөрөн зогсож чаддаг цорын ганц хүч нь ИРГЭНИЙ НИЙГЭМ юм.

Монгол улсын үндсэн хууль ба иргэний нийгэм

Монгол улсын анхны ардчилсан Үндсэн хуульд (1992) эх орондоо иргэний ардчилсан нийгэм цогцдуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно гэж заасан билээ. Үндсэн хуулийн энэ тунхаглал манай нийгмийн оюун санаа, эдийн засаг, социал, улс төрийн амьдралын бүхий л харилцааны хуучин зарчмыг эвдэж цоо шинэ дүр төрх, зохион байгуулалт, үзэл санааг нөхцөлдүүлсэн юм.



Хяналтын асуулт

- ❖ Яагаад хүчтэй иргэний нийгэм хэрэгтэй байдаг вэ?
- ❖ Ямар хүрээнд иргэний нийгэм засгийн газрын чиг үүргийг гүйцэтгэх вэ?
- ❖ Төрөөс иргэний нийгмийг хэрхэн дэмжих ёстой вэ?

Семинар 3. Иргэний нийгэм төрийн харилцаа

Яагаад модны арга

А. Иргэний нийгэм гэж юу вэ?

- ❖ Иргэний нийгэм - хувийн ашиг сонирхлыг илэрхийлж байдаг. Яагаад?
- ❖ Иргэний нийгмийн дайсан нь хувь хүний эрх чөлөө бус, харин төр засаг мөн. Яагаад?
- ❖ Иргэний нийгэм - төрийн сөрөг хүч болдог. Яагаад?
- ❖ Иргэний нийгэм - эрх чөлөөний орчин. Яагаад?
- ❖ Чөлөөт худалдаа иргэний нийгмийг хөхиүлэн дэмждэг. Яагаад?
- ❖ Иргэний нийгэм бүтцээрээ дарангуйлын тогтолцоог хааж байдаг. Яагаад?
- ❖ Иргэний нийгэм - иргэншлийн үр дүн мөн. Яагаад?
- ❖ Иргэний нийгмийн нэг гол үндэс нь иргэдийн эвлэлдэн нэгдэх эрх билээ. Яагаад?
- ❖ Иргэний нийгэм хүмүүсийн хоорондын итгэлцлийн хүрээг тэлж байдаг. Яагаад?

Б. Төрийн ажил уу? эсхүл иргэний нийгмийнх үү?

- ❖ “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 12-р зүйлд “Нутгийн захиргааны байгууллага гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулахдаа иргэдийг нийтийн эргүүлд гаргаж болно”.
- ❖ “Ой хээрийг түймрээс хамгаалах тухай” хуулийн 7.7-д "иргэн гарсан түймрийг унтраах ажиллагаанд иргэний журамт үүргийн дагуу оролцох үүрэгтэй".
- ❖ "Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай" хуулийн 7.1.3-т "малаа байнгын хариулга, манаатай байлгаж хулгайд алдахгүй байх бусад арга хэмжээг орон нутгийн болон улирлын онцлог, боломжид тохируулан авах үүрэгтэй".
- ❖ "Давс иоджуулж иод дутлаас сэргийлэх тухай" хуулийн 6.2.1 "иргэд хүнсэндээ иоджуулсан давс, бусад бүтээгдэхүүнийг хэрэглэх үүрэгтэй".




Анхаарах зүйл

- 1) Дээрхи хуулийн заалтуудад онолын үүднээс шинжилгээ хийх. Үүний тулд холбогдох эх зохиол, бусад эх сурвалжийг ашиглах.
- 2) Монгол улсын Үндсэн хуулийн холбогдох заалтуудтай холбон тайлбарлах.

7. Төрийн удирдлагын хэлбэр

Төрийн хэлбэр

Төрийн дээд албан тушаалыг ямар субъект хэрэгжүүлж буйгаар, улсын нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын хуваарилалт, тэдгээрийн удирдлагын харилцааны эрх хэмжээгээр, төрөөс эрх мэдлээ хэрэгжүүлэх аргаар нь төрийг ангилан судлах тухай ойлголт мөн. Тодруулбал, тухайн улсын нутаг дэвсгэр зөвхөн засаг захиргааны нэгжид эсхүл субъектуудын нутаг дэвсгэрт хуваагдаж байна уу гэдгийг харуулахын зэрэгцээ тэрхүү нутаг дэвсгэрт төрийн дээд албан тушаалыг хэн, ямар аргаар хэрэгжүүлж буй нь төрийн хэлбэрийг тодорхойлно.



Төрийн удирдлагын хэлбэр

Төрийн дээд албан тушаалыг хэн хэрэгжүүлж буйгаар нь төрийн удирдлагын хэлбэрийг хаант, бүгд найрамдах улсад хуваадаг.

Хаант улс - төрийн дээд албан тушаалыг хаан угсаа залгамжлан хэрэгжүүлдэг төрийн удирдлагын хэлбэр мөн. Түүний түгээмэл шинж:

1. Хааныг угсаа залгамжлан тодруулна. Олон улсын практикт хаан ширээ зайгамжлах гурван гол тогтолцоо бий.
 - a. Зөвхөн эрэгтэй талаас хааны угсаа залгамжлах ёсыг **салийн тогтолцоо** гэнэ.
 - b. Хаан ширээ залгамжлахад хүйс үл ялгаварлах хэдий ч отгон хүү давуу эрх эдлэх тогтолцоог **кастилийн тогтолцоо** гэж нэрлэнэ.
 - c. Эрэгтэй талаас залгамжлах хүнгүй нөхцөлд эмэгтэй талаас хаан ширээ залгамжилдаг нь австрийн тогтолцоо юм.
2. Хааны бүрэн эрхийн хугацаа насан туршийнх байна.
3. Хаан улс төрийн хариуцлага үл хүлээнэ.
4. Хаан өөрийн үзэмжээр бүрэн эрхээ хэрэгжүүлнэ.

Хаант улсыг түүхэн хөгжлийн дагуу ангилахаас гадна хааны бүрэн эрхийг харгалзан хэмжээгүй, хэмжээт эрхт гэж ангилна.

Хэмжээгүй эрхт хаант засаг - төрийн эрх мэдэл (хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх) зөвхөн хааны бүрэн эрхэд төвлөрнө. Ард түмний хүсэл зориг, ашиг сонирхлыг илэрхийлсэн төлөөлөгчдийн байгууллага хэрэг дээрээ үл оршино. Зарим улсад зөвлөх хурал, парламент байх боловч тэр нь хэлбэрийн төдий байдаг.

Хэмжээт эрхт хаант засаг - хааны эрх хэмжээг Үндсэн хуулийн дагуу хууль тогтоох (парламент), гүйцэтгэх (засгийн газар), шүүх эрх мэдлээр хязгаарласан





төрийн удирдлагын хэлбэр. Хааны эрх хэмжээг Үндсэн хуулиар хязгаарласныг шалгуур болгон хэмжээт эрхт хаант улсыг дуалист, парламентын хэмээн ангилж болно.

Бүгд найрамдах улс. Ерөнхийлөгч болон төрийн дээд байгууллагыг сонгож байгуулдаг төрийн удирдлагын хэлбэр. Үндсэн шинж нь:

1. Төрийн тэргүүн, эрх мэдлийн дээд байгууллагыг ард түмэн тодорхой хугацаагаар сонгоно.
2. Төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгчид өөрийн үзэмж, хүсэл зоригоор бус, хууль, нийтлэг эрх ашгийг удирдлага болгон ард түмний хяналт дор ажиллана.
3. Төрийн тэргүүн, эрх мэдлийн дээд байгууллага хуульд заасны дагуу улс төрийн хариуцлага хүлээнэ.



Орчин үеийн бүгд найрамдах улс. Төрийн эрх мэдэл нь ард түмнээс эх үндэстэй төрийн удирдлагын хэлбэр. Үндсэн хуульт ёс, хүний эрх, эрх чөлөөний суурь хэм хэмжээг хэрэгжүүлэх, төрийн эрх мэдлийг хуваарилахыг гол зорилго болгодог.

Орчин үеийн бүгд найрамдах улсыг ийнхүү ангилж буйн үндсэн шалгуур бол **Засгийн газрыг "хэн" байгуулж, засгийн газар "хэний" өмнө хариуцлага хүлээж** буй явдал мөн.

Ерөнхийлөгчийн бүгд найрамдах улс. Төрийн тэргүүн, засгийн газрын тэргүүний бүрэн эрх нэг субъектэд төвлөрсөн. засгийн газрыг ерөнхийлөгч парламентын гадуур байгуулж, хариуцлага хүлээлгэдэг төрийн удирдлагын ардчилсан хэлбэр мөн.

Парламентын бүгд найрамдах улс. Энэ нь төрийн болон гүйцэтгэх эрх мэдлийн тэргүүний бүрэн эрхийг өөр өөр субъектэд хадгалсан, засгийн газрыг парламентаас байгуулж, хариуцлага хүлээлгэдэг төрийн удирдлагын ардчилсан хэлбэр.

Холимог бүгд найрамдах улс. Төрийн тэргүүн, засгийн газрын тэргүүний бүрэн эрхийг өөр өөр субъект (ерөнхийлөгч, ерөнхий сайд) хадгалж, засгийн газрыг ерөнхийлөгч байгуулж, парламентын өмнө хариуцлага хүлээдэг төрийн удирдлагын ардчилсан хэлбэр мөн.



Хяналтын асуулт

- ❖ Төрийн удирдлагын хэлбэрийг “сайн”, “муу” гэж үзэх үү? эсхүл “тохирох”, мэс тохирох” гэж үзэх ёстой юу?
- ❖ Монгол Улсын Үндсэн хуулийн 20 дугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн” гэж заасан нь тус улсыг “парламентын улс” гэж үзэх улс төр, эрх зүйн үндэслэл болж чадах уу?



Сорил

1. Засгийн эрхийг ямар субъект хэрэгжүүлж буйгаар нь:
 - a. Парламентын, үндсэн хуульт хаант
 - b. Весминистрийн, Боннын
 - c. Ерөнхийлөгчийн, парламентын
 - d. Хаант, бүгд найрамдах гэж ангилна

1. Эрх зүйт, иргэнлэг нийгэмд гагцхүү бүгд найрамдах засаг л орших бололцоотой.
 - a. Тийм. Үүнийг И.Кант нотолсон
 - b. Үгүй. Энэ бол хэтэрхийлэлд хүргэнэ
 - c. Улс төр, эрх зүйн үнэт зүйлсээс хамааралтай
 - d. Үндсэн хуультай эсэхээс шууд хамаарна
2. Аль нь хүний эрх, эрх чөлөөг илүүтэй дээдэлдэг вэ?
 - a. Ерөнхийлөгчийн засаг
 - b. Парламентын засаг
 - c. Үндсэн хуульт хаант засаг
 - d. Дээрхи бүгд зөв

Семинар 4. Бүгд найрамдах улс түүний төрөл

Харьцуулан шинжлэх арга

А. Бодомж

1. Ерөнхийлөгчийн бүгд найрамдах улс	2. Парламентын бүгд найрамдах улс
❖ Сонгууль нь парламентын бус аргаар аль болох өргөн төлөөлөлттэй байдаг ❖ Засгийн газар ерөнхийлөгчийн өмнө хариуцлага хүлээдэг. ❖ Төрийн тэргүүн, Засгийн газар тэргүүн нэг субъектэд төвлөрдөг. ❖ Парламенты засгийн газрыг огцруулах, ерөнхийлөгч парламентыг тараах хууль зүйн механизм байдаггүй. ❖ Төрийн эрх мэдлийн салаа мөчирт улс төрийн намын нөлөө бага байдаг. ❖ Ерөнхийлөгч хууль санаачлах эрхтэй. ❖ Ерөнхийлөгч ард нийтийн санал асуулга явуулах эрхтэй.	❖ Парламентад олонх болсон нам засгийн газрыг байгуулж, тэрхүү засгийн газар парламентын өмнө хариуцлага хүлээнэ. Засгийн газар парламентын гишүүдийн олонхын итгэлийг алдсан тохиолдолд огцорно. ❖ Төрийн болон засгийн газрын тэргүүний бүрэн эрх өөр өөр субъектэд (ерөнхийлөгч, ерөнхий сайд) хадгалагдан хэрэгжинэ. ❖ Төрийн хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд эрх барьж буй болон парламентад суудалтай улс төрийн намын нөлөө харьцангуй өндөр байдаг. ❖ Төрийн тэргүүнийг ихэвчлэн парламентаас сонгоно.

Б. Статистик үзүүлэлт

- ❖ Өдгөө ерөнхийлөгчийн сонгуулийн дараах дөрвөн төрлийн тогтолцоо байна: (1) Бүх ард түмний санал асуулгаар сонгох (Сири, Египет зэрэг улс), (2) Бүх ард түмний шууд сонгуулиар сонгох (Балти хавийн болон Латин Америкийн орнууд, Ирланд, Исланд, Мексик, Польш, Румын, Франц зэрэг орнууд), (3) Парламентын болон төлөөлөгчдийн байгууллагаас сонгох (Болгар, Герман, Грек, Итали, Турк, Унгар, Чех, Швейцар, Энэтхэг), (4) Сонгогчдоос



сонгож сонго, (АНУ, Финланд зэрэг). Ерөнхийлөгчийг ихэвчлэн 1-7 жилийн хугацаагаар, зарим оронд (Малави) насан туршид нь сонгодог.

- ❖ Өнөөгийн байдлаар Азербайжан, Армен, Молдов, ОХУ, Польш, Португал, Тайван, Турк, Финлянд, Франц, Грек зэрэг орон төрийн удирдлагын холимог хэлбэртэй байна.

В. Аль нь ардчиллын мөн чанарыг илүүгэй илэрхийлдэг вэ?

- ❖ Боннын загвар
- ❖ Вестминистрийн загвар




Анхаарах зүйл

- 1) Нийтлэг болон ялгаатай талыг тодруулах
- 2) Статистик үзүүлэлтэнд анализ хийж, өөрсдийн дүгнэлт гаргах

8. Төрийн байгууламжийн хэлбэр

Улсын нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын хуваарилалт, төрийн төв, орон нутгийн байгууллагын хоорондын харилцааны эрх зүйн байдлыг илэрхийлсэн ойлголт. Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны нэгжид эсвэл муж улс, субъектын нутаг дэвсгэрт хуваагдаж байна уу гэдгээс хамааран нэгдмэл хийгээд холбооны улс гэсэн төрийн байгууламжийн хэлбэрт хуваагдана.



Нэгдмэл улс

Нутаг дэвсгэр нь зөвхөн засаг захиргааны нэгжид хуваагддаг, төрийн нэгдмэл тогтолцоо бүхий төрийн байгууламжийн хэлбэр. Нэгдмэл улсын үндсэн шинж:

1. Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны нэгжээс бүрэлдэнэ.
2. Нэг Үндсэн хууль, эрх зүйн нэгдмэл тогтолцоо улсын нутаг дэвсгэрт үйлчилнэ. Гэхдээ зарим оронд өөртөө засан тогтнох зарим муж орон нутгийн асуудлаар хууль гаргах эрх эдэлдэг.
3. Төрийн байгууллагын нэгдмэл тогтолцоотой байна. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага улс орны бүх нутаг дэвсгэрт нэгдмэл ажиллана.
4. Татвар, мөнгөний нэг тогтолцоотой байдаг.
5. Иргэний нэг харьяалал оршино.
6. Улс үндэстэн төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байх нэг чухал нөхцөл бол хэл, соёл, шашин суртлаар ижил угсаатан хүн ам зонхилох явдал мөн.

Энгийн нэгдмэл улс - хүн амыг оршин суугаа нутаг дэвсгэрээр засаг захиргааны нэгжид хуваана. Засаг захиргааны нэгжийн шатлал бүрийн эрх зүйн байдал ижил байна. Өөрөөр хэлбэл, засаг захиргааны аль нэг нэгж эрх зүйн байдлын хувьд илүү эрх хэмжээ эдлэхгүй.

Нийлмэл нэгдмэл улс - нутаг дэвсгэр нь засаг захиргааны нэгжээс бүрэлдэхийн зэрэгцээ өөртөө засан тогтнох бусад хэлбэрийг агуулна. Зарим нийлмэл нэгдмэл улсын нутаг дэвсгэр нь өөртөө засан тогтнох эрх бүхий нэгжээс бүрэлдэнэ.

Холбооны улс

Өөрийн нутаг дэвсгэрийн хүрээнд төрийн эрх зүйн бие даасан байдлаа хадгалсан статус бүхий бие даасан улсууд (субъект)-ын холбоог сайн дурын гэрээний үндсэн дээр байгуулсан төрийн байгууламжийн хэлбэр.

Нутаг дэвсгэрийн холбооны улс. Үндэстний бие даасан байдлыг хангах зорилгоор бус, харин нутаг дэвсгэрийн байршлын зарчмаар байгуулсан холбооны улсын хэлбэр мөн. Нутаг дэвсгэрийн холбооны улсын гишүүн улсын төрийн бүрэн эрхт байдал харьцангуй хязгаарлагдмал байдаг.

Үндэстний холбооны улс - Үндэстний өөрийгөө тодорхойлох эрхийг хангах зарчимд тулгуурласан, гишүүн орны төрийн бүрэн эрхт байдлыг хамгаалсан төрүүдийн холбоо мөн. Үндэстний холбооны улсад олон үндэстний хэл, соёл, шашин, зан заншгал бие даан орших бололцоог хангах үндэстний хүчин зүйл зайлшгүй байдаг онцлогтой.

Тусгаар улсуудын холбоо - Тусгаар тогтносон, бие даасан, бүрэн эрхт улсууд тодорхой зорилгод (улс төр, эдийг засгийн) хүрэхийн тулд гэрээний үндсэн дээр байгуулсан хууль зүйн түр холбоо мөн. Гишүүн нь бие даасан, тусгаар тогтносон, бүрэн эрхт улс байна. Хоорондын харилцааг олон улсын нийтийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулдаг.



Хяналтын асуулт

- ❖ “Төрийн байгууламжийн хувьд нэгдмэл байх”, “Нутаг дэвсгэрийн хувьд халдашгүй дархан байх” гэсэн ойлголтуудын харилцан хамаарлыг тайлбарла.
- ❖ Англид бичмэл Үндсэн хууль байдаггүй. Харин хэд хэдэн эрх зүйн суурь баримт бичиг түүний үзэл баримтлалыг илэрхийлдэг гэж үздэг. Эндээс “Англи улс бол төрийн байгууламжийн тодорхойгүй улс мөн” гэсэн дүгнэлт хийж болох уу?

9. Төрийн дэглэм

Төрөөс эрх мэдлээ хэрэгжүүлэх эрх зүйн дэг журмын арга, механизм, түүний шинж чанарыг төрийн дэглэм гэнэ.

Хүний эрх, эрх чөлөөний суурь зарчмыг хүлээн зөвшөөрч, хууль зүйн хамгаалалтыг ард түмний хүсэл зориг, эрх зүйт хуульд тулгуурлан бүрдүүлсэн, хууль бус албадлагаас татгалзсан дэглэмийг ардчилсан гэнэ.

Ардчилсан дэглэмийн үндсэн шинж

1. Төрийн эрх мэдлийг хуваарилсан байна.
2. Эрх зүйт хуулийг дээдэлнэ.
3. Хүний эрх, эрх чөлөөний орчин (иргэний нийгэм) нээлттэй, хамгаалалттай байна.



4. Шударга, тэгш, чөлөөтэй, шууд сонгуулийн тогтолцоо бүрэлдсэн байна.
5. Олон ургальч үзэл бодитой хүлээн зөвшөөрөгдсөн байна.
6. Зөвхөн хууль, шударга ёсонд үйлчилдэг бие даасан, хараат бус шүүхийг тогтоосон байна.
7. Хүний эрх, эрх чөлөөний суурь зарчим, хэм хэмжээгээр төрийн эрх мэдлийг хязгаарласан байна.



Иргэний соёл, иргэнлэг ёс төлөвшсөн байх нь ардчилсан дэглэм орших гол нөхцөл мөн.

Хүний эрх, эрх чөлөөний суурь зарчмыг хүлээн зөвшөөрөөгүй эсвэл зөвхөн тунхагласан, хууль зүйн хамгаалалтыг бүрдүүлээгүй, ард түмний хүсэл зориг, эрх зүйт хуульд бус албадлага, хүчирхийлэлд тулгуурлан эрх мэдлээ хэрэгжүүлдэг дэглэмийг **ардчилсан бус** гэнэ.

Ардчилсан бус дэглэмийн үндсэн шинж:

1. Төрийн эрх мэдлийг хуваарилаагүй эсвэл хэлбэрийн төдий хуваарилсан байна.
2. Эрх зүйт Үндсэн хууль бус, харин тухайн дэглэмийг хамгаалсан дур зоргын эрх зүйн тогтолцоотой байна.
3. Хүний эрх, эрх чөлөөний орчин (иргэний нийгэм) хаалттай, хатуу хяналтад байна.
4. Дайчилгааны сонгуулийн тогтолцоо оршино.
5. Олон ургальч үзэл бус, харин сэтгэлгээний монизм ноёрхоно.
6. Эрх баригчдад үйлчилдэг, бие даасан бус, хараат шүүхтэй байна.
7. Хүний эрх, эрх чөлөөний суурь зарчим, хэм хэмжээг эрх баригчдын дур зорго, үзэл суртлаар сольж, төрийн эрх мэдэл үл хязгаарлагдаж, хүчирхийлэл, албадлагын тогтолцоо нь ард түмнийг аймшгийн сэтгэл зүйд дасгасан байдаг.



Ардчиллын чанар

Хүүвэрийн институтын профессор Ларри Даймонд ардчиллын чанарын найман хэмжүүрийг гарган тавьсан. Энд хэрэгжилтийн тав (эрх зүйт ёс, оролцоо, өрсөлдөөн, хариуцан тайлагнах босоо тогтолцоо, хариуцлагын хэвтээ тогтолцоо), суурь анхдагч утга агуулгын хоёр (эрх чөлөө, тэгш эрх), үр дүнгийн нэг хэмжүүр (үүрэг хариуцлага) байна.



Сорил

1. Аль нь ардчиллын мөн чанарыг илүүтэй илэрхийлж байна вэ?
 - a. Хувь хүний эрх чөлөөг хамгаалах
 - b. Олонхийн дарангуйлал
 - c. Хамгийн муу засгийн хэлбэр
 - d. Олонхийн засаг, цөөнхийн хамгаалал



Сорил

2. Аль нь ардчиллын чанарын хэмжүүрт багтах вэ?
 - a. Оролцоо, өрсөлдөөн, санал хураалт
 - b. Эрх зүйт ёс, тэгш эрх, сонгууль
 - c. Эрх чөлөө, олон намын тогтолцоо, өрсөлдөөн
 - d. Оролцоо, тэгш эрх, эрх зүйт ёс, хариуцлага
3. Эдийн засаг, соёл, улс төрийн чиглэлд гарч буй өөрчлөлтүүд нь хоорондоо уялдаа холбоотой бөгөөд үүнийг урьдчилан таамаглаж болно гэж үздэг нь:
 - a. Модернизацийн онол
 - b. Институцийн онол
 - c. Рационал сонголтын онол
 - d. Шинэ сонгодог онол
4. “Нэг хүн - Нэг санал” гэсэн зарчим нь:
 - a. Насанд хүрсэн бүх хүнд
 - b. Нийт хүн амд
 - c. Боловсролтой хүмүүст
 - d. Насанд хүрсэн, эрүүл ухаант бүх хүнд хамааралтай

10. Төрийн байгууллага, түүний чиг үүрэг

Төр - хийсвэр ойлголт. Төрийн хүсэл зоригийг байнга илэрхийлэн хамгаалдаг бие хүн, нийгмийн бүлэг бий болсноор эл хийсвэр ойлголт бодитой, материаллаг зүйл болж хувирдаг. Төр оршиж буйн бодит биелэл, илрэл нь засгийн газар юм. Байгууллагагүй шөр оргийхгүй учраас төрийн байгууллага бол түүний орших үндэс, илрэх бодит хэлбэр мөн.

Леон Дюги

Төрийн механизм


Төрийн механизм бол нийтлэг эрх мэдлийг хэрэгжүүлдэг байгууллага, албан тушаалтны тогтолцоо мөн. Түүний бүрэлдэхүүнд төрийн байгууллага, албан тушаалтан, тэдний эрх, үүргээ хэрэгжүүлэхэд зориулсан эдийн болон эдийн бус баялаг, техник хэрэгсэл багтана.

Төрийн байгууллага, түүний ангилал

Төрийн байгууллага бол хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн хүрээнд бүрэн эрх эдэлж, хуульд заасан чиг үүрэг хэрэгжүүлдэг, нийтлэг эрх ашгийг илэрхийлэн хамгаалдаг хуулиар бий болгосон "зохиомол" тогтолцоо мөн. Төрийн байгууллагыг янз бүрийн шалгуураар ангилж болно. Тухайлбал, (1) үйл ажиллагааны хүрээгээр нь төв ба орон нутгийн; (2) чиг үүргээр нь хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх; (3) байгуулах аргаар нь сонгогдсон, томилогдсон; (4) бүрэлдэхүүн, шийдвэр гаргах аргаар нь ганцаарчилсан, хамтын гэх мэтээр ангилдаг.



Төрийн байгууллагын чиг үүрэг



Нийтээр дагаж мөрдөх эрх зүйн хэм хэмжээ тогтоох үндсэн чиг үүрэг бүхий тогтолцооны дээд субъектыг төрийн **хууль тогтоох байгууллага** гэнэ. Хууль биелүүлэх замаар зорилго тодорхойлох, зохион байгуулах, төлөвлөх, хүний нөөцийг бүрдүүлэх, идэвхжүүлэх, хянан шалгах чиг үүргийн үндсэн дээр нийгмийг удирддаг тогтолцооны дээд субъектыг төрийн **гүйцэтгэх байгууллага** гэнэ. Хэрэг, маргааныг шударга ёс, төрийн хуулийн дагуу шүүн шийдвэрлэдэг тогтолцоог **шүүх эрх мэдлийн байгууллага** гэдэг.

Хууль тогтоох байгууллага, түүний чиг үүрэг

Парламент бол хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлдэг, ард түмнээс сонгуулиар байгуулагддаг, хамтын зарчмаар ажилладаг, ард түмний төлөөллийн дээд, төв байгууллага юм. Парламент нь ард түмний эрх мэдлийн дээд байгууллага учраас хууль тогтоохоос гадна төрийн эрх мэдлийн салаа бүрийг байгуулахад оролцох, төрийн гадаад, дотоод бодлогыг боловсруулах, улсын тосвийг батлах, засгийн газрыг хянах зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлдэг. Тиймээс парламент хууль тогтоох, төлөөлөх, хянах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг.


Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, түүний чиг үүрэг

Гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төрийн төв, дээд байгууллага бол засгийн газар юм. Хууль биелүүлэх, төрийн удирдлагыг хэрэгжүүлэх нь засгийн газрын үндсэн чиг үүрэг юм.



Шүүх эрх мэдлийн байгууллага, түүний чиг үүрэг

Шүүх эрх мэдлийг шүүхийн байгууллага хэрэгжүүлнэ. Тиймээс Монгол Улсын Үндсэн хуулийн 47-р зүйлийн 1-д "Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ" гэж заажээ. Шүүх бол хүний эрхийн хууль зүйн хамгаалалтын баталгаа юм. Аливаа хэрэг, маргаан, гомдлыг зөвхөн шударга ёс, зүй ёс, хууль ёсонд нийцүүлэн шийдвэрлэнэ, хууль ёсны шүүхээр эцэслэн шүүлгэнэ гэсэн хүний эрхийн суурь хэм хэмжээг хамгаалахад шүүхийн үндсэн чиг үүрэг оршино.



Нутгийн удирдлагын байгууллага

Нутгийн удирдлага нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хүрээнд өөрийн болон **төрийн** удирдлагыг хэрэгжүүлдэг байгууллагын тогтолцоо, орон нутаг дахь төрийн механизмын гол салаа мөн.



Хяналтын асуулт

- ❖ УИХ-ын үндсэн чиг үүргийг тайлбарлана уу? Парламентын хяналт гэдэгт юуг ойлгох вэ?
- ❖ Прокурорын байгууллага эрх мэдэл хуваарилах онолын дагуу төрийн эрх мэдлийн аль салаа мөчирт хамаарах вэ?
- ❖ Иргэдийн төлөөлөгчдийн хурал иргэний нийгмийн байгууллага уу? эсхүл төрийн байгууллага уу?



Сорил

1. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь:
 - a. Нийтийн захиргааны байгууллага
 - b. Иргэний нийгмийн байгууллага
 - c. Орон нутгийн байгууллага
 - d. Үндсэн хуулийн байгууллага
2. Парламент бол:
 - a. Төрийн эрх барих дээд байгууллага
 - b. Төлөөллийн дээд байгууллага
 - c. Хууль тогтоох байгууллага
 - d. Иргэний нийгмийн байгууллага

Семинар . Төрийн орон нутгийн байгууллага

Маргаантай асуудлаар хэлэлцүүлэг явуулах арга А. БОДОМЖ

Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн "Орон нутгийн өмч болон орон нутаг дах төрийн өмчийг эзэмших, ашиглах" гэсэн 55 дугаар зүйлд:

- 55.1. *Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн байгууллага үндсэн бүтээгдэхүүнээ нийлүүлэхэд ашиглаж байгаа төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг тухайн нэгжийн балансад бүртгэнэ.*
 - 55.2. *Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн байгууллага өөрийн балансад байгаа эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг хариуцна.*
 - 55.3. *Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн байгууллагын ерөнхий менежер байгууллагын балансад байгаа эд хөрөнгийг бүрэн эрхийнхээ хүрээнд эзэмшиж ашиглана.*
 - 55.4. *Орон нутгийн төсвийн байгууллага өөрт байгаа орон нутгийн өмчийн эд хөрөнгө ашигласны төлбөрийг жил бүр орон нутгийн төсөвт төлнө.*
- гэж хуульчилсан нь орон нутгийн өмч, хөрөнгийг бүрдүүлэх, хамгаалах талаас зохицуулалт сайтай мэт харагдавч сум, дүүрэгт шилжүүлсэн хөрөнгө байхгүйгээс төсвийн байгууллагууд "өмчлөлгүй" хөрөнгөөр бүтээгдэхүүн нийлүүлж байна¹.

1

Орон нутаг эдийн засгаа бие даан хөгжүүлэх боломж, арга зам. Нээлттэй нийгэм форум.
УБ., 2006. 26-27 дахь тал



Б. АСУУДАЛ

- ❖ Төсвийн байгууллага удирдлага санхүүжилтийн тухай хуулийн дээрхи заалт нь дэлхийн нийтийн чиг хандлагат нийцсэн зохицуулалт болж чадсан.
- ❖ Төсвийн байгууллага удирдлага санхүүжилтийн тухай хуулийн дээрхи заалт нь дэлхийн нийтийн чиг хандлагаас хол хоцорсон, үзэл баримтлалын хувьд алдаатай зохицуулалт болсон.
- ❖ Төсвийн байгууллага удирдлага санхүүжилтийн тухай хуулийн дээрхи заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалтай нийцэж байна. Төсвийн байгууллага удирдлага санхүүжилтийн тухай хуулийн дээрхи заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалт, түүний үзэл баримтлалтай огт нийцэхгүй байна.
- ❖ Монгол Улсын Үндсэн хуульд энэ талаар тодорхой зохицуулалт байхгүй. иймээс энэхүү хуулийн алдаа, оноог үндсэн хуульт ёсны онолоор шийдэх бололцоотой.



Анхаарах зүйл

- 1) Холбогдох хууль тогтоомж, бусад эх сурвалжийг заавал ашиглах
- 2) Өөрийн олж авсан мэдээлэлд тулгуурлаж дүгнэлт гаргах

II бүлэг. ТУСГАЙ ОНОЛ

11. Төрийн эрх мэдэл хуваарилах онол

Иргэд нь эрхээр хангагдаагүй, төрийн эрх мэдлийг хуваарилаагүй нийгэмд угтаа Үндсэн хууль байдаггүй...

Францын Хүний болон иргэний эрхийн тунхаг

Хэрэв хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийг нэг гарт төвлөрүүлвэл эрх чөлөө хэрэгжихгүй... шүүх эрх мэдэл хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлээс тусгаарлагдаагүй тохиолдолд мөн эрх чөлөө үл оршино. Хэрэв шүүх эрх мэдэл хууль тогтоох эрх мэдэлтэй нэгдвэл, иргэдийн амьдрал, эрх чөлөө дур зоргын золиос бол болно. Хэрэв шүүх эрх мэдлийг гүйцэтгэх эрх мэдэлтэй нэгтгэвэл шүүгчид дарангуйлагчид болох бололцоог бүрдүүлнэ.


Ш. Монтескье

Эрх мэдэл хуваарилах үзэл санаа

Төрийн эрх мэдлийг хуваарилах нь хүний эрх, эрх чөлөөний хамгийн том баталгаа мөн. Үүний тулд ГҮЙЦЭТГЭХ засгийг хянах чадвартай хууль тогтоох засаг, хууль тогтоох засгийг хязгаарлах хараат бус шүүх оршдог. Өрнө дахинд хууль болон ард түмний төлөөлөгчдийн дуу хоолойгоор, дорно дахинд төрийн зүтгэлтний ёс суртахуунаар хязгаарлах тухай ерөнхий үзэл санаа оршиж байлаа. Төрийн эрх мэдлийг хуваарилах онол төрийн удирдлагын боловсронгуй тогтолцоог хангах үүднээс бус, хүний эрхийг төрийн дур зоргоос хамгаалах механизмыг бүрдүүлэх хэрэгцээ, шаардлагаас ийнхүү урган гарчээ. Тиймээс хүний эрх, төрийн эрх мэдлийн хуваарилалт нь нэг зүйлийн хоёр тал мөн.

Үндсэн хуулийн зарчим

Төр хүний эрх, эрх чөлөөг хамгаалдаг боловч бас хамгийн ноцтой хохироогч нь байх бололцоотой. Хүн төрөлхтөн өөрийнхөө эрх, эрх чөлөөг төрийн хүчнээс хамгаалах талаар хийсэн дорвитой ололтуудын нэг бол төрийн эрх мэдэл хуваарилах онолыг бүтээж, Үндсэн хуулийн нэг гол зарчим, үзэл баримтлал болгосон явдал юм. Төрийн эрх мэдлийн хуваарилалтыг орчин үеийн ардчилсан төр ёсны тулгуур зарчим, улс төрийн дээд үнэт зүйл хэмээн хүлээн зөвшөөрч буй хэдий ч түүнийг сонгодог утгаар хэрэгжүүлэх үйл хэрэг нарийн ээдрээтэй хэвээр байна.



Үндсэн хуулийн шүүхийн хяналт

Бодитой үйлчилж байгаа Үндсэн хуулийн зохицуулалтын хүрээнд тэнцвэр, хяналтын тогтолцоог хангахад хүн төрөлхтний олсон нэг том амжилт бол Үндсэн хуулийн шүүхийн хяналт мөн. Үндсэн хуулийн шүүхийн хяналт нь зөвхөн Үндсэн хуулийн замаар эрх мэдэл нэмэгдүүлэх эрх зүйн бололцоог хааж боодог хэдий ч хуулийн гадуур хувь хүмүүсийн төвшинд эрх мэдэл хутгалдах бололцоог төдийлөн хязгаарлаж чаддаггүй.

Гүйцэтгэх эрх мэдлийн хяналт

Ерөнхийлөгчийн бүгд найрамдах улсад гүйцэтгэх эрх мэдлийг хянах хяналтын тогтолцоог парламентаас бүрдүүлэх боломж харьцангуй нээлттэй байдаг бол



парламентын бүгд найрамдах улсын хувьд энэ нь эрх баригчдын ухаан, соёлд найдсан бүрхэг, ээдрээ маргаантай асуудал байсаар байна.

Хэлбэрийн хуваарилалт

Монгол Улсад төрийн эрх мэдлийг хуваарилсан нь Үндсэн хууль бодитой орших хууль зүйн үндсийг бүрдүүлж, улмаар иргэний нийгэм, ардчилсан ёс төлөвшин хөгжих нөхцөл болсон юм. Гэвч төрийн эрх мэдлийн хуваарилалт хуульчилснаар шууд хэрэгждэг энгийн хялбар зүйл биш, харин хөгжлийн төвшин, цаг хугацаа шаардсан эгзэгтэй нарийн асуудал билээ.

Агуулгын хуваарилалт

Агуулгын тал буюу хуваарилалт төрийн түшээ нарын оюун ухаан, ухамсар, албаны соёл, үйл хэрэгт хэрэгжих учиртай. Төрийн эрх мэдлийн хуваарилалтын хамгийн хүнд хэцүү энэ талын хэрэгжих үйл явц манай өнөөгийн хөгжлийн төвшинг тусгасан объектив, субъектив хүчин зүйлээс хамаарч урагшлах ухрах, алдах онох замаар үргэлжилсээр байна.

Иргэний нийгмийн хяналт

Төрийн эрх мэдлийн субъект бүр өөрийн хил хязгаарын хүрээнд бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хуулийн ноёрхол, төрийн албан хаагчдын ухамсар, соёлоос гадна иргэний нийгмийн хүчтэй хяналт нэн чухал. Энэ бүхэн мэдээж цаг хугацаа шаардана.



Хяналтын асуулт

- ❖ Үндсэн хуулийн цэц эрх мэдлийн аль салаа мөчирт багтах вэ?
- ❖ Монгол улсын ерөнхийлөгч чиг үүргийн хувьд аль эрх мэдэлд хамаарах вэ?
- ❖ Хэвлэл мэдээллийн хэрэгсэл дөрөв дэх засаг гэдэг нь юу гэсэн үг вэ?
- ❖ Прокурорын байгууллагын чиг үүргийн хувьд аль эрх мэдэлд хамаарах вэ?
- ❖ “Бичмэл үндсэн хуультай улсад л эрх мэдэл хуваарилалт орших бололцоотой” гэсэн дүгнэлтэд онолын үүднээс шинжилгээ хийнэ үү?

12. Эрх зүйг төр, түүний үндсэн элементүүд

*Оюун ухаант амьтад өөрсдийн зохиосон хууль дүрэмтэй байж болох юм.
Гэхдээ тэрхүү хуулийн дээр тэдний хэзээ ч зохиодоггүй хууль оршдог.*

Ш. Монтескье

Эрх зүйт төр гэж юу вэ?

Эрх, хууль, төр гэсэн гурван онлголт салшгүй нэгдэлтэй, бас ялгаатай. Эдгээрийн хамгийн зохистой хослолыг бүрдүүдсэн торийг эрх зүйт тор гэдэг. Хууль дээдэлдэг тор бүрийг эрх зүйт гэх¹⁷и, харин эрх зүйт хуулийг дээдэлдэг торийг тэгж хэлдэг.



Rule of Law ба Rule by Law

Эрх зүйт төрийн гол зарчим "Rule of Law" нь "Rule by Law"-оос зарчмын ялгаатай. "Rule by Law" гэдэг нь хуулийг төрийн албадлагаар хамгаалагдсан хувьд нь дагаж мордохийг хэлиэ. Энэ нь хуульгүй байснаас хамаагүй дээр. Гэвч суурь хэм хэмжээг тусгасан **эрх зүйт төрийн** үүднээс авч үзвэл нэр төдий л зүйл юм. Парламентаас баталсан хууль тогтоомж бүрийг эрх зүйт хууль гэхгүй. Зөрчигдөж болохгүй зарчмуудад үндэслэсэн хууль л эрх зүйт бөгөөд дээдлэгдэх, хүлээн зөвшөөрөгдөх үндэстэй. Ийм зарчимд тулгуурласан хуулийг "Rule by Law"-гоос ялгаж "Rule of Law" гэдэг.

Үзэл санааны үндэс

Хүн биш, эрх зүй засаглах үзэл санаа нь эртний сэтгэгчдээс улбаатай. Платон "Хууль ямар ч хүчгүй. хэн нэгний эрхшээлд орсон бол тийм төр улс сөнөдөг. Харин хууль эрх баригчийн эзэн, эрх баригчид нь хуулийн боол байгаа цагт тэрхүү улс орон цэцэглэн мандах зүй тогтолтой" хэмээн бичиж байв. Энэхүү үзлийг Аристотель цааш хөгжүүлж "Иргэдийн дундаас хэн нэг нь бус, харин хууль засаглаж байх нь илүү чухал" гэж тэмдэглэсэн нь бий.

Хожим английн сэтгэгч Ж.Локк төр хөндөж үл болох жам ёсны хуулийн тухай үзэл санааг дэвшүүлж, эдгээр үнэт зүйлсийг бодитой хэрэгжүүлэхэд хүний буюу, хуулийг засаглал чухал болохыг номлов. Хожим энэ үзэл нь 1870 оны Масачусетсийн тунхагт "GOVERNMENT OF LAWS, NOT OF MEN" буюу "**Хүний бус, хуулийн засаг**" хэмээн тэмдэглэгдэж, дэлхий дахинаа түгэн дархлаажих болов.

Эрх зүйт төрийн үндсэн зарчим, түүний шалгуур

Эрх зүйт төрийн үндсэн зарчим, түүний шалгуурын асуудлыг нэлээд эртнээс судалж ирсэн бөгөөд 1885 онд А.Дисей анх удаа цэгцтэйгээр томъёолсон гэж үздэг. Үүнд:

Нэгд, хууль нь эцсийн бөгөөд дээд хүчинтэй байна. Ялангуяа гүйцэтгэх эрх мэдэл өөрийн үзэмжээр асуудал шийдвэрлэх эрхийг хязгаарлах ёстой бөгөөд хэрэв хуульд харшилсан шийдвэр гаргасан бол хүчингүй болгоно.

Хоёрт, Хуулийн өмнө хүн бүр эрх тэгш байх ёстой. Та тариачин байна уу засгийн төлөөлөгч байна уу гэдгээс л хамааран эрх зүйн адил нөхцөл үйлчлэх ёстой.



Гуравт, Үндсэн хуулийн дэг журам нь эрх зүйн зайлшгүй байх эх сурвалж биш. Тодруулбал, английн эрх зүй нь хүний эрх чөлөөг бичмэл үндсэн хуультай улс орнуудаас илүү төвшинд хамгаалж ирсэн хэмээн тэмдэглэж байжээ.

Эдүгээ эрх зүйт төрийн шалгуурыг АГУУЛГЫН ба ХЭЛБЭРИЙН хэмээн хоёр задалж үздэг.

Эрх зүйт төрийн үндсэн баталгаа

Эрх зүйт төрийг хий хоосон үзэл санаа болгочихгүйн баталгаа бол хараат бус, бие даасан шүүх эрх мэдэл мөн. Чухамхүү ийм шүүх л байж гэмээнэ эрх зүйт төрийг жинхэнэ утгаар нь төлөвшүүлж, иргэний эрх чөлөөг хамгаалж чадна. Тиймээс ардчилсан ус орнуудад шүүх нь иргэний эрх чөлөөний баталгаа гэсэн хүндтэй нэрийг зүүдэг. Өнөөдрийн байдлаар дэлхий дахинаа хүний эрхийг хамгаалах шүүхийн мөрдөх ба мэтгэлцэх гэсэн хоёр үндсэн тогтолцоо үйлчилдэг. Мөрдөх тогтолцоо нь шүүхээс урьдчилан нотлох баримтыг цуглуулдаг бол мэтгэлцэх тогтолцоо нь шүүхийн өмнө мэтгэлцэх зарчмаар нотлох баримтыг дэлгэж үнэлдэг.



Хяналтын асуулт

- ❖ Хуулийн засаг яагаад үнэ цэнэтэй байдаг вэ?
- ❖ Орчин үеийн эрх зүйт төр нь “байх ёстой” зүйлийг хуульчилсан хуулийг дээдэлдэг үү, эсвэл хуулийг л дээдэлдэг төр үү?
- ❖ “Шүүгч бол ярьдаг хууль, хууль бол хэлгүй төр” гэсэн эртний Ромын мэргэн үгэнд эрх зүйт төрийн үүднээс шинжилгээ хийх.
- ❖ Хууль тогтоомж хууль бус байж болох уу?

Семинар 6. Rule of Law & Rule by Law

Маргаантай асуудлаар байрь суурь илэрхийлэх арга

А. БОДОМЖ

Rule of law	Rule by law
❖ Хувь хүний эрх чөлөөг хамгаалах ❖ Эрх зүйд хязгаарлагдсан засаг бий болгох ❖ Улс төрийн эрх мэдлийг хууль дээдлэх зарчимд нэгтгэх ❖ Хараат бус шүүхийн хяналтанд засгийн бүх үйл ажиллагааг оруулах ❖ Иргэний эрх нэр төрийг баталгаажуулах ❖ Хууль нь төрийн эрхийг тогтооно ❖ Зөрчигдөж болохгүй зарчмуудад үндэслэсэн хууль ❖ Хууль бүхнээс дээгүүр	❖ Засгийн газарт (төрд) хуулиас давсан эрх мэдэл төвлөрөх ❖ Ямар ч дэглэмийг хууль ёсны болгоно ❖ Төрийн эрх мэдэл нэг хүний гарт төвлөрнө ❖ Бодьгалчлагдсан ❖ Хэмжээгүй эрхтэй, юугаар ч хязгаарлагдаагүй ❖ Төрийн эрх нь хуулийг тогтооно ❖ Хуулийг төрийн албадлагаар хамгаалагдсан хувьд нь дагаж мөрдөнө

Б. Төр ашигтай санал тавиад унахад л эрх чөлөөгөө хамгаалах мэдрэмж маань сэрэх хэрэгтэй юм байна гэж туршлага бидэнд хэлж байна. Байгалиасаа эрх чөлөөт амьдралын төлөө төрсөн хүмүүс эрх мэдэлтний зүгээс эрх рүү нь халдсан үйлдэл болгоныг тас цохиход бэлэн байдаг. Юу ч мэддэггүй атлаа сайхан сэтгэл агуулсан гал цогтой хүмүүсийн цаана л эрх чөлөөнд учрах хамгийн том аюул нуугддаг. (Шүүгч Луйс Брэндис)



Анхаарах зүйл

- 1) Өгөгдсөн мэдээллийг ашиглан “Rule of law”, “Rule by law” гэсэн ойлголтуудыг үзэл баримтлалын хувьд харьцуулах. Монгол улсын 1960, 1992 оны Үндсэн хуулиудыг жишээ болгон ашиглах.
- 2) Rule of law-ын зарчим, үзэл баримтлалыг ашиглан шүүгч Луйс Брэндисийн үгэнд дүн шинжилгээ хийх.

13. Социал төр, түүний үндсэн зарчмууд

Эрх зүйт төр нийгмийн өөрийнх нь социал асуудлыг шийдвэрлэх чадваргүй гэдгээ батлан харуулсан тул социал төрийн зарчим үүссэн.

Вольфанг Хоон

Социал төрийн үзэл санаа



Эрх чөлөөний болон тэгш ёсны зарчмыг ухаалгаар хослуулах, хүний эрх, эрх чөлөө бодитой хэрэгжих нийгмийн орчныг бүрдүүлэх нь социал төрийн үндсэн үзэл санаа мөн. Социал төр хэмээх ойлголтыг XIX зууны төгсгөлд германы эрдэмтэн Л.Штайн судалгааны эргэлтэд оруулжээ. Тэрээр "нийгмийн янз бүрийн давхраа, хувь хүний эрхэд туйлын тэгш байдлыг төр өөрийн эрх мэдлийн хүрээнд хангах, эдийн засгийн болон нийгмийн дэвшилд өөрийн бүх иргэдийг дэмжих үүрэгтэй. Энэ нь эрх чөлөөт байдлыг хангахад тусална" гэжээ. Социал төрийн үзэл санаа Британий парламентаас лейборист засгийн газарт санал болгосон Бевериджийн төлөвлөгөөнд (1942 он), улмаар 1949 онд ХБНГУ-ын Үндсэн хуулинд туссанаас хойш өргөн тархаж, тал бүрээс судлагдах болсон.

Социал төрийн элементүүд

Байгаль, нийгмийн бодит хүчин зүйлээс хамааран нийгмийн тодорхой хэсэг өөрийн оршихуйг хангаж чадахгүй болох тохиолдолд (өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, олон хүүхэд төрүүлэх, эхчүүд, хүүхэд, залуучуудын нийгмийн асуудал, тахир дутуу болох гэх мэт) хүн болж төрснийхөө нь хувьд эрхэм чанараа алдах, цөхрөл, гутралд оруулахгүйн тулд тэдний амьдралын наад захын үндсэн хэрэгцээг хангах үүднээс төрийн тусламжийн баталгааг хуульчилж, нийгмийн хамгааллын бодлого, зарчмыг хэрэгжүүлэх хэрэгтэй.



Амьдралын наад захын баталгааг тогтоон хуульчлах

Хүн өөрийгөө хийгээд үр хүүхдээ асран тэжээх иргэний үүргээ биелүүлэх амьдралын нөхцөл нь хүн ёсоор, нэр төртэй амьдрах нийгмийн баталгаа, үнэлэмж мөн.

Нийгмийн тэгш ёсыг эмзэг бүлгийн хүрээнд хамгаалах

Иргэд зөвхөн хууль шүүхийн өмнө л тэгш байна. Хувь хүнийхээ хувьд байгалиас харилцан адилгүй (тэгш бус) байдаг бөгөөд амьдралын явцад үүссэн тэрхүү тэгш бус байдалд орсон хэсгийг төр зөнд нь орхих ёсгүй.

Нийгмийн эмзэг хэсэгт туслалцаа үзүүлэх

Хүний амьдралд жам ёсоор болон цаг зуураар зовлон бэрхшээл (өвчлөх, өндөр настай болох, тэжээгчээ алдах, тахир дутуу болох, ажилгүйдэх гэх мэт) тохиолдох нь олонтаа. Ийм үед нь эс харж хандваас иргэн нь хүн болж төрсөндөө гутрах, шаналах, амьдралаас уйдах зэрэг золгүй явдалд автана. Өндөр наслах, өвчин эмгэг тусах, тахир дутуу болох, ажилгүйдэх, үхэл хагацал үзэх зэрэг нь хүнээс өөрөөс нь тэр бүр шалтгаалдаггүй үзэгдлүүд учир төрөөс "гар сунгах" үүрэгтэй гэж үзнэ.

Эрх зүйт болон социал төрийн хослол

Эрх зүйт хийгээд социал төрийн нийтлэг хийгээд онцдог нь бие биенээ тэтгэн хөгжөөж байдаг. Социал төр өөрийн зорилго, зарчмаа эрх зүйт ёсны хэлбэрээр хэрэгжүүлж, нийгмийг энэрэнгүй үзлээр тэтгэж, хүний эрхийг өргөжүүлж, эрх зүйн хэм хэмжээг шударга ёсны агуулгаар баяжуулж байгаа нь орчин үеийн төр ёсны нэгэн гол хандлага болж байна.



Хяналтын асуулт

- ❖ Монгол Улсын Үндсэн хуулийн оршил хэсэг дэх "хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм цогцлон хөгжүүлэх" гэснийг социал төрийн үзэл баримтлалын үүднээс тайлбарлаж болох уу?
- ❖ Социал төр үүсэх болсон үндсэн шалтгааныг тайлбарлана уу?
- ❖ Социал төрийн хөгжлийн чиг хандлага ба сул талыг орчин үеийн төр судлалын үүднээс тайлбарлана уу?



Сорил

1. Социал төрийн зарчим аль улсын Үндсэн хуульд тусгалаа олсон бэ?
 - a. БНХАУ
 - b. ОХУ
 - c. АНУ
 - d. ХБНГУ

2. Социал төрийн үндсэн зарчим (үл хамаарахыг ол)
 - a. Амьдралын наад захын баталгааг тогтоон хуульчлах
 - b. Нийгмийн эмзэг хэсэгт туслалцаа үзүүлэх
 - c. Тэгш ёсыг хангах
 - d. Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх
3. “Социал төр” гэсэн нэр томъёо анх хэний бүтээлд тусгалаа олсон бэ?
 - a. Р.Моль
 - b. К.Маркс
 - c. Л.Штайн
 - d. Х.Кельзен

Семинар 7. Эрх зүйт ба социал төр

Харьцуулан шинжлэх арга

А. БОДОМЖ

Эрх зүйт төр	Социал төр
❖ Иргэн нь үл зөрчигдөх суурь эрхтэй ❖ Төр болон иргэний эрх, үүргийг Үндсэн хуулиар хатуу зааглан тогтоосон хувийн эрх чөлөөнд хуулиар хориглохгүй бүхэн зөвшөөрөгддөг ❖ Гарч болзошгүй маргаанаас сэрэмжилсэн ❖ Төр, иргэн харилцан бие биедээ шаардлага хяналт тавих механизмтай, иргэд нь нийтлэг зорилгоо хэрэгжүүлэхийг төрөөс шаарддаг ❖ Эрх зүйн хамгаалалт хяналтыг тогтоох ❖ Эрүүгийн хууль тогтоомжийг буцаан хэрэглэхийг хориглох ❖ Үндсэн хуульт ёсыг хэрэгжүүлэх ❖ Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах ❖ Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас улс төрийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ төрийн хууль ёсыг чандлан сахих	❖ Нийгмийн хамгаалал шаардсан нийгмийн тодорхой бүлэгт амьдралын наад захын баталгаа бүрдүүлэхэд гол анхаарлаа хандуулдаг ❖ Нийгмийн тэгш ёсыг эмзэг бүлгийн хүрээнд хамгаалах ❖ Нийгмийн эмзэг бүлэгт тусламж үзүүлэх ❖ Амьдралын наад захын баталгааг тогтоон хуульчлах ❖ Нийгмийг энэрэнгүй үзлээр тэтгэх ❖ Хүний эрхийг өргөжүүлэх ❖ Эрх зүйн хэм хэмжээг шударга ёсны агуулгаар баяжуулна Сул тал ❖ Дарангуйллын тогтолцоо үүсэх хөрс суурийг агуулж, нийгмийг дээрээс нь хүсэл зоригоороо удирдах, хянах аюулыг агуулах ❖ Ард түмнийг номхон хүлцэнгүй байх сэтгэл зүйд дасах ❖ Олон түмний бэлэнчлэх, тэжээлгэх сэтгэлгээнд сургах



Анхаарах зүйл

- 1) Давуу болон сул талыг тодруулах
- 2) Монгол улсын Үндсэн хуульд дээрхи зарчмууд хэрхэн тусгалаа олсныг тайлбарлах
- 3) Холбогдох хууль тогтоомж, бусад эх сурвалжыг ашиглах
- 4) Үндэслэлийг статистик тоо баримт болон бусад эх сурвалжаар заавал нотолсон байх. Тухайлбал, ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон улс орнуудын хэдэн хувь нь социал төрийн зарчмыг Үндсэн хуулиндаа тусгасан гэх мэт.

14. Монгол төрийн хөгжил

Тухайн улс орны дотоод уг чанар, амьдрах арга ухаан байгалийн нөхцлөөр тодорхойлогдоно.

Геродат (МЭӨ V зуун)

Төр ёс

Төр ёс - төрийг барих, засах ухаан, соёлын нийлбэр цогц мөн. Харин төр хэмээх ойлголт нь төр ёсны биежсэн хэлбэр, илрэх дүр төрх юм. Үүгээр эл хоёр ойлголтын нэгдэл хийгээд ялгааг тодорхойлно. Монголын төр ёс дорно дахины соёлын хүрээнд үүсвэрлэн хөгжиж, уламжлагдан боловсорчээ.

Дорнын деспот ёс

Дорнын төр ёсны онцлог шинж олон хүчин зүйлээр тодорхойлогддог боловч товойлгон үзмээр нэг зүйл бол азийн үйлдвэрлэлийн арга буюу нийгэм, эдийн засгийн амьдралд төрийн үүрэг ямагт өндөр байсан явдал юм. Үүнийг өрнийн судлаачид дорнын деспотизм гэж нэрлэдэг.

Монголын төр ёсны эх сурвалж

Монголын төр ёсны сэтгэлгээний объектив эх сурвалж нь төвлөрүүлсэн удирдлага, зохион байгуулалтыг шаардсан өргөн уудам газар нутаг, эрс тэс цаг агаар, уур амьсгал, газар дэх төрийн өмчлөл, малаар дамжуулж үр шимийг нь хүртэхэд илүү зохимжтой хөрс, ус, ургамлын аймгаас хамаарсан нийгмийн зохион байгуулалт, нүүдлийн аж төрөх ёс юм. Харин субъектив эх сурвалж нь байгаль, цаг агаар, нийгмийн зохион байгуулалт, монгол үндэстний дотоод мэдрэмж, итгэл бишрэлийг тусгасан монгол хүний сэтгэлгээний хэв шинж, уугуул төрх мөн.

Төрийн тухай ойлголт

Монголчууд төр гэсэн нэр томъёог европчуудаас өмнө хэрэглэж байсан гэсэн судалгааны дүгнэлт бий. Тэд төр гэдэг нэрийн дор бусад үндэстэн шиг ард түмэн, газар нутаг, түүн дээр тогтсон эрх мэдлийг ойлгож байсангүй. Харин тогтоосон ёс, ёс журам, хэв хэмжээг голчлон ойлгож байв.

Монгол төрийн үүсэл, хөгжил

Монгол төр ёсон Төв азийн өндөрлөгт оршин байсан Хүннү, Сүмбэ, Нирун зэрэг өвөг нүүдэлчин улсаас эх үндэстэй гэдэг нь өдгөө нэгэнт тогтоогджээ. Үүний хажуугаар монгол төр биежиж тогтсон үеийн тухайд нэг мөр дүгнэлтэд хараахан хүрээгүй байна. Нэг хэсэг судлаачид Хүннүгийн төрийг монголын анхны төр гэж үзсэн бол зарим нь Их монгол улсыг монгол төрийн анхны хэлбэр гэдэг.

Монгол төрийн хөгжил

Монголын хаант төрийг дараах байдлаар ангилна:

- язгуурын монголчуудын хаант төр бүрэлдсэн үе буюу Хамаг Монгол (барагцаалбал XII зуун);
- Их Монгол Улсын нэгдсэн хаант төр буюу эзэнт гүрний үе (1206-1368);
- Умард Юан улсын болон “бага хаадын” үеийн хаант төр (1368-1757);
- Богд хаант Монгол улсын хаант төр (1911-1924).

Ардчилсан төр бүрэлдэх үйл явц

Монгол төр ёсны түүхэнд анх удаа Үндсэн хууль бодитой оршихын хэмжүүр болсон хүний эрх, эрх чөлөө, төрийн эрх мэдэл хуваарилах онол, зарчмыг 1992 оны Үндсэн хуулийн үзэл баримтлал болгосон нь иргэний нийгэм, ардчилсан төр төлөвшин хөгжих улс төр, эрх зүйн үндэс болов. Монгол улсын шинэ Үндсэн хуулиар монголын төр хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн дээдэлдэг, иргэний нийгэмд үйлчилдэг, нийтлэг хуулинд захирагддаг төрийн эрх мэдлийг УИХ, Засгийн газар, Шүүхэд тэнцвэржүүлэн хуваарилсан байна.



Хяналтын асуулт

- ❖ Өрнө, Дорнын төр ёсны нийтлэг болон ялгаатай тал юу вэ? Монголын төр уламжлалын хувьд алинд нь илүү хамаарах вэ?
- ❖ Монголчуудын төр ёсны сэтгэлгээний объектив эх сурвалж юу вэ?
- ❖ 1992 оны Үндсэн хуулийг төр ёсны уламжлалтай холбон тайлбарлах бололцоотой юу?



Сорил

1. Монголд төр ёс хэдийнээс үүсэж, бүрэлдсэн бэ?
 - a. Хүннү, Сумбийн үеэс
 - b. Нирун, Уйгарын үеэс
 - c. Хамаг монголын үеэс
 - d. Богд хаант засгийн үеэс
2. Монголд ардчилсан төрийг тогтоох үйл хэрэг хэдийнээс эхэлсэн бэ?
 - a. Улс төрийн товчоо огцорсноор
 - b. Шинэ Үндсэн хуулийн төсөл боловсруулсан үеэс
 - c. Улс төрийн тогтолцоог өөрчилсөн үеэс
 - d. Эрх зүйн шинэтгэлийг эхлүүлснээр



Семинар 8. Монголын төрийн хөгжил

Харьцуулан шинжлэх арга
А. БОДОМЖ

Проф Н.Лүндэндорж	Проф Ж.Болдбаатар
Монголын төр эрх зүйн сэтгэлгээний хөгжил	Монголын төр, эрх зүйн түүхийн үечлэл
❖ Монголын эрх зүйн үзэл, сэтгэлгээний уг сурвалж ❖ Заншлын эрх зүйн үзэл, сэтгэлгээний үе ❖ Зүй ёсны эрх зүйн үзэл, сэтгэлгээний үе ❖ Манж-Чин улсын эрх зүйн нөлөөнд байсан үе ❖ Өрнийн эрх зүйн соёл, сэтгэлгээ нэвтэрсэн нь ❖ Социалист эрх зүйн сэтгэлгээний үе ❖ Орчин үеийн эрх зүйн сэтгэлгээний төлөвшил	❖ Монголын эртний үеийн төр эрх зүй (МЭӨШ-МЭХШ) ❖ Монголын дундад үеийн төр, эрх зүй (ХШ-ХХ) ❖ Монголын шинэ үеийн төр, эрх зүй (ХХ зууны эхээс-ХХ зууны эцэс) ❖ Монголын нэн шинэ үеийн төр, эрх зүй (1990 оноос хойшхи)



Анхаарах зүйл

- 1) Дээрхи судлаачид ямар онол, арга зүйг судалгаандаа ашигласан болохыг тайлбарлах
- 2) Дээрхи судлаачдын бичсэн эх зохиолтой сайтар уншиж, танилцах
- 3) Холбогдох бусад эх сурвалжтай харьцуулах замаар өөрсдийн дүгнэлтийг хийх
- 4) Дээрхи судлаачдын шинжлэх ухаанд оруулж буй хувь нэмрийг өөрсдийн байр сууринаас үнэлж цэгнэх

15. Төрийн хөгжил дэх түгээмэл хандлага

*Үндсэн хуульт ёс - ардчилал, эрх зүйт төрийн,
тулгын чулуу, төрт ёсны охь дээж мөн*

Ханс Иоахим Иенч (ХБНГУ-ын Үндсэн хуулийн шүүгч)

*Улам олон улс орон ардчиллын системийг хүлээн зөвшөөрөх болж,
ардчилал хүн төрөлхтний ирээдүйн давалгаа болж байна.*

Найжель Ашфорд (Английн Стафффордшир их сургуулийн профессор)

Жам ёсны эрх

Жам ёсны эрх нь хүмүүсийн бий болгосон(позитив) эрхээс давуу гэсэн үзлийг МЭӨ V зууны Грекийн түүхээс бид олж мэдэх болно. Чухам энэ л үеэс бурхан тэнгэр хүн бүрийг тэгш байхаар бүтээсэн бөгөөд хэнийг ч боол болгоогүй гэсэн үзэл санаа улбаатай. Эртний сэтгэгч Аристотель “Аливаа хууль нь нэгэн төрлийн эрхэд үндэслэж байдаг” гэж бичсэн байна. “Хэрэв тиймгүй бол хууль нь хэмжээгүй эрхт ноёрхлын хэрэгсэл болж хувирна” гэж тэрээр бичжээ. Түүний үзлийг цааш хөгжүүлсэн ромын хуульч Марк Туллий Цицерон “Жинхэнэ хууль гэдэг нь байгалийн хууль зүй тогтолд нийцсэн, хүн бүрт хамаатай, мөнхийн ухамсар юм” гэж тэмдэглэсэн нь бий.

Үндсэн эрх

Орчин үеийн үндсэн хуульт ёсны онолоор хүний жам ёсны эрх нь эрх зүйн үндсэн хэм хэмжээ хийгээд зарчмуудад зайлшгүй тусгалаа олсон байх ёстой. Ингэж байж гэмээнэ үндсэн эрх нь Үндсэн хуулиар хамгаалагдсан, төрийн эрх мэдлийг хязгаарлах хүчин чадалтай, шууд үйлчлэх эрх зүй болж чадна.

Үндсэн хуульт ёс

Үндсэн хууль нь иргэний үндсэн эрхийн бүхий л асуудлыг үүрд мөнхийн болгон баталгаажуулж өгсөн хэм хэмжээнүүдийн оргил, ардчилсан эрх зүйт төрийн суурь зарчмуудын бүрдэл юм. Үндсэн хуульт ёсны мөн чанар парламентын дур зоргоос хүний эрх, эрх чөлөө, Үндсэн хуулийн үзэл санааг хамгаалах явдал мөн.

Ард түмний эрхийг барих ёс

Төрийн үйл хэрэг дэх ард түмний оролцооны төвшин түүний хөгжлийн нэг гол шалгуур мөн. Аристотель “иргэн хүний гол шинжийг шүүх, төрийн эрх мэдэлд оролцож буй байдлаар тодорхойлно. Эрх чөлөө, тэгш ёс нь ардчиллын чухал лгганж хэдий ч төрийн удирдлагад оролцох оролцоонд тэр нь тусгалаа олдог” гэж тэмдэглэсэн нь одоо ч арга зүйн чухал баримтлал болсоор байна. Тийм учраас төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд ард түмнийг улам бүр татан оролцуулах нь төрийн хөгжлийн төвшинг харуулах төдийгүй, түүний хөгжлийн нэгэн түгээмэл хандлага, тэргүүлэх чиглэл хэвээр байна.



Хамгийн бага оролцоо бүхий төр

Хувь хүмүүс эрхээ хамгаалуулахын төрийг бий болгодог. Лорд Эктоны хэлсэнчлэн "аливаа эрх мэдэл хүнийг эвддэг бол хязгааргүй эрх мэдэл хүнийг хязгааргүй эвддэг". Иймд хүмүүс эрх мэдлийг задалж, хязгаарлахыг хүсдэг. Үүнийгээ тэд өөрийн хүнийг төрд сонгож, эрх мэдлийг хязгаарласан Үндсэн хууль бий болгох замаар хэрэгжүүлдэг.



Хяналтын асуулт

- ❖ Үндсэн хуульт ёсны мөн чанар нь үндсэн хуулийг дээдлэхийг хэлж байна уу эсвэл түүнийг хамгаалдаг тусгай шүүхтэй байхыг хэлж байна уу? Үндсэн хуулийн шүүхгүйгээр Үндсэн хуулийг дээдэлж болох уу? Аль нь хамгийн чухал вэ?
- ❖ Төрийн эрхмэдлийг хэрэгжүүлэхэд ардтүмний оролцоо өсөн нэмэгдэж байгаагийн илрэл юу вэ? Монгол улс дахь нэг жишээг хэлнэ үү. Дэлхийн бусад оронд энэ нь тийм түгээмэл болсон үзэгдэл мөн үү. Гол ач холбогдол нь юу бол? Ард түмнийг төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэхэд аль болохоор өргөн оролцуулахын тулд юу хийх хэрэгтэй вэ? Өөрийн орны жишээн дээр эргэцүүлэн бодож саналаа хэлнэ үү.
- ❖ Төрийн хөгжилд даяаршилын зэрэгцээ дангааршил явагдаж байгаагийн шалтгаан, хүчин зүйл юу вэ? Ихэнх судлаачид соёлын хүчин зүйлтэй холбоотой гэжээ. Энэ үзлийг дэмжиж байгаа бол өөрийн үндэслэлийг дэвшүүлнэ үү.



Сорил

1. Үндсэн эрх бол ... мөн.
 - a. Негатив эрх
 - b. Позитив эрх чөлөө
 - c. Үндсэн хуулиар хамгаалагдсан жам ёсны эрх
 - d. Хуульчлагдсан эрх
2. "Laissez - faire" зарчим аль төрд илүүтэй хамаарах вэ?
 - a. Буянлаг төр
 - b. Эрх зүйт төр
 - c. Социалист төр
 - d. Хамгийн бага оролцоо бүхий төр
3. Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө нь:
 - a. Позитив эрх
 - b. Негатив эрх
 - c. Жам ёсны эрх
 - d. Материаллаг эрх

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

Монгол хэлээр:

1. Алексеев С.С, Төр ба эрх зүй, Орч. Батчулуун Б, Бахдал Г, УБ, 2004
2. Аристотель, Улс төр, Орч. Даш-Ёндон Б, УБ, 2003
3. Батчулуун Б, Посмсоммунист нийгэм дэх төр, иргэний харилцаа, УБ, 2003
4. Вебер М, Улс төр бол мэргэжил мөн. Шинжлэх ухаан бол мэргэшил мөн, Орч. Нямдорж Ү, УБ, 2000
5. Вольф Ж, Улс төрийн философийн удиртгал, Орч. Батчулуун Б, УБ, 2002
6. Мизес Людвиг фон, Либерализм, Орч. Чойжил П, УБ, 2004
7. Нарангэрэл С, Монголын ба Дэлхийн эрх зүйн тогтолцоо, УБ, 2001
8. Нарангэрэл С, Лүндэндорж Н, Эрх зүй судлалын удиртгал, УБ, 2004
9. Руссо Жан Жак, Нийгмийн гэрээ ба улс төрийн эрхийн зарчмууд, Орч. Янжмаа Р, УБ, 2002
10. Сарантуяа Ц, Төрийн ерөнхий онол, УБ, 1998
11. И.Найжел Ашфорд. Чөлөөт нийгмийн үндсэн зарчмууд. Орч. М.Батсуурь, Ч.Өнөрбаяр, УБ., 2007

Орос хэлээр:

1. Алексеев С.С, Государство и право, Начальный курс, М, 1994
2. Бруннер Г, Хёфер Ф, Государственное и административное устройство Германий, Мюнхен, 1994
3. Гоббс Т, Соч, в 2-х т, Т. 2. М, 1992
4. Гроций Гуго, О праве войны и мира, М, 1956
5. Даль Р, О Демократий, Перевод с англ, М, 2000
6. Кашанина Т.В, Происхождение государтсва и права, М, 2004
7. Монтескье Ш, Избранные произведения, М, 1955
8. Нерсисянц В.С, Общая теория права и государства, М, 2000
9. Платон, Филеб, Государство, Тимей, Критий, М, 1999
10. Романов А.К, Правовая система Англий, М, 2000
11. Хрестоматия по истории государства и права зарубежных стран, М, 1984
12. Шершеневич Г.Ф, Общая теория права, Т. 1, М, 1995

Англи хэлээр:

1. Cohen Jean L, Aroto Andrew, Civil Society and Political Theory, The MIT Press, Cambridge, Massachusetts, and London, England, 1992
2. Cormick D.Neil Mac, Rechtsstaat and Rule of law, The Rule of law, Edited by Josef Thesing, 1997
3. Dahl R.A, On Democracy, Yale University, Press, New & London
4. Freeman M.D.A, Introduction to Jurisprudence, London, 2001
5. Fuller L, The Morality of Law, New Heaven, Revised edition, Yale University press, 1964
6. Hobbs Thomas, Leviathan, ch. XXVI



7. Locke John, The Second Treatise on Government (1690), Indianapolis: Naskett, 1980, chap. 7
8. Lundendorj N, Common and unique features of Eastern and Western states, Centre for Asian and Pacific Law in the University of Sydney, Oct. Edition, 1996, N 5
9. Montesquieu, The Spirit of the laws, 1748, N.Y narpers, 1949, I (3)
10. Nozic R, Anarchy, State and Utopia, Basil Blacwell, Oxford, 1974
11. Oxford Dictionary of Law, Edited by Elizabeth A. Martin, Oxford University Press, 2001
12. Service E, Primitive Social Organization, New York, Radmon House, p.103, 132-169, Origins of the State and Civilization, N.Y, Norton,
13. Siegan B, Separations of Powers and other Divisions of Authority under the Constitution, Suffolk University Law Review, 1989, №1

Герман хэлээр:

1. Mohl R. Von, Enzyklopadie der Staatwissenschaften, 1872,
2. Mommsen, Abria des remischen Staatsrechts, 1893
3. Radbruch Gustav, Rechtsvergleichende Schriften, bearbeitet von Heinrich Scholler, Miller C.F, Verlag, Heidelberg, 1999
4. Restauration der Staatwissenschaften, I
5. Stahl, Staatsrechtstehre auf der Grundlage der christlichen Weltanschauung, Heidelberg, 1856